Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 04 сар. №006 (016) www.mongolianeconomy.mn

Орой унтаж, эрт босох малч ухаан

Улстөрчид ногооноор сэтгээд ирэхээр улс төрийн хүсэл эрмэлзлэл бий болно

Эрэлт, нийлүүлэлтийн уулзвар хаана вэ



Challenger®

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮЧИРХЭГ ХАМТРАГЧ



“CHALLENGER” нь цаг агаарын эрс тэс өөрчлөлттэй,хүйтэн сэрүүн бүс нутгуудад ажиллахаар бүтээгдсэн байдаг бөгөөд Монгол улсын зах зээлд “Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК анхлан таниулаад удаагүй байна. Хүнд машин, тоног төхөөрөмжийн худалдааны салбарт зөвхөн “оруулж ирээд – зарах” гэдэг ойлголт орчин цагт алга болж байна. Машин механизмаа дагаад түүний сэлбэгийн хангамж - агуулах, засварын үйлчилгээ, засварын төв, түүнийг ажиллуулах операторын сургалт, дуудлагын засварын инженерүүд, мөн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх лизингийн үйл ажиллагаа зэрэг бүгд багтсан, таны бизнесийг бүрэн дүүрэн дэмжих ОРЧИН ЦАГИЙН ХУДАЛДААГ бид ХАА -н салбарынханд санал болгож байна.

Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК
Баянгол дүүрэг, Баруун Үйлдвэр-133, Ш/х-26, Улаанбаатар-16030, Монгол Улс
Утас: 976-687588, 99013673 Факс: 976-11-687587
www.wagnerasia.com

WAGNER ASIA EQUIPMENT LLC CAT

FUTURE MONGOLIA

INTERNATIONAL TRADE FAIR AND CONFERENCE FOR SUSTAINABLE DEVELOPMENT

МОНГОЛД анх удаа олон улсын стандартын өндөр зэрэглэлийн үзэсгэлэн худалдаа

БУЯНТ-УХАА СПОРТ ЦОГЦОЛБОРТ 2012.05.16-05.19

Дараах чиглэлүүдэд бизнес эрхэлдэг гадаад дотоодын аж ахуйн нэгжүүд **FUTURE MONGOLIA** үзэсгэлэн худалдаанд бүтээгдэхүүнээ танилцуулах, түүний хүрээнд явагдах хурал, зөвлөгөөнд оролцохыг урьж байна.

- Уул уурхайн болон барилгын машин, тоног төхөөрөмж
- Хөдөө аж ахуйн болон байгаль орчны техник
- Тээвэрлэлт, төмөр замын техник
- Эрчим хүчний техник, технологи
- Банк санхүүжилт, даатгал
- Эрүүл мэнд болон боловсрол, харилцаа холбоо

Зохион байгуулагч:

Дэмжигч байгууллагууд:

MINISTRY OF MINERAL RESOURCES AND ENERGY

MINISTRY OF ROAD TRANSPORTATION, CONSTRUCTION AND URBAN DEVELOPMENT

MINISTRY OF FOREIGN AFFAIRS AND TRADE OF MONGOLIA

MINISTRY OF FOOD AGRICULTURE AND LIGHT INDUSTRY

KINDLY SUPPORTED BY THE CITY OF ULAANBAATAR

THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA

Mining Journal

MONGOLIAN ECONOMY

www.future-mongolia.com Contact: info@future-mongolia.com,
Tel: + 976 7015 5075, + 976 7011 6240 ,+976 9910 5076

KHATAN TUUL

Pure Water



Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /balloon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

Produced and bottled by " Welmon Trade " Co.,Ltd of Mongolia

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор: Terrence Edwards
Орчуулагч: Б.Үүрийнтуяа
Сэтгүүлчид: Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Уганбаяр
Б.Энхмарт

Дизайнер, Вэб мастер: Ш.Оюундарь

Маркетингийн менежер: Д.Барианжав 88800825
С.Жавхлан 99620780
Б.Энхцэцэг 99015476

Борлуулалтын менежер: С.Цэнд-Аюуш

"Economy" ТВ студи
Дэд захирал: Ц.Буянбат 88112885
Зураглаач: Ц.Бат-Отгон
График дизайн Г.Буянбааатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

MONGOLIAN ECONOMY

14 хоног тутамд танд хүрнэ

II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

ЗАХИАЛГЫГ:

"Монгол шуудан"
"Түгээмэл шуудан"
"Sky" шуудан
"UB Post" шуудангийн салбарууд болон сэтгүүлийн редакцид авч байна.

Утас: 7011-5476
8880-0825


Агуулга

Эрэлт, нийлүүлэлтийн уулзвар хаана вэ



Монголдүлхөдлөххөрөнгийн үнийн хөөс олон шалтгаанаас болоод дарагдах биш, улам бүр томорсоор байгаа нь иргэдийн байртай болох мөрөөдлийг үлгэр болгож ч мэдэх өндөр эрсдэлийг үүсгэж буй юм. ..9

Малтай монгол махгүй өлсөх үү



Манай мал сүргийн тоо толгой өнгөрсөн онд гэхэд л 36 саяд хүрч, нэг хүнд ногдох малын тоогоороо дэлхийд эхний аравт багтаж байна...16

Орой унтаж, эрт босох малч ухаан



Дөрвөн настай отгон охин Хонгорзул нь хонь мал, хот хороотой ойр өсөж байгаа болоод ч тэр үү биедээ ахадсан хэрсүү зантай. Түүнийг гэрийнхэн нь хургачин Хонгороо гэж хочилдог...20

Эдийн засаг

8 Үнийн хөөс

9 Эрэлт, нийлүүлэлтийн уулзвар хаана вэ

12 Орон сууцны зах зээлийн мэдээлэл

14 Л.Туяа: Хүмүүст тусалж мөнгө олно гэдэг сайхан шүү дээ

16 Малтай монгол махгүй өлсөх үү

20 Орой унтаж, эрт босох малч ухаан

22 Өртэй, өргүйн хооронд

25 Маркс философич уу?, эдийн засагч уу?

28 Б.Бямбасайхан: Мөрөөдлөө зорилго болгож, түүндээ хүрэх хариуцлага биднийх

32 Маркетингаас хүмүүнлэг рүү

Ногоон эдийн засаг

33 Улстөрчид ногооноор сэтгээд ирэхээр улс төрийн хүсэл эрмэлзлэл бий болно

38 Оюутолгой усны асуудлаа яаж шийдсэн бэ

Бизнес

40 Хамгийн оновчтой шийдэл бүхий зөвлөгөө

41 Та ямар ном уншиж байгаа вэ?

Өртэй, өргүйн хооронд



Тавантолгойн орд газрын үнэт цаасыг иргэд гартаа атгах цаг ойртож байгаа ч үйл ажиллагааны хувьд тус ордыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй бололтой...24

Б.Бямбасайхан: Мөрөөдлөө зорилго болгож, түүндээ хүрэх хариуцлага биднийх



Манай компанийн хамгийн сүүлд хийж буй томоохон ажлын нэг гэвэл цэвэр эрчим хүчний салбар дахь их бүтээн байгуулалтыг нэрлэж болох юм...28

Хамгийн оновчтой шийдэл бүхий зөвлөгөө



Хуульч бидний үндсэн чиг үүрэг бол үйлчлүүлэгчийнхээ бизнесийг эрсдэлээс хамгаалахад чиглэдэг... 40

http://www.mongolianeconomy.mn

Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдлын өнгөрөгч хоёрдугаар сарын мэдээг хүргэж байна.

Өрхийн орлого:

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны дөрөвдүгээр улирлын судалгааны дүнгээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 555.4 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 134.7 мянган төгрөг буюу 32.0 хувиар нэмэгджээ. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2011 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 548.9 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 104.3 мянган төгрөг буюу 23.5 хувиар өссөн байна.

Ажилгүйдэл:

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны хоёрдугаар сарын эцэст 58.4 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.9 мянган хүнээр буюу 51.6 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалд 2012 оны эхний хоёрдугаар сард 406.5 мянган хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгджээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 77.2 мянгаар нэмэгдсэн байна.



Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны эхний хоёрдугаар сард 53.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.8 хувиар өсчээ. Түүнчлэн “Хүний хөгжил” сангаас 2012 оны эхний хоёрдугаар сард 119.0 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.8 сая иргэнд олгосны 98.3 хувь нь 21.0 мянган төгрөг, 0.9 хувь нь 70.0 мянган төгрөг, 0.8 хувь нь 10.0 мянган төгрөг бэлнээр авсан байна.

Эрүүл мэнд:

Халдварт өвчнөөр 2012 оны эхний хоёрдугаар сард 7220 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 987 хүн буюу 15.8 хувиар нэмэгдсэн байна. Цусан суулга, сүрьеэн өвчлөл буурсан хэдий ч тэмбүү, трихомониаз, салхин цэцэг, вируст хепатитээр өвчлөгсдийн тоо өссөн нь халдварт өвчний дээрх тоонд нөлөөлжээ.

Төрөлт:



Улсын хэмжээнд 2012 оны эхний хоёрдугаар сард 11579 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 1320 эх буюу 12.9 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 11631 болж, 1338 хүүхэд буюу 13.0 хувиар өссөн байна.

Банк санхүү:

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны хоёрдугаар сарын эцэст 176.3 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 102.5 тэрбум төгрөг буюу 2.3 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 63.7 тэрбум төгрөг буюу 56.6 хувиар өсчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны хоёрдугаар сарын эцэст 323.3 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 3.3 тэрбум төгрөг буюу 1.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 37.1 тэрбум төгрөг буюу 10.3 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа дээрх хугацаагаар 2.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 7.2 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Улсын төсөв:

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны эхний хоёр сард 674.8 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 682.1 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 7.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Эргэж төлөгдөх цэвэр зээл 2.0 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар буурсан хэдий ч хөрөнгийн зардал 89.3 тэрбум төгрөг буюу 4.1 дахин, татаас, шилжүүлгийн зардал 88.6 тэрбум төгрөг буюу 38.4 хувь, бараа, үйлчилгээний зардал 34.8 тэрбум төгрөг буюу 18.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Татвар:

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 160.8 тэрбум төгрөг буюу 37.2 хувиар өсөхөд бусад татварын орлого 59.1 тэрбум төгрөг буюу 2.3 дахин, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 56.3 тэрбум төгрөг буюу 35.2 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 30.3 тэрбум төгрөг буюу 60.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 14.9 тэрбум төгрөг буюу 46.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 44.6 тэрбум төгрөг буюу 2.3 дахин өсөхөд төсөвт газрын өөрийн орлого 16.4 тэрбум төгрөг буюу 76.3 хувь, хувьцааны ногдол ашгийн орлого 10.2 тэрбум төгрөг, бусад нэр заагдаагүй орлого 7.5 тэрбум төгрөг буюу 3.6 дахин, газрын тосны орлого 4.7 тэрбум төгрөг буюу 4.3 дахин, хүү, торгуулийн орлого 4.3 тэрбум төгрөг буюу 2.2 дахин өсжээ.

Гадаад худалдаа:

Монгол Улс 2012 оны эхний хоёрдугаар сард дэлхийн 103 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1469.3 сая ам.доллар, үүнээс экспорт 529.9, импорт 939.3 сая ам.долларт тус тус хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны хоёрдугаар сард 60.2 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2012 оны хоёрдугаар сард 154.8 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 94.6 сая ам.доллар буюу 2.6 дахин өсөв.

Экспортын 97.7 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

http://www.mongolianeconomy.mn

Аж үйлдвэрлэл:

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний хоёрдугаар сард 287.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 20.6 тэрбум төгрөг буюу 7.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, металл агуулгаараа, молибдений баяжмал, цайрын баяжмал, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.4-77.3 хувь, архи, ариун цэврийн цаас, зүсмэл материал, хивс, шар айраг, шингэн сүү, нарийн боов, талх, амтат ус, ундаа, шахмал түлш, бетон зуурмаг зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.1 хувиас 7.9 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Ачаа эргэлт:



Төмөр замын тээвэрээр 2012 оны эхний хоёрдугаар сард 3263.0 мянган тонн ачаа, давхардсан тоогоор 609.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 674.0 мянган тонн буюу 26.0 хувь, зорчигчдын тоо 37.3 мянган хүн буюу 6.5 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны эхний хоёрдугаар сард 68.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.8 тэрбум төгрөг буюу 47.3 хувиар өсөв.

Агаарын тээвэрээр 2012 оны эхний хоёрдугаар сард 553.7 тонн ачаа, давхардсан тоогоор 94.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 301.6 тонн буюу 2.2 дахин, зорчигчдын тоо 28.4 мянган хүн буюу 43.1 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны эхний хоёрдугаар сард 22.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.0 тэрбум төгрөг буюу 22.4 хувиар өссөн байна.

Уул уурхай:

Чулуун нүүрс нийт экспортын 34.6 хувийг эзэлж байна. Манай улс эхний хоёрдугаар сарын байдлаар 529.9 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 27.4 хувь буюу 114.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.Мөн хугацаанд нийт экспортын 34.6 хувийг чулуун нүүрс, 24.1хувийг зэсийн баяжмал, 16.2 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 8.9 хувийг боловсруулаагүй нефть тус тус бүрдүүлж байна. Тус хугацаанд “Бороо гоулд” ХХК 315.0 кг алт Канад улсад экспортолсон байна.


Хөдөө аж ахуй:

Манай улс өнгөрсөн оны эцэст 36,3 сая толгой мал тоолуулснаас 15,6 сая толгой нь төллөх насны мал байна. Өнгөрсөн сарын 20-ноос орон даяар мал төллөлт жигдэрч, нийт хээлтэгч малын 13 хувь нь төллөж, 2000 орчим төлтэй болоод байна. Шинэ төл 99 хувьтай эрүүл бойжиж байгаа гэсэн мэдээг ХХААХҮЯ-наас гаргажээ.

Үнэ ханш:

Үндэсний статистикийн хорооноос Улаанбаатар хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг гуравдугаар сарын 21-ний байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 4.6 хувиар өссөн байна.

Мөн дээрх үнийн судалгааг сараар хийгээд зогсоогүй бүтээгдэхүүн тус бүр дээр өмнөх долоо хоногтой нь харьцуулж гаргажээ. Тиймээс цагаан будаа, элсэн чихэр, төмс гурвын өнгөрсөн сарын 21-ний дундаж үнийг өмнөх долоо хоногтой нь харьцуулсныг Та графикаас сонирхоорой. ■





Эдийн засаг



Шог зургийг А.Амарсайхан

Онцлох сэдэв

Үнийн хөөс

И.Отгон

Махны үнийн өсөлт гаарсан инфляцийг улам бүр галзууруулсаар. Инфляцийг ногтлохын тулд Монголбанк бодлогын хүүгээ өсгөж, Мөнгөний бодлогыг чангаруулсаар байгаа ч тусыг эс олж байна. Үндэсний статистикийн хорооны өнгөрөгч хоёрдугаар сард гаргасан судалгаагаар инфляци улсын хэмжээнд жилийн 12.5 хувь, Улаанбаатар хотод 13.3 хувьд хүрчээ. Төвбанк инфляцийг бүтэн жил онилоод ч хүчин мөхөстөж буй нь илт. Монголчуудын дотоодын хэрэгцээгээ зуун хувь хангадаг цөөн тооны бүтээгдэхүүний нэг нь мах. Гэтэл махны үнийн өсөлт өнгөрсөн өвлөөс эхэлж чихнээс хонх уясаар өнөөдөр хотын зарим хүнсний зах, дэлгүүрт нэг килограммын үнэ хэдийнэ 8500-9000 төгрөгт хүрэв. Итгэхэд ч бэрхтэй.

Махны үнийн өсөлт монголчуудын хувьд шинэ зүйл биш. Жил бүрийн хавар өсөж л байдаг. Өслөө өслөө гэхдээ сайн чанарын үхрийн мах дээд тал нь нэг кг нь 5000 төгрөгөөс нэг их хол давдаггүй байсан билээ. Тэр үед “Мах худалдаж авч чадахгүй хоосон хоногдоо хүрч байна” гэж бухимдаж байсан нийслэлчүүд өдгөө өмнөх оны мөн үеийнхээсээ бараг хоёр дахин өндөр үнэтэй мах идэхдээ тулаад байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ оны эхнээс 29.6 хувиар өсч, нийслэл хотын эхний хоёр сарын инфляцийн 58 хувийг дангаараа бүрдүүлсэн байх жишээтэй. Монгол Улс мал аж ахуйн орон гэдгээрээ дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн. Өнгөрсөн оны төгсгөлд манайх 36.3 сая толгой мал тоолуулснаас 15.6 сая нь хээлтэгч гэсэн статистик ч бий. Гэтэл малтай монгол махныхаа үнэд зохицуулалт хийж чадахгүй, өлсөөд суух гэж үү. Энэ нь үнэн инээдтэй хийгээд эмгэнэлтэй хэрэг юм. Энэ талаар Та манай сэтгүүлчийн бичсэн “Малтай монгол махаар өлсөх үү” гэсэн нийтлэлийг уншаарай.

Махны үнэ монголчуудын толгойг өвтгөж байгаа бол сүүлийн саруудад огцом дээшилсэн орон сууцны ханш Засгийн газрын “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдаж байртай болох гэсэн хүмүүсийн сэтгэлийн шаналан болж байна. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлд сар, улирал тутамд дүн шинжилгээ хийдэг “Мастер пропертис” компанийн өнгөрөгч хоёрдугаар сард гаргасан судалгаагаар Улаанбаатар хотод шинээр баригдаж байгаа орон сууцны ам метрийн үнэ дунджаар 1,6 сая төгрөгийн ханштай гарчээ. Энэ нь өмнөх сараас 1,59 хувиар, өмнөх оны мөн үеэс 38,13 хувиар тус тус өссөн үзүүлэлт аж. Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн олон хүчин зүйлээс шалтгаалж байдаг орон сууцны үнийн хөөс дарагдах биш, улам томроход олон нийт Засгийн газрын бага, дунд орлоготой иргэдэд зориулсан зургаан хувийн хүүтэй орон сууцны зээлийн шийдвэр гол “буруутан нь” хэмээн үзэж буй.

Түүнчлэн шатахуун болон хүнсний бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн талаас илүү хувийг бүрдүүлээд байгаа тухай статистик бас бий. Хаа сайгүй л үнийн хөөс. Эрэлтээс үүдэлтэй үнийн гэрэлтсэн бөмбөлөг хэзээ хагарахыг хэлж таашгүй. ■

http://www.mongolianeconomy.mn

“100 мянган айлын орон сууц” хөтөлбөр

Эрэлт, нийлүүлэлтийн уулзвар хаана вэ

Б.Санжааханд

Монголд үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөс олон шалтгаанаас болоод дарагдах биш, улам бүр томорсоор байгаа нь иргэдийн байртай болох мөрөөдлийг үлгэр болгож ч мэдэх өндөр эрсдэлийг үүсгэж буй юм. Тухайлбал, Засгийн газрын “100 мянган айл орон сууц” хөтөлбөр үүнийг гэрчлэх нэгэн жишээ. Хоёр жилийн өмнө УИХ-аас тус хөтөлбөрийг баталж, өнгөрсөн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан. Харин луу жилийн босгон дээр жилийн зургаан хувийн хүүтэй, 50,0 сая хүртэл төгрөгийн зээл олгох тухай Засгийн газар чихэнд чимэгтэй шийдвэр гаргав. Анх удаа орон сууцтай болох бага, дунд орлоготой иргэдэд энэ зээл илүү чиглэх ёстой гэж холбогдох албаны том дарга нар ярих нь “Хэзээ ч гэр хорооллын үнс, шороноос ховхрохгүй байх даа” гэсэн гутранги үзэлтэй иргэдийн ч магнайг тэнийлгэхээр сайхан мэдээ байлаа. Дээрх шийдвэр хэдий батлагдаад хоёр жил болсон ч хэрэгжилт нь удаашралтай байсан “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн нэр хүндийг ч сөгийтөл өргөв. Сайн шийдвэрийн тусгал нь гялалзсан үр дүн байх учиртай. Тэгвэл зургаан хувийн хүүтэй, шинээр авах байр нь барьцаа хөрөнгө болно гэдэг утгаараа хүмүүсийг хуйлруулсан зээлийн шийдвэр гарч, хэрэгжиж байгаа нь хот, хөдөөгөөрөө талцаж, гэр хороолол, орон сууцанд амьдардгаараа ялгарах нь ихэссэн өнөөгийн нийгэмд ямархан гэрэл гэгээ татуулах бол оо.

Монголын төр, засгийн зүгээс ард түмэндээ гологдохоор харалган шийдвэр, дутуу дулимаг бодлого явуулах нь бишгүй бий. Гэхдээ агаарын бохирдлыг багасгах хамгийн оновчтой шийдэл гэдэг үүднээсээ ч тэр үү, орон сууцжуулах бодлогыг нэлээд зөв, зоригтой эхлүүлж байгааг хэн хүнгүй сайшаан ярилцаж байна. “100 мянган орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтэд алдаа оноо бий ч жилийн зургаан хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай орон сууцны зээл олгох шийдвэрийн тухайд үнэхээр эрэмгий зориг гаргаж байгаа нь олон талаар харагдаж буй. Орон сууцны зээл олгох нь хамгийн эрсдэл багатайд тооцогддог учраас өнөөдөр Монголын арилжааны банкууд моргэйжийн чиглэлд өрсөлдөж, 20-30 жилийн хугацаатай 100 хүртэл сая төгрөгийн зээл олгохоор байгаа ч хамрагдах иргэдийн тоо харьцангуй цөөхөн. Жилийн 15-24 хувийн хүүтэй, 40-50 хувийн урьдчилгаа төлөх босго өндөртэй арилжааны банкны зээлд иргэд хамрагдах санаа байвч сачий нь хүрэхгүй. Бага, дунд орлоготой гэх гэр хорооллынхны хувьд ийм зээл сонирхож арилжааны банк руу зүглэхийн ч хэрэггүй. Үүнтэй харьцуулахад “100 мянган орон сууцны” жилийн зургаан хувийн хүүтэй зээлд хамрагдана гэдэг үнэхээр их хувь заяа. Мэргэжлийн байгууллагынхны орон сууцны зээлийн шинжилгээ гэж нэрлэдэг бяцхан тооцоог хийгээд үзэхэд л ялгаа нь харагдаж хорхой гозолзуулна.

Арилжааны банкны моргэйжийн зээлд хамрагдсан хүн 30 жилийн хугацаатай зээл авлаа гэхэд сардаа хамгийн багадаа 560,000-600,000 төгрөгийн зээл төлөх болно. Гэтэл зургаан хувийн хүүтэй зээлийн шинжилгээг хийж үзэхэд сардаа 350 гаруй мянган төгрөг төлөхөөр байгаа юм. Гэвч бага, дунд орлоготой иргэдээ бодсон энэхүү төрийн хишиг нэг талаас угаасаа хөөс ихтэй Монголын орон сууцны зах зээлийн үнийг огцом хөөрөгдөж орхив. Ингэснээрээ төр хайр ивээлээ үзүүлэх гэсэн бага, дунд орлоготой иргэдийн хөтөлбөр нь эзэндээ наалдацгүй их эрэлт, үнийн өсөлт болон хувирсан талтай.

Танайд шинэ хүн мэндэлсэн үү?

Өнөөдөр орон сууцны үнэ иргэдийн толгойг өвтгөж байна. “Мастер пропертис” компаниас гаргасан Улаанбаатар хотын шинэ, хуучин орон сууцны өнгөрөгч хоёрдугаар сарын судалгаанаас үзэхэд орон сууцны нэг ам метр талбайн үнэ дунджаар 1,649,191 төгрөг байгаа ажээ. Энэ нь өмнөх сарынхтай харьцуулахад 1,59, өмнөх оны мөн үеэс 38,13 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.

“Хонх нь дуугарахаар дамар нь таг” гэдэг шиг л зүйл болж байгаа нь энэ. Иргэдийн удтал хүлээсэн “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилт сайжирч, зургаан хувийн хүүтэй зээлийн шийдвэр гарангуут барилгын үнэ огцом өсөв. Тус зээлтэй холбоотойгоор сүүлийн хоёр сарын дотор орон сууцны үзэсгэлэн худалдаа ойр ойрхон зохион байгуулсан ч иргэдийн боломжийн нөхцөлөөр байртай болох »



http://www.mongolianeconomy.mn

гэсэн сэтгэлийн нарыг орон сууцны өндөр үнийн сүүдэр халхлах нь тэр. Монголд өнөөдөр орон сууцны зах зээлийн мэдээллийг түлхүү хүргэдэг “Барилга.mn”, “Тэнхлэг зууч” гэсэн үл хөдлөх хөрөнгө зуучийн байгууллага байдаг. Гэхдээ мэргэжлийн судлаачдын баг ажиллуулан мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг ганц байгууллага нь одоогоор “Мастер пропертис” компани юм. Тийм болохоор манай сэтгүүл тус байгууллагын өнгөрөгч хоёрдугаар сарын болон дөрөвдүгээр улирлын тайланг үндэслэж орон сууцны зах зээлийн үнэ ханшийн мэдээллийн нүүр болон нийтлэл бэлтгэн хүргэж байна.

Орон сууцны үнийн өсөлтөд зургаан хувийн хүүтэй орон сууцны зээлийн шийдэр нөлөөлсөн гэж олон нийт үзэж байгаа билээ. Тэгвэл энэ мэдээллийг “Мастер пропертис” компанийн Маркетингийн албаны захирал Д.Моломжамцаас лавлахад “100 мянган айлын орон сууц хөтөлбөрийн хэрэгжилт идэвхжсэн байдал шууд нөлөөлсөн гэж үзэж болохгүй. Зах зээлийн дагуу л өсөлт явж байна. Байршлаасаа хамаарсан үнийн өсөлт их байна. Орон сууцны үнэд эрэлт, нийлүүлэлтийн олон хүчин зүйл нөлөөлж байдаг. Тухайлбал, эрэлт талаасаа ипотекийн зээл, эдийн засгийн идэвхтэй хүн амын өсөлт, орлогын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хэрэглээнд гарах өөрчлөлт, тэрбитгий хэл гэрлэлт, гэр бүл салалт ч нөлөөлөх хүчин зүйл болдог. Мөн нөгөө талын буюу нийлүүлэлтийн хүчин зүйлст барилгын материалын үнийн өсөлт, дэд бүтэц, Замын-Үүд боомтын хүчин чадал зэрэг орно” гэв.

Хэдийгээр судалгааны байгуулагынхан орон сууцны үнийн огцом өсөлтөд Засгийн газрын моргэйжийн зээлийг буруутгахгүй байгаа ч зах зээлд болсон үйл явдлын өрнөлөөс сэтгүүлчийн нүдээр ажиглаж дүгнэж болох юм. Засгийн газрын шийдвэртэй холбоотой нийлүүлэлтээс давсан огцом эрэлт бий болсон нь үнэд нөлөөлсөн байх талтай. Үүнийг орон сууцны үзэсгэлэн худалдааны үеэр зохион байгуулагчдын зүгээс ч худалдан авагчдын зүгээс ч онцлон хэлж байсан. Нэг үгээр хэлбэл, “100 мянган орон сууц”-ны зургаан хувийн зээл хэрэгжсэнээрээ нүд ирмэхийн зуурт нэг талд оволзсон эрэлт, нөгөө талд олз хайсан борлуулалтыг бий болгосон гэж хэлж болно. Тэгвэл Засгийн газар ард түмнээ баярлуулсан дээрх шийдвэрийг гаргахдаа орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хэрхэн тооцсон байж таарах вэ? Орон сууцжуулах тухай багагүй ярьдаг ч эрэлт, нийлүүлэлтийн тухай тодорхой мэдээлэл төр, засаг болоод иргэдийн хувьд хаана хаанаа хомс байгаа юм.

Орон сууцны эрэлт нийлүүлэлтийн талаарх мэдээлэл хомс үед уншигч танд сонирхолтой баримт эхлээд хүргэе. Танай ам бүлд шинэ хүн мэндэлж, ах дүү, хамаатан саданд чинь залуус туурга тусгаарлаж, эсвэл гэр бүл салахад хүрэхэд тэр тоолон орон сууцны эрэлт нэмэгдэж байдаг ажээ. “Өрхөд шинэ төрөх хүүхдийн тоо хоёр ба түүнээс дээш нэмэгдэхэд орон сууцны эрэлт нэг нэгжээр, гэрлэлт дунджаар таваар нэмэгдэхэд орон сууцны эрэлт нэг нэгжээр, иргэдийн дундаж цалин 130 мянган төгрөгөөр нэмэгдэхэд орон сууцны эрэлт нэг нэгжээр, шилжилт хөдөлгөөн таван хувиар нэмэгдэхэд орон сууцны эрэлт нэг хувиар тус тус нэмэгддэг гэсэн судалгаа байдгийг судлаачид сонирхуулж байв. Зургаан хувийн зээлтэй холбоотой Орон



http://www.mongolianeconomy.mn

сууцны санхүүжилтийн корпорацийн Зээлийн газрын захирал М.Уламбаяр “Хөтөлбөр батлагдсанаас хойш зөвхөн манай байгууллага л гэхэд өдөрт 50-70 заримдаа 100 гаруй иргэнд мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлж байна” хэмээсэн. Мөн тэрбээр “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр 2016 оныг дуустал үргэлжлэх учраас иргэд яарч сандрах хэрэггүй. Өөрсдийн боломжтой цагт, насаараа амьдрах орон сууцаа сайн судалж сонгосны үндсэн дээр бичиг баримтаа бүрдүүлээд ирж болно” гэж их хүсэлдээ дийлдсэн иргэдийн яарсан сэтгэлийг нь тайвшруулах үг хэлэхээ мартаагүй. Орон сууцны үнийн өсөлтийн талаар албаныхны бодлыг сонирхоход, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү “Ирэх жил орон сууцны хөтөлбөр эхлэхээр байрны үнэ нэмэгдэнэ. Тэгэхээр үнэ оруулж зарна гээд иргэд оны өмнө банкны хадгаламжид байсан мөнгөө аваад байр ихээр худалдаж авах хандлага хүчтэй явагдсан байсан. Нэг гэр бүлийн иргэд нийлээд 50 байр худалдаж авсан тохиолдол ч гарсан. Хоёрдугаарт, байрны үнэд нөлөөлсөн зүйл бензиний үнэ” гэв. Тэрбээр мөн” Бүх барилгын компанитай уулзаад үнээ буулга гэж шаардах боломжгүй. Ерөнхийдөө зах зээл дээр байгаа барилгын материалын үнээр тооцож үзэхэд орон сууцны нэг ам метрийн ханш 750-900 мянган төгрөгийн үнэтэй байх боломжтой юм. Тодорхой ашгаа нэмээд бодсон ч 1.5-1.8 сая, бүр 2.0 сая төгрөгт хүрч өсөх үндэслэлгүй” гэлээ. Сангийн яамны дэд сайд Ц.Ганхуяг “Нэг аюултай зүйл бий. Энэ онд цалин тэтгэвэр 50 хувиар нэмэгдэнэ. Ялгаагүй барилгын компаниудын ажилтнуудын цалин нэмэгдэнэ. Тэгэхээр тэр өртгийг тооцоход байрны үнэ нэг их буурах бололцоо гарахгүй байх” гэсэн юм.

Чингэлтэй дүүрэгт байртай болох гэж санахын ч хэрэггүй

Үүнтэй холбоотой судалгааны байгууллагын мэдээлэл рүү эргээд оръё. Улаанбаатар хотод өнгөрөгч хоёрдугаар сарын байдлаар нийт 135 орон сууцны барилгын төсөл хэрэгжиж байгаа аж. Эдгээр нь энэ оны нэгдүгээр улирлаас эхлээд 2013 оныг хүртэл ашиглалтад орохоор байгаа юм. Аль дүүрэгт хэчнээн ширхэг орон сууцны төсөл хэрэгжиж байна вэ гэдгээсээ хамаараад байрны үнийн өсөлт, хэлбэлзэл янз бүр байдаг аж. Хан-Уулд 35, Баянзүрхэд 39 орон сууцны барилга баригдаж байхад Чингэлтэй дүүрэгт нийтдээ гуравхан төсөл хэрэгжиж байх жишээтэй. Тэгэхээр хотын төвийн дүүрэг болох Чингэлтэйд орон сууцны үнэ харьцангуй өндөр хэвээр байна гэсэн үг. Энэ байдлаараа орон сууцны зах зээлд оролцогчдын сонирхлыг тус дүүрэг байнгын татаастай байдаг гэж хэлж болох.

“100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатарт 75000 айлын орон сууцыг Нисэх, Яармагт барих төлөвлөгөөтэй. Шинэ бүтээн байгуулалтын хүрээнд төвлөрлийг сааруулъя, хот, хөдөөгийн ялгааг арилгаж, хотын төвдөө байшин-гуудыг шавааралдуулан барьдаг байдлаа зогсоох гэсэн үндсэн зарчим барьж байгаа нь сайн хэрэг. Харин орон сууцны зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн асуудалд илүү бодитой хандаж, үнийн хөөсийг улам томруулах биш, тогтворжуулах шаардлага бий нь эндээс харагдах биз ээ. Өөрөөр хэлбэл, ипотекийн зээл оволзсон эрэлт, олзны үүдийг нээдэг байж таарахгүй. ■

Арилжааны банкуудын орон сууцны зээлийн нэрлэсэн хүүгийн судалгаа

Банк	Урьдчилгаа төлбөр	Хүү		Үйлчилгээний шимтгэл	Өргөдлийн хураамж	Зээлийн хугацаа	Зээлийн дээд хэмжээ	
		Төгрөг	Доллар				Улаанбаатарт	Орон нутагт
Капитал	50.00%	1.30%	1.10%	0.50%	10.000	120 сар	100 сая төгрөг эсвэл түүнтэй тэнцэх ам.доллар	
	40.00%	1.40%	1.20%	0.50%	10.000			
	20.00%	1.50%	1.30%	0.50%	10.000			
Хас	30.00%	1.80%	1.50%	1.00%	10.000	240 сар	80 сая төг эсвэл 100.000 ам.доллар	40000 ам.доллар
		2.00%	1.70%	1.00%	10.000			
Капитрон	30-40%	1.6-1.9%		0.50%	5000	180 сар	150 сая төгрөг	
	40-50%	1.5-1.8%		0.50%	5000			
	50%-с дээш	1.4-1.6%		0.50%	5000			
ХААН	30-39%	1.60%		0.50%	15.000	180 сар	100 сая төгрөг	30 сая төгрөг
	40-49%	1.50%		0.50%	15.000			
	50%-с дээш	1.40%		0.50%	15.000			
ХХБ	20-40%	1.50%		0.20%	10.000	180 сар	100 сая төгрөг, түүнтэй тэнцэх ам.доллар	
	41% дээш	1.40%	1.30%	0.20%	10.000			
Төрийн банк	30-50%	1.40%	1.25%	Санхүүгийн үйлчилгээний шимтгэл 0.5 %, үүнд өргөдлийн хураамж, үйлчилгээний хөлс багтсан болно		180 сар	Орон сууцны үнэлгээний 70 %	
	50%-с дээш	1.40%	1.10%			180 сар	100 сая төгрөг эсвэл 100.000 ам.доллар	
Голомт	50%-с дээш	1.50%	1.00%	0.50%	10.000	180-240 сар	120 сая төгрөг хүртэл	
	30-49%	1.40%		0.50%				
Хадгаламж	30%	1.80%		0.50%	10.000	120 сар	Улаанбаатар хотод 100 сая төгрөг хүртэл	
	31%-с дээш	2.00%		0.50%				

http://www.mongolianeconomy.mn

Үнэ ханш

Орон сууцны зах зээлийн мэдээлэл

“Mongolian Economy” сэтгүүл үл хөдлөх хөрөнгийн худалдаа эрхэлдэг “Мастер пропертис” компанитай хамтран Улаанбаатар хотын орон сууцны зах зээлийн үнэ ханшийг өнгөрөгч хоёрдугаар сарын байдлаар сонирхуулж байна. Монголчуудад өнөөдөр хамгийн их хэрэгцээтэй орон сууцны зах зээлийн мэдээлэлд анхаарал хандуулдаг “Барилга.mn”, “Тэнхлэг зууч.mn” гэх мэт байгууллага байдаг ч “Мастер пропертис” компани нь мэргэжлийн судлаачдын баг ажиллуулан сар, улирал тутамд орон сууцны зах зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, судалгаа хийдэг байгууллага юм. Тус компани үйл ажиллагаагаа өргөжүүлэн Судалгааны албатай болж, судлаачдаа энэ чиглэлээр Сингапурт мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байгаа аж.

Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй төслүүдийн үнийн судалгаа

/сая.төгрөгөөр/

	Баянзүрх дүүрэг		Хан-Уул дүүрэг		Сүхбаатар дүүрэг		Сонгинохайрхан		Чингэлтэй дүүрэг		Баянгол дүүрэг		Улаанбаатар хот	
	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ	Байрны тоо	Дундаж үнэ
900-аас доош	2	830,000			1	583.333	1	888,000					4	1,200,000
901-1200	10	1,132,000	1	990,000			8	1,091,000			1	1,200,000	20	2,000,000
1201-1700	20	1,479,725	12	1,460,000	6	1,433,333	5	1,410,000			29	1,444,517	72	1,915,806
1701-ээс дээш	6	1,983,684	22	2,272,808	6	2,541,300			3	2,333,356	1	1,750,000	38	1,962,929
Нийт	**38**	**1,433,595**	**35**	**1,879,784**	**13**	**2,375,409**	**14**	**1,183,800**	**3**	**2,333,356**	**31**	**1,446,483**	**134**	**1,649,191**

Хэрэгжүүлж буй төслүүдийн үнийн судалгаа

/сая төгрөгөөр/	Нийт тоо	Эзлэх хувь
900 -гаас доош үнэтэй байр	4	2.99%
901-1200 үнэтэй байр	20	14.93%
1201-1700 үнэтэй байр	72	53.73
1701-ээс дээш үэнтэй байр	38	28.36%

Хэрэгжүүлж буй төслүүдийн ашиглалтад орох хугацаа

	Хан-Уул	Сүхбаатар	Баянгол	Чингэлтэй	Баянзүрх	Сонгинохайрхан	Нийт
Ашиглалтад орсон	14	3	9	1	19	3	49
2012-I улиралд	5	2	11	1	3	2	24
2012-II улиралд	4	5	6	1	9	5	30
2012-III улиралд	3	-	3	-	2	2	10
2012-IV улиралд	3	1	1	-	2	1	8
Нийт	35	13	31	3	39	14	135

Улаанбаатар хотод хэрэгжиж буй нийт 135 орон сууцны барилгын төслийг ашиглалтад орох хугацааны дарааллаар байрлуулав.

http://www.mongolianeconomy.mn

Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй орон сууцны төслүүдийн дундаж үнэ

/сая. төгрөгөөр/

Дүүрэг	2011 оны 02 сар	2012 оны 01 сар	2012 оны 02 сар	Сарын өөрчлөлт	Жилийн өөрчлөлт
БГД	930.000.00	1.401.630.43	1.446.483.87	-3.20%	35.71%
БЗД	987.000.00	1.426.263.64	1.433.594.98	0.51%	31.15%
ЧД	1.081.000.00	2.400.220.00	2.333.356.27	2.79%	53.67%
СБД	924.000.00	2.319.345.83	2.375.408.89	-2.42%	61.10%
СХД	1.010.000.00	1.069.750.00	1.183.800.00	-10.66%	14.68%
ХУД	1.190.000.00	1.941.555.44	1.935.046.95	0.34%	38.50%
Дундаж	1.020.333.33	1.675.809.77	1.649.191.33	1.59%	38.13%

2012 оны хоёрдугаар сарын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд шинэ орон сууцны ам метрийн дундаж үнэ 1.649.191 төгрөг болж, өмнөх сараас 1.59 хувиар, өмнөх оны мөн үеэс 38.13 хувиар өссөн дүнтэй байна.

Хэрэгжүүлж буй төслүүдийн хүчин чадлын хэмжээ

	Нийт төслийн тоо	Нийт айлын тоо	Захиалга авах сууцны тоо	Харьцаа
Хан-Уул	35	4791	2378	49.6%
Сүхбаатар	13	794	299	37.7%
Баянгол	31	3341	1470	44.0%
Баянзүрх	39	9510	2530	26.6%
Чингэлтэй	3	62	19	30.6%
Сонгинохайрхан	14	1768	753	42.6%
Нийт	**135**	**20266**	**7449**	**36.8%**

135 орон сууцны төслийн хүчин чадлыг айлын тоо хэмжээгээр нь аваад үзвэл нийтдээ 20 мянган өрхийн орон сууц баригдаж байгаагаас захиалга авах сууцны тоо хэмжээ 7449 буюу нийт хэрэгжиж буй төслүүдийн 36.8 хувь нь байна.

Хэрэгжүүлж буй төслүүдийн өртөг, борлуулалтын түвшин

	Төслийн нийт борлуулалт	Захиалга авч буй сууцны борлуулалт	Борлуулалтын түвшин
Баянзүрх	907.455.789.006₮	709.641.243.346₮	21.80%
Сонгинохайрхан	98.575.115.650₮	37.134.227.100₮	62.33%
Хан-Уул	1.242.704.669.301₮	585.186.041.198₮	52.91%
Чингэлтэй	24.235.819.638₮	12.322.860.768₮	49.15%
Сүхбаатар	138.058.452.485₮	52.056.271.341₮	62.29%
Баянгол	440.767.831.743₮	115.090.667.105₮	73.89%

Улаанбаатар хотод хэрэгжиж буй 135 төслийн нийт борлуулалт 2.8 тэрбум төгрөг юм. Захиалга авч буй нийт сууцнуудын борлуулалтын дүн 856 тэрбум төгрөг буюу нийт хэрэгжүүлж буй төслүүдийн дундаж борлуулалтын түвшин 47 хувь байна.

Хуучин орон сууцны дундаж үнэ

	1 өрөө			2 өрөө			3 өрөө		
	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их
БГД	39.60	54.44	62.00	59.94	76.81	89.20	78.90	94.64	107.60
СБД	48.90	58.57	64.80	66.80	79.41	89.80	87.40	100.30	108.00
ХУД	43.67	48.42	51.33	61.33	67.77	83.00	70.33	74.83	79.33
ЧД	58.67	63.67	68.67	69.33	77.67	86.00	90.00	98.33	106.67
БЗД	38.25	50.14	57.50	65.00	78.18	90.75	76.50	91.23	101.25
СХД	31.88	41.99	47.63	53.25	58.73	69.50	59.50	67.60	77.50

Эх сурвалж: “Мастер пропертис” компани

http://www.mongolianeconomy.mn

Үл хөдлөх хөрөнгийн зууч

Л.Туяа: Хүмүүст тусалж мөнгө олно гэдэг сайхан шүү дээ



Америкийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлд чадварлаг ажиллаж буй нэгэн монгол эмэгтэйг Лодонгийн Туяа гэдэг. Уг нь Энхтуяа нэртэй ч том гүрэнд бизнес эрхлэхэд товчхон, амархан цээжлэгдэх нэр ихээхэн чухал байдаг аж. Өндөр хөгжилтэй орны үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэх нь нэлээд тэвчээр, мэдлэг боловсрол, ур ухаан, чадвар шаардсан ажил. Тэр дундаа монгол эмэгтэй ийм бизнес хийгээд америкчуудын нэгэн адил ажиллаж явна гэдэг үнэхээрийн бахархуштай билээ. Тэрбээр эдийн засагч мэргэжилтэй, ШУТИС-ийн КТМС-ийн багш, Монголбанк, Гадаад хэргийн яаманд ажиллаж байгаад 10 жилийн өмнө магистарт суралцахаар Америкийг зорьжээ. Эдүгээ АНУ-ын Арлингтон мужид ажиллаж амьдарч байна.

-Та Америкт өөрийн эрхэлдэг ажлынхаа талаар сонирхуулахгүй юу?

-Миний хувьд орон сууц худалдан авах гэж байгаа иргэдэд шийдвэр гаргах хүртэлх бүх талын үйлчилгээг үзүүлдэг. Брокер гэсэн үг. Нөгөө талдаа хувь хүн, иргэнийхээ хувьд хөрөнгө оруулагч болон ажиллаж байгаа гэж хэлж болно. Ийм хоёр ажлыг хамт хийдэг. Гэхдээ сүүлийн үед хөрөнгө оруулагч талдаа түлхүү ажиллаж байгаа. Энэ нь банкны өмч болсон байрыг анхны үнээр нь худалдан аваад, засвар болон бусад шаардлагатай үйлчилгээг хийж, зах зээлийн үнээр нь эргүүлэн худалддаг. Брокерээс ялгаатай нь би өөрөө байр худалдан аваад өөрөө зарна гэсэн үг. Харин брокер бол аль нэг компанид харьяалагдаж, цалин аваад явахыг хэлнэ.

-Энэ том зах зээлд ийм бизнес эрхлээд хөлөө олно гэдэг нь монгол эмэгтэйн ухаан, авьяас, ур чадварыг харуулж байна. АНУ-д сайхан амьдрах боломж хэр байдаг вэ?

-Өөр нийгэм, өөр ёс заншил дунд орно гэдэг хувь хүнээс асар их өөрчлөлт шаарддаг. Ер нь аливаа зүйлд хүн эрсдэл гаргах зайлшгүй шаардлага гарна. Том эрсдэл, том ашиг авчирдаг шүү дээ. Тиймээс хүн цагаа үеэ олсон эрсдэлийг гаргах хэрэгтэй. Хамгийн гол нь би юу хийж чадах вэ гэдгээ сайтар мэдэх нь чухал. Тэгээд хамгийн сайн хийж сурсан зүйлээ чадамгай, зоригтой хий. Тэр чинь танд мөнгө авчирна. Тийм болохоор хүн хаана ч амьдрах адилхан болов уу. Миний хувьд хийж чадах зүйл бол олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцах байсан. Зах зээлийн мэдлэгээ бусадтай хуваалцаж, хүмүүст тусалж мөнгө олно гэдэг сайхан шүү дээ. Хүн ямар нэг ажил хийхдээ түүнээсээ аз жаргал олж авч чадах нь их чухал юм. Би одоогийн хийж байгаа ажилдаа дуртай, энэ ажлаасаа аз жаргалыг мэдэрдэг. Энэ л тухайн хүнийг амжилтад хүргэдэг байх.

-АНУ-д явуулж буй үл хөдлөх хөрөнгийн бизнестээ Таныг Монголоос хөрөнгө оруулагч хайж байгаа гэсэн. Мэдээж хөрөнгө оруулахын тулд баталгаа шаардлагатай. Тэгвэл таны хөрөнгө оруулагчид үзүүлэх баталгаа юу вэ?

-Мэдээж хөрөнгө оруулахын тулд баталгаа хэрэгтэй нь үнэн. Үүний тулд эхлээд миний хийдэг ажлыг нарийн ойлгох хэрэгтэй. АНУ-д зах зээл дээр нэгэнт гарчихсан байрыг худалдан аваад сайжруулж, эргүүлэн зардаг нэг хэсэг хүмүүс байдаг. Миний хувьд бол тухайн байрыг зах зээлд зарлахаас нь өмнө банктай харьцаж зах зээлийн үнээс илүү хямдаар авахыг боддог. Энэ нь ашиг илүү олно гэсэн үг.

Америк бол том зах зээл. Тиймээс хямд үнэтэй байр авах нь хүн бүрийн хүсэл. Харин энэ эрэлт дээр миний эрхэлж буй бизнес тогтдог. Тэр эрэлтийг нийлүүлэлтээр хангах нь миний ажил. Гэхдээ эрэлтийг хангахад шаардлага хэрэгтэй. Тухайлбал, байршил гэдэг хамгийн том үзүүлэлт. Ашигтай байрлалтай байр сонгож чадсан л бол Та худалдан авагч гарч ирнэ гэдэгт итгэлтэй байж болно. Мөн үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хөрөнгө нь өөрөө баталгаа болж өгдөг. Хар ухаанаар бодоход зах зээл дээр 100 мянган ам.долларын үнэтэй байрыг 50 мянган ам.доллараар худалдан авах нь эрсдэл бага гэсэн үг шүү дээ. За тэгээд худалдан авч байгаа байрныхаа бичиг баримтыг зөв бүрдүүлж чадвал эрсдэл улам л буурна. Түүнчлэн талууд хоорондын итгэлцэл чухал. Хөрөнгө оруулагч тал тогтворгүй байх юм бол өөрөө өөртөө өндөр эрсдэл учруулж байна гэсэн үг. Мөн хөрөнгө оруулагчидтайгаа нарийн гэрээ хийдэг.

-Таны банкнаас авч байгаа орон сууцыг жирийн иргэд яагаад шууд банкнаас нь авч болдоггүй юм бэ?

http://www.mongolianeconomy.mn

-Банкны барьцаалсан хөрөнгө гэдэг иргэд зээлээ төлж чадаагүй тохиолдолд банкинд очсон тэр хөрөнгө юм. Тиймээс арилжааны банк өөрийн эргэлтийн хөрөнгөө гаргаж авахын тулд үл хөдлөх хөрөнгийг аль болох бэлэн мөнгөөр хурдан зарах хэрэгтэй. Харин жирийн иргэд шаардлагатай мөнгийг шууд гаргаад өгөх нь ховор. Тиймээс тодорхой хөрөнгө оруулагч нарт банк шууд ханддаг гэсэн үг. Энэ нь аль аль талдаа ашигтай.

-Та ямар шалгуур үзүүлэлтээр үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг вэ?

-Хамгийн том шаардлага бол байршил. Манайхны хэлдгээр худаг буудалдаа ойрхон гэдэг ч юм уу. Ингэж чадвал Та сайн наймаа хийлээ гэсэн үг. Дээрээс нь цонх нь ой мод руу харсан байна уу эсвэл граш руу харсан уу. За тэгээд наран талдаа цонхтой эсэх гээд олон зүйл үнэ ба эрэлтэд шууд ба шууд бусаар нөлөөлдөг.

-Худалдан авсан орон сууцаа хэр хугацаанд борлуулдаг вэ?

-Ер нь бол янз бүр. Гэхдээ дээд талын хугацаа нь гурван сар байх ёстой. Түүнээс дээш бол алдагдалд орж эхэлнэ. Хэрвээ Та үнэхээр сайн наймаа хийж чадсан бол хоёр долоо хоногийн дотор л зарагддаг.

-Та гаднын оронд үл хөдлөх хөрөнгийн бизнесийг амжилттай хийж явна. Харин эх орондоо энэ талын бизнес хийх санаа байгаа юу?

-Байна аа. МҮХАҮТ-аас надад санал тавьсан. Үүний дагуу өөрийнхөө бололцоогоор энэ чиглэлийн бизнесийг эх орондоо өргөжин хөгжихөд хувь нэмрээ оруулна гэж бодож байгаа. Гэхдээ санасны зоргоор шууд бүтэхгүй. Нэгдүгээрт, бид мэргэжлийн боловсон хүчин бэлдэх шаардлагатай. Мөн ёс зүйн хувьд бэлдэх нь маш том ажил. Хууль эрх зүйн орчин сайн байх шаардлага байна. Одоогоор үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын ёс зүйн дүрэм батлагдах гэж байгаа юм билээ. Энэ тал дээр өөрийн санаа оноогоо хэлж байгаа. Мөн хуулийн санал санаачилга гарч эхлээд байгаа гэсэн. Уг хуулийн төсөлд бас өөрийн саналаа нэмэрлэнэ гэж бодож байна.

-Өнөөдөр Монголд үл хөдлөх хөрөнгийн зууч гэдэг ойлголт хөгжиж эхлээд байна.

-АНУ-д үл хөдлөх хөрөнгө үүсч бий болоод хэдэн зуун жил болсон. Тэр утгаараа маш өргөн хүрээг хамардаг. Харин манайд байшинг л үл хөдлөх хөрөнгө гэвэл ойлгочихсон байх шиг байна. Өрөөсгөл ойлголт. Тухайлбал, АНУ-д 60 жилийн турш тухайн обьектыг хэн эзэмшиж байсан, жинхэнэ эзэн нь мөн биш эсэх, өв залгамжлал, газар, байршил гээд бүх зүйл үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой байдаг. Энэ утгаараа хууль зүйн олон асуудал хөндөгддөг. Харин жирийн иргэдийн дунд ажлын хажуугаар энэ бүгдийг хийх зав байхгүй дээрээс нь хуулийн бүх талын мэдлэг хуримтлуулна гэдэг хэцүү. Манайхан нэг хашаа байшин худалдаж авлаа гэхэд кадастрын зургаас авахуулаад нэр дээрээ шилжүүлэх хүртэл бөөн асуудал болдог. Асуудлаа шийдэхийн тулд ажлаасаа чөлөө авах гэдэг ч юм уу. Харин энэ бүх асуудлыг брокер шийдээд өгч чаддаг. Энэ үүргээ нэр төртэй биелүүлдэг байх хэрэгтэй. Тиймээс тэдэнд хийх ёстой ажлыг нь өгчих. Тэгээд л бүх зүйл жин тан. Үүнээс гадна үл хөдлөх хөрөнгөө зарж байгаа хүний эрхийг мөн брокер хамгаалж өгөх учиртай. Мөн цаг хугацаа, талуудын хөдөлмөрийг аль аль талд нь хөнгөвчилж өгдөг. Дээр хэлсэнчлэн үл хөдлөх хөрөнгийн зуучдын ёс зүйг сайн байлгах нь иргэдийн сэтгэлгээнд том нөлөө үзүүлнэ. Бид л үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг олж, эрх ашгийг хамгаалж чадвал тэд бидэнд хандаад эхэлнэ. Би эх орондоо ирээд хэдхэн хонож байгаа болохоор миний байсан үеийнхээс юу өөрчлөгдсөн гэдгийг сайн мэдэхгүй байна. Зах зээлээ ч судалж амжаагүй яваа. Харин мэргэжлийн хүмүүстэй ярилцаж байхад иргэдийн дунд үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нарт хандах нь үргүй зардал гэж үздэг юм шиг санагдсан. Тиймээс үйлчлүүлэгч талд асуудлыг сайтар ойлгуулах нь чухал.

-Гадаадад олон жил ажиллаж байгаад ирэхэд тань манай улсын хөгжил ямар байна вэ?

-Улс орны хөгжлийг тодорхойлдог томоохон хүчин зүйлүүдийн нэг нь ард иргэдийн харилцааны соёл байдаг. Энэ тал дээр манайхан хөгжсөн байгаа нь ажиглагдсан. Энэ бол том амжилт шүү. ■

Статистик

Америкчууд ажиллаж амьдрахад таатай газрыг сонгохдоо үр хүүхдээ хүмүүжүүлэх сургууль орчны аюулгүй байдал байгалийн гоо сайхныг түлхүү харж, ажилгүйдлийн түвшин доогуур газрыг эрэлхийлдэг аж. Үүнд, ихэвчлэн 58 мянга гаруй хүн амтай жижиг хотууд ордог. Зарим иргэн худалдан авсан байраа эдийн засгийн эргэлтэд оруулж ашиг хонжоо олохын төлөө явдаг байна. Ийм иргэдийн хувьд худалдан авсан байрандаа дунджаар зургаан жил амьдраад буцааж худалддаг аж. Мөн америк иргэн 32 наснаасаа хаус худалдан авдаг судалгаа бий. Эдгээр залуусын жилийн дундаж орлого 57.200 ам.доллар байдаг байна. Америкчуудын 65 хувь нь 30-40 насандаа анхныхаа хаусыг худалдан авдаг хол 45-60 насандаа хоёр дахь байрыг худалдан авдаг гэсэн баримт байна. Тус улсад хаусны дундаж үнэ 300.000 орчим ам.доллар байдаг тухай АНУ-ын Реалтеруудын холбооны судалгаанд дурджээ.


2007 оны эдийн засгийн санхүүгийн хямрал АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн буюу моргэйжийн зээлээс улбаатай байсан билээ. Банкнаас үл хөдлөх хөрөнгийн зээл авах боломжийн нөхцөл нь олон америкийг орон сууцтай болгосон ч олон иргэн зээлээ төлж чадахгүйд хүрч санхүүгийн хямрал нүүрлэхэд хүрсэн юм. Өнөөдөр тус улсын иргэд банкнаасаа жилийн 3-4 хувийн хүүтэйгээр үл хөдлөх хөрөнгийн зээлийг 15-30, түүнээс ч дээш жилийн хугацаатай авах боломжтой аж.

АНУ-ын олон хотод нэг өрөө түрээсийн байрны төлбөр 900-1000 ам.доллар байдаг. Гэхдээ зарим хотод 500-700 ам.доллар байх нь бий. Үнийн хэлбэлзэл нь мөн орон сууцны байршил тохижолт зэргээс хамаарч өөр хоорондоо адилгүй байдаг аж.



http://www.mongolianeconomy.mn

Эдийн засаг



Шог зургийг А.Амарсайхан

Асуудал

Малтай монгол махгүй өлсөх үү

Б.Баяртогтох

Монгол Улс мал аж ахуйн орон. Бид ингэж ярих дуртай. Дуртай ч гээд байх зүйлгүй угаасаа тийм гэдэгтэй гадаад улс орнынхон ч санал нийлж, хүлээн зөвшөөрдөг. Манай мал сүргийн тоо толгой өнгөрсөн онд гэхэд л 36 саяд хүрч, нэг хүнд ногдох малын тоогоороо дэлхийд эхний аравт багтаж байна. Гэсэн хэдий ч малтай монгол махгүй өлсөх болж байгаа нь эмгэнэлтэй. Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт болон инфляци гэдэг “хадны мангаа” гаарч байгаатай холбоотой иргэдийн худалдан авах чадвар улам бүр дордсоор.

Өнөөдрийн байдлаар өрхийн эдийн засгийг хамгийн их хотолзуулж буй хүнсний бүтээгдэхүүнээр махны үнийг нэрлэж болно. Махны үнийн өсөлт Монголд шинэ асуудал биш. Жил бүрийн хавар болоод Улсын баярын үеэр тэнгэрт гардаг уламжлалтай гэж хэлж болно. Малын тоо толгой 36 сая битгий хэл 40 гаруй саяд хүрч өссөн үед ч энэ асуудал арилдаггүй талтай. Гэхдээ энэ жил махны үнэ Улаанбаатар хотод урд өмнө нь байгаагүйгээр өсөж, рекорд тогтоогоод байна.

Нийслэлийн Дэнжийн мянгад байрлах “Хүчит шонхор” захад өнгөрөгч сарын 22-ны байдлаар мах дараах үнэтэй байлаа. Үхрийн цул махны жижиглэн худалдаалах үнэ нэг кг тутамд 7800-8500, хониных 7500-8200, ямааны цул 5500-6000 төгрөгийн ханштай байв. Ястай болохоороо үхрийн мах нэг кг нь 6500-7200 төгрөгийн үнэтэй. Өөрөөр хэлбэл, ямар малын мах гэдгээсээ хамаараад ястай махны үнэ цул махныхаас даруй 1000-1300 төгрөгөөр хямд байна гэсэн үг. Өмнөх жилүүдийн хавар махны үнэ өслөө өслөө гэхэд дээд тал нь өнөөдрийн ямааны цул махны ханштай ижил хэмжээнд очдог байсан /үхрийн мах дээд тал нь нэг кг нь 5500-6000 төгрөгийн үнэд хүрдэг / юм. Хонины махны үнэ бол өмнөх жилүүдэд өсөөд 5000 төгрөгөөс нэг их хол давдаггүй байсныгуншигчидсайнсанажбайгаабиз ээ. Гэтэл өнөөдөр махны үнэ нийслэлд дунджаар 8500 төгрөгийн үнэтэй байна. “Хүчит шонхор” зах Улаанбаатар хотын махны бөөний төв гэдэг утгаараа энд махны үнэ харьцангуй хямд байдаг гэж хэлж болно. Нийслэлийн бүх хүнсний дэлгүүр, томоохон худалдааны төв, супермаркетууд өглөө бүр тус захаас махаа бөөндөж авдаг гэсэн үг. Тэгэхээр махны худалдааны

http://www.mongolianeconomy.mn

төвлөрсөн зах дээр нэг кг махны үнэ дунджаар 8500 төгрөг байхад хотын төвийн хүнсний зах, дэлгүүрүүдэд дээрх ханш кг тутамд 300-500, зарим дэлгүүрт бүр 1000 хүртэл төгрөгийн зөрүүтэй байдаг билээ.

36 сая толгой малтай гэчихээд нэг кг махыг 9000 төгрөгөөр үнэлж авна гэдэг монголчуудын хувьд бухимдахаас аргагүй зүйл. 30, 40 сая толгой малтайгаас гадна жил бүр төсвөөс хэдэн тэрбумаар нь мөнгө гаргаж, улсын нөөцөд мах бэлтгэдэг. Өнгөрсөн жил гэхэд л 12000 тонн мах нөөцөлсөн. Тэгсэн хэрнээ махны үнийн өсөлтийг хазаарлаж чадахгүй, нэг кг нь 9000 төгрөгт хүрч өсөж байгаа нь хачирхалтай. Зах зээлийг ямар үл үзэгдэгч гар эвдэхэд хүргээд байна вэ гэдэг талаар бодох л асуудал. ХХААХҮЯ-наас өнгөрсөн өвөл болон хавар цаг агаар тогтуун сайхан байгаа тул Монголын мал сүргийн тоо шинэ төлтэйгээ нийлээд энэ оны төгсгөлд 50 сая толгойд дөхөж очно гэсэн урьдчилсан таамаг дэвшүүлжээ. Малын тоо толгой өсөх нь чихэнд чимэгтэй сайн мэдээ ч махны үнийн өсөлт монголчуудыг сөхрүүлж байгаа нь утгагүй зүйл юм.

Сонгуулийн жил махны үнэ өмнө байгаагүйгээр цойлж байгаа нь улстөрчдийн хувьд сонирхолтой сэдэв болж, аль болох махны тухай их ярьж, олон нийтэд гэгээн дүрээ олон харуулах сайхан далим болж байх шиг. Хавар идэхээр нөөцөлсөн 12 мянган тонн махныхаа 5000 тонныг нь өвлийн сард зах зээлд нийлүүлсэн. Цагаан сарын буузыг хямд өртөгтэй байлгах үүднээс хотын дүүрэг бүрт Нөөцийн махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, ангилж, жижиглэн “нарийлалгүйгээр” гулуузаар нь худалдаалж бийлэгжүү загнасан. Үүнийг гэхдээ нөөцийн махны бэлтгэл, борлуулалтад оролцдог төрийн болон төрийн бус байгууллагууд, компанийнхан дур мэдэн хийчихээгүй. Дээрээс төр, засгийн зүгээс өгсөн шийдвэр нь мэдээж.

Хаврын тарчиг цагаар зах зээлд нийлүүлэх байсан нөөцийн мах 5000 тонноор дундраад ирэнгүүт Засгийн газраас дахин шинээр 10 гаруй мянган тонн мах нөөцөд бэлтгэх “лүндэн” буулгах нь тэр. Энэ нь мал мах бэлтгэхтэй холбоотой нарийн ширийнийг мэддэг малчид, мэргэжилтнүүд битгий хэл, мах идэхээс цааш мэдлэггүй хүн ч үнэхээр гайхахаар шийдвэр байв. Учир нь, цас ханзраагүй байхад хаанаасаа дээрх хэмжээний махыг гаргаж ирэх вэ гэдэг нь хачирхалтай. Нойтон мах байтугай нь олддоггүй хаврын тарчиг цагт дахин бүрдүүлэх нөөцийн мах малчны хотонд өрнөхгүй нь лавтай. Харин Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхэд орон нутгийн төр, засгийн байгууллагынхан идэвх чармайлт гаргах учиртай. Хаанаас яаж бүрдүүлэх нь тодорхойгүй ч нөөцийн махны эхний ээлжийн 1000 гаруй тонн мах Хөвсгөл аймгаас ирээд байгаа гэсэн мэдээлэл хэвлэлээр саяхан цацагдлаа. Гэвч нэмж нөөц бүрдүүлэх Засгийн газрын шийдвэр гарч, ажил явагдаж байгаа хэрнээ махны үнэ буурах нь битгий хэл, тогтворжих ч шинжгүй байна. Яагаад вэ? Малаа таван төрөл дээр нь өсгөөд байгаа малчид лав үүнд буруугүй нь тодорхой.


“Мах маркет” компанийн ерөнхий захирал Т.Содномдаржаа монголчуудын махны хэрэглээ жил тутамд дунджаар 3000 тонноор нэмэгдэж байгаа тухай ярьсан юм. Хотын хүн ам жилээс жилд нэмэгдэж, нягтаршиж байгаа учраас Улаанбаатар хотын махны хэрэгцээ нэмэгдэх нь ойлгомжтой. Түүнчлэн иргэдийн цалин орлого, тэтгэвэр тэтгэмж тодорхой хувиар нэмэгдэж буй нь махны үнэ өсөхөд нөлөөлсөн байх талтай. Нийслэлийн нийт иргэд өдөрт дунджаар 300 тонн мах хэрэглэдэг гэсэн судалгаа байна. Одоогоос гурван жилийн өмнө энэ хэрэгцээ 120-200 тоннын хооронд хэлбэлздэг байсан бол өнөөдөр 200-300 тонн болж өсчээ. Энэхүү нийслэлчүүдийн махны хоногийн хэрэглээг сар, жилээр тооцоод үзэх юм бол нэлээд өндөр тоо гарна. Монголчуудын махны хэрэглээ харьцангуй өндөр болохыг энэ тоо гэрчлэх биз ээ.

Махны үнийн өсөлт экспортод хүртэл тушаа болов

Махны үнэ ханш, нийлүүлэлтийн байдлыг судлахаар “Хүчит шонхор” хүнсний захаар явсан талаар дээр хэлсэн. Энэ үед Цагаан сарын өмнөөс зах зээлд нийлүүлсэн нөөцийн махны нийлүүлэлтийг ерөнхийд нь царцаасан байдалтай байсан юм. Учир нь, нөөцийн махыг 2600-3700 төгрөгөөр борлуулж байгаа нь инфляцийн өсөлт болоод бусад өртгийг огтхон ч тооцохгүйгээр зардлаас хэт доогуур үнэ тулгаж, алдагдалд оруулж байна гэж нөөцөд мах бэлтгэсэн компанийнхан үзсэн учраас тэр. Түүнчлэн нөөцөд үлдсэн 7000 тонн мах нь нийслэлчүүдийн хаврын тарчиг өдрүүдийн нийт хэрэглээний 20 хувийг л чадан ядан хангаж чадах тухай Монголын махны холбооны гүйцэтгэх захирал М.Лхачинбал хэлсэн. Тэрбээр мөн “Манай холбооны гишүүн компаниуд нөөцийн мах бэлтгэж, кг тутамд нь 500 төгрөгийн алдагдал хүлээсэн. Тэд дахин нөөцийн махны асуудалд оролцохгүй гэдгээ мэдэгдэж байгаа. Махны бизнесээс ашиг хонжоо хайгчид хэтэрхий их байна. Бодит байдал дээр махны үнэ ийм байх ёстой гэсэн төрийн хатуухан бодлого ч алга. Хятадуудын гар хөл болсон мөнгөтэй ченж нар махны үнийг хөөрөгдөх, зах зээлд нийлүүлэгдэх махыг зохиомлоор хомсдуулж байгаа нь үнийг огцом өсөхөд нөлөөлж байна” гэв.

Хэдийгээр үндэсний компаниудын бэлтгэсэн нөөцийн махны борлуулалт царцанг байдалтай байсан ч “Хүчит шонхор” захад 12,5 кг -аар нимгэн, зузаан хоёр давхар уутанд савласан, гадна талын уутан дээр нь хятад бичиг дурайх махтай таарлаа. Нэг кг нь 4700 төгрөг гэнэ. Ямааны цул мах гэхэд харьцангуй хямд санагдав. Гэтэл хажуугийн лангуун дээр ууталж савлаагүй ямааны махны жижиглэнгийн үнэ 5500-6000 төгрөгийн үнэтэй байв.





http://www.mongolianeconomy.mn

Тооцоод үзэхэд нэг кг тутамдаа даруй 800-1000 төгрөгөөр хямд тусаж байна. Давхар давхар ууттайг нь бодохоор эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг чандлан мөрдсөн гэлтэй. Гэвч яагаад ийм хямд байна вэ. Ахиулаад харвал дээрхийн адил уутанд хийсэн ямааны гулууз мах ч өрөөстэй харагдлаа. Гулууз мах нь бүр хямдхан буюу нэг кг-ыг нь 4300 төгрөгөөр борлуулж байгаа гэнэ. Махны худалдагч Ц.Төмөрбат “Манай Монголын малын гаралтай арьс шир, ноос ноолуур зэрэг түүхийн эдийн зах зээлийг хятадууд атгадаг байсан бол одоо тэд махны худалдааг мэддэг болчихож. Энэ тусгайлан савласан ууттай ямааны махыг би өнөөдөр нэг монгол эмэгтэйгээс авсан юм. Харьцангуй хямд үнэтэй учраас хүмүүс нэлээд сонирхон авч байна. Уг нь экспортын зориулалттай мах юм байна лээ. Эмээлтэд байрладаг Хятадын хөрөнгө оруулалттай компанийн бэлтгэсэн мах гэсэн. Засгийн газраас дотоодын махны үнийн өсөлттэй холбоотой махны экспортыг ирэх долдугаар сарын 1 хүртэл хорьсон учраас үйлдвэрүүд махаа гаргаж эхэлж байх шиг байна” гэж сонирхуулав.



Хятадууд манай махны наймааны дотоодын зах зээлд оролцож, мах их хэмжээгээр нь бөөндөж авч, нөөцөлж байна гэсэн мэдээлэл сүүлийн жилүүдэд байнга дуулдах болсон. Гэвч ам дамжсан дээрх үг хэлийг нотлох баримт тэр бүр олддоггүй байсан. Тэгвэл махны экспортыг хориглосонтой холбоотойгоор хятад хүмүүс мах их хэмжээгээр бэлтгэдэг нь тодорхой болж байх шиг. Түүнчлэн Таван эрдэнийн маханд хайр зарласан хаврын синдром махны экспортыг хүртэл зогсоож дөнгөлөө. ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунайн хэлснээр бол мал ногоонд цадаж, шинэ мах гартал экспортын хоригийг цуцлахгүй бололтой. Нэг үгээр хэлбэл, махны зах зээлд үүсээд буй үнийн өсөлтийг сулруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд экспортын мах нөлөөлнө хэмээн Засгийн газраас үзсэн хэрэг.

Муу нэртэй нөөцийн мах

Нөөцийн мах хэзээний л муу нэртэй. Жил бүрийн хавар нөөцийн мах тойрсон “нийгмийн хэлэлцүүлэг” өрнөдөг. Сайн муу, чанартай чанаргүй гээд муулдаг. Өнөө жил ч ялгаагүй махны үнэ өндөр байгаагаас үүдэн Цагаан сарын өмнө бараг л дүн өвлөөр нөөцийн махыг зах зээлд нийлүүлж үзсэн ч сайн нэр олсонгүй. Тухайн үедээ иргэдийн нэг хэсэг нь хямд үнэтэй маханд урт дараалал үүсгэн байж Цагаан сарын бууз, баншаа харьцангуй хямд өртгөөр хийсэн ч махны үнийн бөмбөлөг хагарсангүй. Тиймээс ирэх өдрүүдэд үлдсэн нөөцийн махыг жижиглэнгээр худалдахаар бэлтгэж байна. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нэгдүгээр хорооны иргэн, өндөр настан Ш.Содномжамц “Нөөцийн махыг худалдаад байгаа боловч ядарсан бидэнд олдохгүй юм. Уг нь орлого багатай тэтгэврийн хөгшчүүлдээ түрүүлээд олгож байвал зүгээр байна. Мөнгөтэй, танилтай, арын хаалгатай нь л нөөцийн махнаас авдаг болчихсон бололтой” гэв. Содномжамц өвөө цэргийн байгууллагад алба хашиж байсан бөгөөд 10 мянган төгрөгт мах авахаар “Хүчит шонхор” захыг зорьж ирсэн боловч хамгийн хямд нь ямааны мах нэг кг нь 6000 төгрөгийн үнэтэй байсан тул “Яаж хоосон буцах вэ дээ хүү минь, ганц килограмм ч болтугай нь мах авахаас даа. Хоёр орой хоол хийнэ биз” хэмээн урамгүйхэн өгүүлэв.

Монголчууд үнийн өсөлтөд дарамтлуулж буйг зөвхөн махны үнээс л харж болох юм. Уг нь бол дотооддоо зуун хувь үйлдвэрлээд, экспортолдог ганц бүтээгдэхүүн нь шүү дээ. Гэтэл нэг кг махны үнэ хэдхэн сарын дотор бараг хоёр дахин өссөн хэрэг. Төр, засаг нөөцийн мах тэдийнхнээр махны үнийн өсөлтийг аргалчихна гэж сэрүүн зүүдэлсээр суувал махны үнийн өсөлт улам гаарч, “дайн” дэгдэхийг ч үгүйсгэхгүй. Нэг кг махны үнэ 10,000 төгрөгт хүрэхэд л байдал эвгүйдэх нигууртай. Тэвчинэ тэвчинэ гэхэд яаж тэвчих вэ дээ гэдэг шиг ганц импортоос хараат бус бүтээгдэхүүнээ тэнгэрт тулсан үнээр удаан хугацаанд авч идэж үнэхээр дийлэхгүй, монголчууд.

Махны үнийн өсөлтийг олон зүйлээс хайх шаардлагагүй гэдэг нь ч зах зээл

http://www.mongolianeconomy.mn



Монгол Улс өнгөрсөн оны төгсгөлд 36.3 сая толгой мал тоолуулсан

дээр болж буй шил шилээ дарсан үйл явдлаас тов тодорхой харагдаж байгааг төр, засгийнхан гадарладаг л байлтай.

Хэдийгээр Монгол Улс малаар баян орон ч гэлээ дэд бүтцийн хөгжил дэндүү сул учраас хотоос алслагдмал аймаг, орон нутгаас хүсээд ч мах ирэх боломжгүй юм. Туувар гэж бараг байхгүй болсон. Баруун аймгаас сайн дураараа малаа борлуулахаар малчдын зарим нь ирээд, нийслэлийн 22-ын товчооны цаана тал бүрээсээ хавчиж шахуулж, хөөгдсөөр сүүлдээ амиа авч гарах нь холгүй болдог учраас одоо холын аймгаас хот руу мал тууж зүрхэлдэг хүнгүй болсон гэж үзэж болно. Хотын ойролцоох аймаг, орон нутгийн малчдын хотноос нь махны ченжүүд бараг жилийн дөрвөн улирлын турш салдаггүй гэхэд хилсдэхгүй. Ченжүүдийн хувьд арайхийн олсон махаа аль болох өндөр үнээр зарах гэж улайрдаг. Гэтэл төр, засгийн хараа мөнөөх л зохицуулалт хийж болохгүй юм байна гэдэг нь олон жилийн өмнөөс тодорхой болсон нөөцийн махнаасаа одоо хэр нь давж харж чадахгүй сууна. Тэд малаар баян монголчуудаа махаар өлсөхийг нэг их асуудал биш гэж үзээд тайван суугаад байна уу, эсвэл үнэхээр алсыг харах тэнхэлгүйдээ мэдэн будилаад сууна уу гэдэг л байна.

Махны үнийн асуудалд төрийн бодлого үнэхээр үгүйлэгдэж байгаа нь цаг хугацаа өнгөрөх тусам тодорсоор. Хятадын Засгийн газраас авах зээлийн тодорхой хэсгийг махны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулна гэж ярьж, зарим холбогдох тендер нь зарлагдаад явж байгаа дуулдсан. Тэгвэл зөвхөн үйлдвэр барихад биш, энэ салбарын логистик болоод дэд бүтцийг хөгжүүлэх том зургийг хаана хаанаа хараасай билээ. Энэ талаар мэргэжлийн хүмүүс ямар бодол тээж яваг сонирхуулъя. Монголын мах үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал М. Лхачинбал “Улаан буудайн сан гэдэг шиг махны нөөцийн сан гэж төрд байх ёстой. Махны нөөцийн санг бий болгоод тэр сангаасаа жил бүр махны үйлдвэрүүдтэй гэрээ байгуулж, урьдчилж мөнгөө өгөөд махаа бэлддэг болох хэрэгтэй. Тэгэхгүй бол өнөөдрийн нөөцийн мах бэлтгэж байгаа байдал үйлдвэрлэгчдийг үнэхээр хашраж байна” гэв.

Монголын хүнс, хөдөө аж ахуйн үндэсний ассоциаци /МХХААҮА/-ийн ерөнхийлөгч Р.Мөнхбат “Тахиа, загас, туулайн аж ахуйг хөгжүүлэх ёстой. Махны шат дамжлагыг цөөлөх хэрэгтэй. Улсын нэгдсэн бодлогоор махны чиглэлийн үйлдвэрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх шаардлагатай” хэмээн зөвлөж байна. Тэрбээр “Мах хэрэглэгчдэд хүртлээ 5-6 дамжлага дамжиж байна. Малчны хотноос ченжийн гараар явсаар хамгийн сүүлд хэд нугарсан өндөр үнэтэй мах хот, суурин газрын иргэдийн гарт хүрдэг” хэмээн тайлбарлав.

Мөн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газраас махны үнийн өсөлттэй холбоотойгоор өнгөрөгч нэгдүгээр сард хийсэн судалгаагаар “Махны зах зээлийн өрсөлдөөн шударга бус байгаа төдийгүй төрийн зохицуулалт буруу байна” гэсэн дүгнэлт гаргасныг дуулгая. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, дэд профессор Х.Цэвэлмаа “Махны кластерыг хөгжүүлэх урьдчилсан нөхцөл байдал”-ын талаар хийсэн судалгаандаа “Мах бэлтгэлийн тогтолцоо уналтад орсны улмаас дотоодын хэрэгцээнд болон экспортод шууд худалдах махны хэмжээ дунджаар 40-50 хувиар буурсан” хэмээн тэмдэглэжээ. Тус судалгаанаас үзэхэд энэхүү нөхцөл байдал нь өнөөдрийн махны үнийг хөөрөгдөх, нөөцийн мах хомсдох, махны нийлүүлэлт багасах суурь шалтгаан болсон байна.

Эцэст нь хэлэхэд, уг нь улс даяараа учиргүй махны хомсдолд орж, хүнсний захын лангуу хоосорчихоогүй байна. Бэлчээрийн даац нь хэтрээд буй малтай Монголын махны зах зээлд төр, засгийн зүгээс дорвитойхон, алсыг харсан зохицуулалт хийхэд тийм ч хэцүү биш байлтай. Ямар техник технологи, түүхий эд нь хязгаарлагдмал нефть боловсруулах үйлдвэр байгуулах шийдлийг олох гэж байгаа биш дээ. Тэгтлээ цаг хугацаа авч, оюун бодол чилээх зүйл байхгүй л баймаарсан. Малаар баян Монгол оронд махаар өлсөж амьдармааргүй байна. ■

http://www.mongolianeconomy.mn

Сурвалжлага

Орой унтаж, эрт босох малч ухаан

Б.Алтай

Гурван худгийн нуруу тарлан цастай харагдана. Тал хээрийн бүсэд багтах Төв аймгийн Өндөрширээт сумын нутгийг хаврын дунд сард зорьж, Зүүнгозгорын өвөлжөөнд буй малчин Б.Уламсайханыхаас сурвалжлага хийлээ. Зам дагуух уул, хөндийн цас сэмэрч бараантан цоохортжээ. Айлууд хаваржаандаа буучихсан ажин түжин хол ойр бараа нь тодроно. Уламсайханы өвөлжиж буй Зүүнгозгорын нутаг руу ойртох тусам цас, өвс нь тэнцүүхэн тэнэгэр сайхан хавар болж байгаа нь илт. Хөдөө нутгийн цэвэр цэнгэг агаарт толгой сэргэнэ. Хажууд хонь малын дуу цангинах нь нэн өөриймсөг дотно. Саяхан бэлчээрт гарсан бололтой өвөлжөөнөөс холгүйхэн үхэр сүрэг уван цуван идээшилнэ.

Малчны хотонд нялх төлийн дуу цангинаж, хурга, ишиг тонгочин тоглоод тун чиг аз жаргалтай. Гэрийнхээ гадна бага оврын ачааны “Портер” маркийн машин, Хятадын улаан мотоцикль сойжээ. Нарны дэлгэц, тавган антен нүднээ тусна. Харин морины уяан дээр буурал морь чихээ сортолзуулан, дороо эргэцэх аж. Өвөлжөөний зүүн хөтлөөр хургаа дагуулсан хонь бэлчин налайна. Өндөрширээт сумын нутагт түрүү оны намрын сүүлч сараар их цас унасан хэдий ч өнөтэй өвөлжиж, хавартай золгоод байгаа нь энэ.

Гэрийн эзэн Уламсайхан 30 эргэм насны эр. Хүүхэд наснаасаа мал дагасан, удам дамжсан малчин. Тэрбээр мал маллаад 20 гаруй жил болж байгаа гэнэ. Хашаа хороо, гэр орон нь цэмцийж, гялалзсан сүрхий ажилсаг хүмүүс бололтой. Гэрийн эзэгтэй З.Байгальмаагийн чанасан цайг уух зуураа нутаг усны сонин сайхны талаар хуучиллаа. Тэднийх гурван охинтой. Том охин У.Намуунцэцэг нь энэ жил 11 дүгээр ангиа төгсөх бол отгон охин нь ирэх жил сургуулийн өмнөх бэлтгэл ангид элсэх аж. Харин дунд охин У.Бэрцэцэг нь долдугаар ангийн сурагч. Хоёр охин нь хотод сургуульд сурдаг юм байна. Дөрвөн настай отгон охин Хонгорзул нь хонь мал, хот хороотой ойр өсөж байгаа болоод ч тэр үү биедээ ахадсан хэрсүү зантай. Түүнийг гэрийнхэн нь хургачин Хонгороо гэж хочилдог. Сургуулийн хүүхдийн улирлын амралт эхэлсэн тул тэднийх халуун ам бүлээрээ цуглаад байгаа ажээ.

Сүүлийн хэдэн өдөр салхи сэвэлзээд цаг агаар таагүй байсан. Харин өнөөдөр харьцангуй тогтуун байна. Тэнгэрийн сайхныг ашиглаад хэдэн ямаа самнаад авъя гээд Уламсайхан нялх хурга, ишгээ ялгахаар гарлаа. Тэдний хонь гуравдугаар сарын 1-нээс хургалж эхэлсэн бол ямаа нь саяхнаас төллөж байгаа гэнэ. Энэ хавар 100 гаруй ямаа төллөх бөгөөд мөн тооны хонь хургалах аж. Ямаа нь энэ жил их ихэрлэж байгаа тухай гэрийн эзэн сонирхуулсан.

Уламсайханы төрсөн дүү Б.Цэнгэлсайхантай айлсан өвөлждөг. Ах дүү өрхүүд удахгүй хаваржаандаа салж буух аж. “Хаврын тарчиг цагт олон мал ногоонд цадахдаа муу байдаг” хэмээн малч ухаанд суралцаж яваа залуус дуу нэгтэй хэллээ. Ах дүү нарын бог мал нийлээд 800 гаруй тоо толгой аж. Цэнгэлсайхан гүвээ давсан хургатай хонио ойртуулахаар мордов. 2001 онд цэргийн алба хаасан Цэнгэлсайхан нутгийн бүсгүй Г.Даваадолгортой ханилан суужээ. Шавилхан биетэй энэ бүсгүй малынхаа хашаа хороог цэмцийтэл нь шүүрдэх аж. Өдөрт Цэнгэлсайхан, Даваадолгор нар 10 ямаа төвөггүйхэн самнадаг гэсэн. Эднийх өнгөрсөн жил нэг кг ноолууруаа 67 мянган төгрөгөөр өгсөн бөгөөд хоёр сая гаруй төгрөгтэй болжээ. Залуу хосууд ноолуурын мөнгөөрөө өөрсдийн амьдралд тустай нэг том зүйл авдаг гэж байв. Нэг ямаанаас дунджаар 300 грамм ноолуур гардаг. Эр ямаанаас бол нэг кг хүртэл ноолуур гарах нь ч бий гэнэ. Цэнгэлсайхан хурдан моринд тун хорхойтой нэгэн. Түүнээс малч ухааны талаар асуухад “Орой унтаж, эрт босохыг хэлнэ” хэмээн товч бөгөөд тодорхой хариулсан.



Хургачин Хонгороо

Хонь мал төллөх үеэр шинэ төлөө амлуулахаас эхлээд ямаагаа самнах, хашаа хороогоо цэвэрлэх гээд малчин хүний ажил дуусч дундрахгүй. Хаврын ажлынхаа ард арайхийн гарангуут зуны их ажил угтдаг тухай тэд ярьж байсан. Хэдийгээр зуны дэлгэр цаг айлчилсан ч үхэр, адуугаа байнга л харуулдаж байхгүй бол малын хулгай шөнө бүтэн нойртой хонуулахааргүй хүндрэлтэй асуудал болсон талаар Цэнгэлсайхан ярьсан юм. Мөн тэрбээр “Орчин үед

http://www.mongolianeconomy.mn



Фотог Э.Зоригт

гар утас ажил амжуулдаг нь сайхан ч малын хулгайч нарын хувьд хууль бус үйлдэл хийдэг гол хэрэгсэл нь болж байгаа нь бас таагүй зүйл" гэлээ.

Малч ухаантай, ажилсаг залуус аав, ээжийнхээ багаас нь олгосон хүмүүжлээр яваа хэрэг. Тэдний аавыг Ж.Балжням, ээжийг нь Ш.Чулуунцэцэг гэдэг. Тэд ерээд оны эхээр Нэгдлийн малыг хувьчлах үеэр малчин болжээ. 20 гаруй жил мал малласан хоёр хөгшин хүүхдүүд нь том болж, туурга тусгаарласан учраас өвөл хотод ирж өвөлжөөд, зуны дэлгэр цагт хөдөө гардаг байна. Биднийг очих үеэр ТЭд хүүхдүүдээ эргэж түр ирээд байгаа аж. "Нэг хэсэг баруун аймгийн малчид манай суманд их ирсэн. Чиний, миний гээд буудал буцаа булаалдах байдал их гарна. Харин сүүлийн хоёр, гурван жилээс баруун аймгаас ирэх шилжилт хөдөлгөөн багасаад байгаа" хэмээн Уламсайхан ярив. Өндөрширээтийн Гурванхудагийн нуруу нь отрын бүс нутаг юм байна. Отрын бүс нутаг дотроо адууны отор хийхэд тун тохиромжтой. Тиймээс хаврын хуйсагнуур өдрүүдэд эндэхийн малчид малаа Гурванхудагийн нурууг бараадуулан байлгах дуртай аж.

Ах дүү хоёрын зуслангийн газар нь баруун аймаг руу явах төв замаас холгүй. Малчид машин тэрэг хөлхсөн төв замтай ойр байхаас царгалдаггүй нь цаанаа учиртай. Зуны цагт айраг, цагаан идээгээ борлуулах гэж тэр. Бидний залуу малчидтай хөөрөлдсөн яриа өрхийн аж ахуйгаас улс орны хөгжлийн бодлого руу хүртэл хазайлаа. "Хүний хөгжил сан"-гийн 21 мянган төгрөг малчны амьдралд хэр тус нэмэртэйг асуусан юм. Уламсайханых

http://www.mongolianeconomy.mn

зургаан ам бүлийн 21 мянгаа бөөнөөр нь авдаг тухай эзэгтэй Байгальмаа ярилаа. Эдний гэр бүл хуримтлалын данстай бөгөөд 21 мянгынхаа заримыг нь хүүхдийнхээ ирээдүйн боловсролд зориулахаар хадгалдаг гэнэ. Харин Чулуунцэцэг “Манай суманд зөвхөн 21 мянган төгрөг дээр амьдрал нь тогтдог улс олон бий” гэв. Малчид нарны зайн эх үүсвэртэй учраас зураг үзнэ, хөргөгч, угаалгын машин ажиллуулна. Тэд ертөнцийн хаана нь юу болж байгааг хотын иргэдээс ч дутахгүй мэдээлэлтэй байдаг болжээ. Адуу малны эрэлд ч нэг их яваад байдаггүй, гар утсаараа сураглаад мэдчихдэг байна.

Улаанбаатарт махны үнэ огцом өсөж байгааг махны худалдаа эрхэлдэг ченжүүд хэлэхдээ хөдөө орон нутгаас үнэтэй орж ирж байна. Малчид малынхаа үнийг өсгөөд байгаа гэсэн шалтгаан тоочдог. Тэгвэл малчдын энэ талаар ярьж байгаа нь бодит байдлаас арай өөр байна. Тухайлбал, Уламсайхан “Эр хонь манай нутагт өнөөдрийн байдлаар





Б.Уламсайханы гэр бүл

дунджаар 85-90 мянган төгрөгийн үнэтэй л байна. Гэтэл зурагтаар харж байхад Улаанбаатарт Цагаан сарын үеэр ууцыг л гэхэд малчны хотонд байгаагаас 2-3 дахин өндөр үнээр зарж байгаа харагдсан. Махны үнийн хувьд бодит байдалтайгаа нийцэхгүй байгаа юм. Үнэхээр малын үнэ өсөөд, бид тэр ашгаа хүртэж байгаа бол өөр хэрэг шүү дээ. Малчдын амьдрал дээшилнэ шүү дээ” гэв.

Залуу малчид зөвхөн малынхаа ашиг шимийг харж суухыг хүсдэггүй байна. “Ажил хийвэл ам тосдоно” гэгчээр мал өсгөж үржүүлэхийн сацуу хийж чадах боломжтой бүхнийг

Бонд

Өртэй, өргүйн хооронд

Террэнс Эдвардс
/ “Mongolian Economy” сэтгүүлийн англи хэлний редактор/

Тавантолгойн орд газрын үнэт цаасыг иргэд гартаа атгах цаг ойртож байгаа ч үйл ажиллагааны хувьд тус ордыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй бололтой. Учир нь, газрын гүнд буй түүхий нүүрсийг хэн ч хаана ч ашиглаж чадахгүй. Хэдийгээр олборлосон нүүрс бага ч гэсэн үнэд хүргэх үүднээс үүнийг боловсруулах шаардлага гарна. Боловсруулах бэрхшээлийг даван туулаа гэж бодоход хэрэглэгчдэд хүргэнэ гэдэг бас нэг төвөгтэй ажил угтаж байна. Нүүрс үйлдвэрлэлийн салбарт тулгамдаж буй асуудлын нэг нь дэд бүтцийн хөгжилтэй холбоотой юм. Хэдийгээр нүүрс боловсруулалтын ажилд ахиц гарч байгаа боловч боловсруулах тоног төхөөрөмж, төмөр зам болон Хятад-Монголын хилийн зааг дээрх дэд бүтцийн дутмаг байдлаас үүдэн нүүрс олборлож байгаа шигээ хурдан борлуулдаггүй аж. Өнгөрсөн жил “Эрдэнэс Тавантолгой” ХХК нэг сая тонн нүүрс олборлосон хэдий ч үүнийхээ зөвхөн тал хувийг л Хятадын худалдан авагчдад нийлүүлжээ. Тус компани олборлосон нүүрсээ өөрсдөө боловсруулж чадахгүй л бол уурхайн нүүрсний үнэ цэнэ “шаварт хутгагдана”.

“Coal Mongolia 2012” хуралдааны үеэр Монголын өмнөд хэсгийг Хятадын хилийн боомттой холбох төмөр замын өргөтгөлийн ажлыг 2017 он гэхэд дуусгахаар төлөвлөсөн, мөн уг бүтээн байгуулалтын эхний хэсгийг эхлүүлэхэд бэлэн болсон тухайгаа Монголын уул уурхайн корпорациас мэдэгдсэн. Өргөтгөлийн хоёр дахь шат Дорнод аймгийг чиглэх бөгөөд Засгийн газрын удирдлага дор явуулах аж. Харин хоёр дахь шатны өргөтгөлийн ажил хэзээ дуусах нь тодорхойгүй байна. Эдгээр төслийг үргэлжлүүлэхэд тулгамдаад байсан санхүүжилтийн асуудлыг Засгийн газар өрийн бичиг арилжаалах замаар шийдвэрлэх юм. Монголын Хөгжлийн банкнаас гаргасан 580 сая ам.долларын бонд нь урд өмнө нь дэлхийн аль ч улс, орон хийж байгаагүй өрийн бичиг борлуулах оролдлого бөгөөд гол зорилго нь Монголын бизнесийн болон хөгжлийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэх аж.

“Би чамд өртэй шүү”

Монголчууд бондын арилжааны талаар тун ядмаг мэдлэгтэй нь төслийн багийнхны хувьд шүдний өвчин болоод байна. Монголын хувийн хэвшлийн салбарт чухал үүрэг үзүүлэх

http://www.mongolianeconomy.mn





эзэмшиж амьдарна гэсэн зарчимтай аж. Тиймээс өнгөрсөн зун зусландаа чацаргана, нарийн ногоо тарьсан нь сайхан ургажээ. Мөн Уламсайхан эхнэр Байгальмаатайгаа буриад гутал урлаж, өөрсдийнхөө болоод ойр дотнынхоо хүмүүсийн гутлын хэрэгцээг хангачихдаг уран гартай. Саяхан болсон Төв аймгийн цагаан идээний үзэсгэлэнгээс Байгальмаа сүү, цагаан идээний төрөлд "Хэрэглэгчдийн найдвартай түнш" гэсэн алтан медаль авсан байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын малчдын хувьд бензинийг голдуу шагийн үнээр худалдаж авдаг гэнэ. Сумын шатахуун түгээх станцад бензин болоод дизелийн түлшний аль нь ч байдаггүй учраас А-80 бензин нэг литрийг нь 2500, дизелийн түлшийг 3000 төгрөгийн үнээр хувь хүмүүсээс авдаг хэмээн Цэнгэлсайхан хэлсэн юм.

Шинэ төлийн дуутай хөдөө нутагт хаврын улирал тэнэгэр эхэлж байна. ■

хүчин зүйл нь хувьцааны худалдаа. Тэгвэл "Эрдэнэс Тавантолгой" ХХК Монголын иргэдийг хувьцаа эзэмшигч болгосон. Гэсэн хэдий ч үнэт цаас, өр хоёр тэс ондоо ойлголт юм. Хувьцааны арилжааг морьтой зүйрлэвэл энэ нь "Хүчит дөрвөн туурайтай, хөнгөн шингэн явдалтай..." гэж магтаал байдаг боловч үргэлж унах эрсдэлийг дагуулдаг. Харин бондын арилжааг тэмээтэй зүйрлэвээс, ийм төрлийн худалдаа нь удаан боловч бат найдвартай байдаг. Гэсэн хэдий ч тэмээ маллаж үзсэн хүн тайван дөлгөөн төрхтэй энэ амьтан бас урьдчилан таашгүй зантай болохыг хэлэх биз ээ.

"Бонд гэх ойлголт нь өрийн бичиг л гэсэн үг. Өнөөдөр би танаас мөнгө зээлээд, хэзээ нэгэн цагт төлнө гэсэнтэй ижил" хэмээн бондын арилжаанд оролцож буй ING банкны Хөрөнгө оруулалтын хэсгийн дарга Ховард Ламберт хэлжээ. Тэрбээр өрийн бичиг, үнэт цаас хоёрын гол ялгаа нь үнэ цэнэдээ бус стратегидээ оршдог хэмээн тайлбарласан юм.

Улсын төмөр замын сүлжээг өргөтгөх зорилгоор Засгийн газар бонд гаргах үүргийг өнгөрсөн жил Хөгжлийн банкинд даалгасан. Харин тэд гарах үр дүнг төлөвлөснөөс өөр байна гэж таамагласангүй. Засгийн газар тэрхүү бондыг зөвхөн дотооддоо борлуулахаар зэхэж байсан ч Сингапур улсын зах зээлд худалдаалагдах болсон байна.

Өнгөрсөн зун Сангийн яамнаас гаргасан 300 тэрбум төгрөгийн бондыг дотоодын зах зээл дээр арилжаалахыг оролдсон. Эдгээр бонд нь ноолуурын салбарыг 100 тэрбум, ноосны үйлдвэрлэлийг 50 тэрбум мөн жижиг, дунд үйлдвэрлэлийг 150 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэх зорилготой байж. Анх долдугаар сард зарлагдсан үгбондыгнаймдугаар сарын 9-нөөс аравдугаар сарын сүүлч хүртэл арилжаалсан ч зөвхөн тал хувийг нь л худалдаалж дөнгөсөн юм. "Одоогийн гаргаж буй бондын худалдааг өнгөрсөн зуныхтай харьцуулж авч үзэх нь сайхан санаа мэт боловч дорвитой өөрчлөлт харагдахгүй" хэмээн Ламберт хэлсэн. Тэрбээр "Эдгээр бондыг хооронд нь харьцуулшгүй. Сүүлд гаргасан бондын арилжааг зөвхөн олон улсын зах зээлд түгээхээр боловсруулсан гэдгээрээ онцлогтойг тэмдэглэсэн.

Асуудлын мөн чанар

Бондын зах зээлтэй "дотно" бус

http://www.mongolianeconomy.mn



хүмүүст эргэлзээ төрүүлэхүйц хэд хэдэн асуудал бий. Euro Medium Term Note гэх нэртэй хөгжлийн банкны бонд нь үнэндээ еврогоор гэхээсээ илүүтэй ам.долларааp арилжаалагддаг. Монголын Хөгжлийн банкнаас гаргасан эдгээр бондыг Засгийн газрын бонд гэж томьёолох нь үнэнд нийцэхгүй. Учир нь, бондыг Сангийн яам батлаагүйд оршино хэмээн Хөгжлийн банкны захирал Л. Болормаа хэлсэн байдаг. Засгийн газрын бондын адил татваргүй, хувь ногдолгүй тул тэдгээрийг "хагас бие даасан бонд" хэмээн нэрлэвэл Засгийн газрын бонд гэдэг ойлголттой дөхөм болох гэнэ.

Засгийн газар батлан дааж буй учраас нэр хүндтэй нь салшгүй холбоотой болохыг Болормаа хэлсэн. Монгол Улс одоогоор дундаж болон ядуурлын үнэлгээний төвөөс "BB-" үнэлгээ, Moody's Investors Service "B1" гэх үнэлгээг тус тус авсан нь Засгийн газрын бондыг "хог" болгоход хүргэж байгаа юм. Гэхдээ энэ нь тэдгээр бонд үнэ цэнэгүй гэсэн үг биш юм. Харин ч эсрэгээрээ байх аж. Хэдийгээр олон улсын үнэлгээгээр Монгол Улс зээлээ буцаан төлөх магадлал багатай орны тоонд орж байгаа ч "AAA" үнэлгээг авсан ХБНГУ зэрэгтэй ижил түвшинд байгаа гэнэ. Банк болон санхүүгийн салбарын ил тод байдал дутмаг, Засгийн газрын хөрөнгийн асуудал, бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээнээс хамаарах эдийн засаг зэрэг нь энэхүү үнэлгээний гол шалгуур болдог байна. Үнэлгээний доогуур үзүүлэлттэй улсын хувьд хөрөнгө оруулагчдыг татахын тулд өндөр хүүтэй бодлого баримтлах шаардлагатай.

ING болон бусад холбогдох банкуудын дараагийн алхам нь үнэт цаасыг зах зээлд гаргах. Худалдаа хөгжлийн банктай хэлэлцээр хийж буй ING нь Монгол Улсад бондын арилжаа хийж байгаа цорын ганц банк болохыг Ламберт хэлсэн. Тэрбээр Хөгжлийн банктай хамтарсан явдал нь тун ахицтай байгаа тэдийгүй Ламберт болон түүний баг хамт олон Монголын хөрөнгийн зах зээлийг сонирхож буй пүүс, компаниудын жагсаалтыг гаргаад амжжээ.

Хөгжлийн хурдыг "аахилуулсаар"

Ийм төрлийн үнэт цаасны арилжаа амжилтад хүрэх эсэх нь хөрөнгө оруулагчид Монгол Улсад хэр "итгэж" байгаагаас шалтгаална. Евро бүсийн болон бусад эдийн засгийн хямрал тэдэнд тийм ч их хүндрэл учруулсангүй. Зах зээлийн нөхцөл байдал үүнд чухал үүрэгтэй. Тухайлбал, өнгөрсөн зун "AAA" зэргээс "AA+" болон буурсан Америк улсын Дундаж болон ядуурлын түвшний үзүүлэлт болон евро бүсийн хямралаас үүдэн Азийн орнуудын үнэт цаас моодонд орсон. Хөрөнгө оруулагчдын хувьд америк доллар, еврогийн тогтворгүй байдал нь хувьцаа нь үнэгүйдэж буй компаниудад хөрөнгө оруулахаас илүү Азийн орнуудын Засгийн газраас гаргаж буй бондод хөрөнгө оруулах нь найдвартай мэт харагдсан.

Монгол Улсын хувьд гадаад зах зээлд гарах нөхцөлийг Хөгжлийн банкны бонд бүрдүүлж байна. Үнэт цаасны арилжаа амжилттай хэрэгжиж хуучин болон шинэ хөрөнгө оруулагчдыг татна гэдэгт найдаж байгаагаа Болормаа илэрхийлжээ. Хэдийгээр уг бондыг Засгийн газраас албан ёсоор гаргаагүй ч Өмнөд Солонгос, Энэтхэг зэрэг олон улс орон ийм аргаар үнэт цаас гаргаж байсныг тэрбээр онцолсон юм.

Мөн тэрбээр "Филиппин, Вьетнам зэрэг улс бидэнтэй адил журмаар үнэт цаас гаргаж байсан. Анхны үнэт цаасны арилжаа болон түүний урьдчилсан нөхцөл хоёрыг ялгах хэрэгтэй. Энэ нь хэрэв зээлдэгч өмнөх зээлийн өрийг цаг бүрт нь төлж байсан бол тухайн хүний орлогын хэмжээ хэд ч байсан зээл нэхэмжлэхэд чухал нөлөө үзүүлэхгүй гэсэн үг" хэмээн ярьсан.

Бонд арилжаалах цаашдын ирээдүйд уян хатан чанар олгож байгаа нь энэхүү төлөвлөгөөг сонгон хэрэгжүүлэх гол шалтгаануудын нэг болжээ. Хэрэв төмөр замын төслийг өргөжүүлэх болвол эсвэл Засгийн газар мөнгөн сан бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл өрийн бичгийн төлөвлөгөөний гарын авлагыг Euronote-ийн үнэт цаасны санамж бичгийг ашиглан эдгээрийг хэрэгжүүлж болох нь ээ. Банк үнэт цаасны арилжааг 600 сая ам.долларааc 800 сая, тэр ч бүү хэл нэг тэрбум ам.доллар хүртэл өсгөх боломжтой. Мөн төлбөрийн хугацаанаас өмнө бондыг урт болон удаан хугацаагаар гаргаж болно.

Уул, уурхайн компаниудад тулгарч буй дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхийн тулд төслийн багийнхан уртхан замыг туулах болно. Гэхдээ энэ удаагийн бондын арилжаа нь хөрөнгө оруулагчдад уул уурхайн компаниудын хувьцааг дам хэлбэрээр худалдаалах бус, харин шууд аргаар Монгол Улсын хөгжилд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж байгаа юм. Одоогийн санал болгож буй бондын арилжааны хэтийн төлөвт сэтгэл хангалуун байгаагаа Болормаа илэрхийлэхийн зэрэгцээ ирээдүйд томоохон төслүүд санаачилвал илүү олон бонд борлуулна гэдэгт илтгэлтэй байна гэсэн юм. Тэрбээр "Энэ жилийн, тэр дундаа зах зээлийн бондын бүрдүүлэлт, маш эерэг эхэлж байна" гэв.

http://www.mongolianeconomy.mn

Өрийн зах зээлийн эрчимт урсгал

ING банкны Ховард Ламберт “Бондын арилжаа гэдэг нь хувьцааны арилжаанаас өөр зүйл бөгөөд нэг салбарын мэргэжилтэн нөгөө нэг худалдааны салбарт амжилт гаргахгүй байх нь бий” хэмээсэн. Аль аль талдаа эерэг, сөрөг үр дагавар гарч болно. Гэхдээ бондын арилжаа нь илүү найдвартай бөгөөд урт хугацааны ашиг авчирдаг гэдэгтэй маргах эдийн засагч ховор биз ээ. Компанийн бүтцийн хувьд авч үзвэл бонд эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдээс давуу эрхтэй байдаг тул бондыг найдвартай гэж хэлж болно. Учир нь, компаниуд өрийн бичиг хийгээд үнэт цаасны аль алийг нь худалдаалдаг. Хэрэв ямар нэг байгууллага төлбөрийн чадваргүй болох эсвэл дампуурлаа зарлах болвол өрийн бичиг эзэмшигчдийн хохирлыг нэн тэргүүнд барагдуулдаг.

Бондын хамгийн чухал гурван хүчин зүйл нь бондын хүүгийн төлбөр, татварын нийт дүн, үнэ болно. Бондын хүүгийн төлбөр гэдэг нь худалдаалагч бонд худалдан авах үедээ купон буюу тасалбар хүлээн авах бөгөөд хувь эзэмшлээ тэрхүү тасалбараар солин авдаг юм байна. Купон, төлбөрийн хугацаа хоёр харьцангуй тогтвортой байхад үнэ ханш зах зээлийн байдлыг дагаад өөрчлөгдөх нь бий. Харин татварын нийт дүн гэх ойлголт нь худалдаалагчын тухайн үед арилжаалсан төлбөрийн буцаалтыг төлөөлөх ба зах зээлийн ханшаас урвуу пропорционалиар явдаг аж.

Өөрөөр хэлбэл, татварын нийт дүн гэдэг нь бондын хүүгийн төлбөрийг үнийн ханшид хуваасан үзүүлэлт гэсэн үг. Ерөнхийдөө төлбөрийн хугацаа дуусах хүртэл бондын ашиглах хугацааг тодорхойлох олон хүчин зүйл байдаг ч эдгээр нь татварын хүүгийн дүнг тооцоход хүндрэл учруулдаг. Хэдийгээр хүүгийн хэмжээ тогтвортой байдаг боловч үнэ ханш ийм байдаггүй тул татварын нийт дүн үүнийг даган хэлбэлздэг. Татварын хэмжээ болон татварын нийт дүн хоёр үндсэндээ адил утга агуулах тул хөрөнгө оруулагчид үүнийг ижил түвшинд авч үздэг. Татварын нийт дүн зах зээлээ даган өөрчлөгддөг учир, үнэ буурсан тохиолдолд энэ нь буурдаг. Хөрөнгө оруулагч ижил хэмжээний ашигт бага төлж байхад шинэ хөрөнгө оруулагч тухайн бондын ашигт их хэмжээний мөнгө зарцуулсан байх жишээтэй.

	Нийт өртөг	2012	Хувь, багцаар
Зам барилга	845.74	375.84	29.0%
Зам төлөвлөлт	11.06	6.30	0.5%
100,000 айлын орон сууц	132.70	37.65	2.9%
6 хувийн зээлийн хүү	200.00	200.00	15.4%
Инженерийн хэрэгсэл	108.60	57.36	4.4%
Төмөр зам	521.00	521.00	40.1%
Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор	40.00	40.00	3.1%
Төр хувийн хэвшлийн түншлэл	60.00	60.00	4.6%

Монголын Сингапурын зах зээлд борлуулагдаж буй бонд нь томоохон байгууллагуудад зориулагдсан тул одоогийн байдлаар бие даасан худалдаачид тус бондоос хувь хүртэх боломжгүй ажээ. Гэхдээ Монгол Улс эдийн засгийн хувьд чадвартай, бондын арилжаанд идээших тэр цагт бондын хувь хүртэх боломж хүн бүрт нээлттэй болох биз ээ. ■



Ч.Отгочулуугийн булан

Маркс философич уу, эдийн засагч уу?

Бага ангид сурч байх үеийн дурсамжинд минь сахал үсэндээ баригдсан хоёр герман эр, дээр нь халзан толгойтой Ленин гурвын зураг бүдэгхэн хэрнээ томоохон байр суурь эзэлдэг. Тэдний зураг бас толгойг нь дүрсэлсэн баримлын өмнө ёсолж, улаан бүч зүүж пионер болж байлаа. Маш их баярлаж байсан. Карл Маркстай танилцсан түүх нэг иймэрхүү буюу одоогийн зарим хүүхэд Будда эсхүл Христтэй танилцаж байгаатай төстэй. Социалист Монгол Улсад Марксгүй зүйл ховор байсан байх. Ямар сайндаа л “Мал маллахаа Марксаар заалгахгүй” гэсэн хэдэр үгийг малч өвгөн хэлсэн гэсэн яриа байдаг. Дунд ангид сурч байхад ардчилсан хувьсгал өрнөж, өнөөх Маркс маань хүчирхийллийг сурталчлагч, ангигүй гэгдэх утопи нийгэм байгуулахын тулд люмпен пролетарийг турхирагч гэх зэргийн ойлголт авч эхэлсэн. Гинжнээс өөр алдах юмгүй пролетари анги, бүх дэлхийд ялах улаан коммунизм энэ тэр гэсэн ойлгоход бэрх зүйл бичдэг байсан нь аргагүй байж гэсэн шүү юм бодсоор тэгсгээд мартсан даа.

Дараа нь оюутан болж, Философийн хичээл сонслоо. Формацийн онолыг үндэслэгч гэсэн утгаар Марксыг үзсэн санагдаж байна. Тэгээд насаараа Марксизм судалсан гэгдэх багш шалгалтад хэр хатуу шүүдэг вэ гээд урьдчилсан тандалт хийтэл, өмнөх курсын ▸▸

http://www.mongolianeconomy.mn

маань нэг залуугийн паян чих дэлсдэг юм байна. Оюутнуудын дунд тарсан яриагаар бол өнөөх оюутан Карл Марксын тухай ярина уу гэсэн билет (асуулт) сугалж л дээ. Тэгээд "Маркс зүгээр л нэг эдийн засагч" шүү дээ гэж хэлж багшийг уурлуулаад хөөгдөж гарсан гэдэг. Тэр цагаас хойш Маркс эдийн засагч уу, эсвэл философич уу гэсэн асуултыг сонирхдог болсон юм.

Маркс гэж хэн байв аа? Еврей гаралтай гэр бүлд өсч хүмүүжсэн тэрбээр еврейн шашны номлогчийн охинтой гэрлэжээ. Эхнэр нь долоон удаа төрсөн ч ердөө гурван охин нь л хүн болж. Өтөл ахуй цагтаа бас нэг охиноо алдаж гашуудаж байсан байна. Ид хийж бүтээх насандаа байнгын мөрдлөг, хавчлагын дор цагаач байдалтай, өвчинд ээрээстэй амьдарч байжээ. Гэрийн үйлчлэгчтэйгээ учир ургуулж нэг хүүтэй болсон байдаг. Гэхдээ орчин үеийнх шиг, тухайлбал "Терминатор" Арнольд Шварценеггэрийн (Калифорни мужийн амбан захирагч асан) гэрийн үйлчлэгчээс нь төрсөн нууц хүү илэрч шуугиан тарьсантай адил үйл явдал болсон эсэх нь тодорхойгүй.

Хувь хүн талаасаа тэрбээр алдаа оноогоор дүүрэн, ээдрээтэй амьдралыг туулж. Гэвч шинжлэх ухааны ертөнцөд тэрбээр түүхэн хүний байр суурийг нэгэнт олжээ. Дэлхийд алдартай BBC (Их Британийн БиБиСи телевизийн цахим хуудас) Карл Хайнрих Марксыг өнгөрөгч мянганы хамгийн суут сэтгэгчээр тодруулсан байна. Тэрбээр харьцангуйн онолын Эйнштейн, таталцлын хуулийн Ньютон, хувьсгалын онолын Дарвин болон эрх зүйт төрийн Кант нарыг ардаа орхиж түрүүлжээ.

Марксыг алдаршуулсан гол бүтээл нь түүний нийтлэлүүдийн эмхтгэл болох "Капитал" хэмээх гурван боть зохиол юм. Амьд ахуйдаа тэрбээр эхний ботийг нь л тэрлэж амжсан бөгөөд удаах хоёрыг нь түүний үнэнч анд Энгельс дуусгасан байдаг.

Энэ бүтээлдээ тэд нэмүү өртөг, барааны өртөг, хөдөлмөрийн өртөг болон капиталын өртгийг тодорхойлж, улмаар эдгээр хүчин зүйлс зах зээлд ямар үүрэг гүйцэтгэдгийг тайлбарласан байдаг. Баялаг бий болгож буй эдгээр хүчин зүйлийн зохист тэнцвэр алдагддаг учир, зах зээлийн системийн мөн чанар тогтворгүй. Хямрал зайлшгүй. Капитализмд өөрөө өөрийгөө идэж устгах хүч нуугдаж байдаг. Хэдий хүй нэгдлийн, боолын, феодалын нийгэмтэй харьцуулахад капитализмд олон давуу тал бий ч гол нь нийгмийн баялгийн хуваарилалт бас л шударга бус байдаг гэнэ. Бараа материал олноор үйлдвэрлэхийн тулд, өөрөөр хэлбэл баялаг бий болгохын тулд багаж зэвсэг, мөнгө, хөрөнгө, газар зайлшгүй хэрэгтэй. Эдгээрийг эзэмшиж буй хөрөнгөтнүүд ажилчин ангийн хөдөлмөрийг сорон мөлжих замаар улам баяждаг. Ядуус нь улам ядуурдаг. Элдэв



хямрал, инфляци, ажилгүйдэлд ажилчин анги илүү өртөнө. Капиталист нийгмийн үндсийн үндэс болсон дундаж анги үгүй болж, нийгэм нь эрх мэдэл бүхий хэт цөөнх (буржуй), үгээгүй олонхи (пролетари) гэсэн хоёр хэсэгт хуваагдана.

Мөн улс төрийн шинжтэй бусад нийтлэлүүдээрээ тэрбээр үйлдвэр, банкны эзэд баян хангалуун амьдарч байхад, ажилчид амрах завгүй ажиллаж, өлсгөлөнгийн цалин авч байгааг шүүмжилдэг байв. Хүүхэд, эмэгтэйчүүдийн тэвчишгүй хөдөлмөр ч тухайн үед газар авч байсан нь нийгмийн тогтолцооны гажуудлын үр дүн бөгөөд хүн өөрөөсөө харьжиж (хүнээ алдаж) байна гэж үзжээ. Хөдөлмөрчин хүн үйлдвэрийн түүхий эд болж хувирсаны гол буруутан бол хөрөнгөтөн буюу буржуй нар юм. Буржуй нар төрийг худалдан авах бөгөөд ингэснээр төр, засаг гэдэг нь хөрөнгөтөн ангийн зүгээс ажилчин ангийг дарангуйлж байх хэрэгсэл болж хувирсан гэж үзжээ. Тийм учраас жинхэнэ баялгийг бий болгодог ажилчин анги хувьсгал хийх замаар эрх мэдэлд хүрэх ёстой гэнэ. Улмаар шударга бус хуваарилалтын эх үндэс болсон хувийн өмчийг устгаж, нийтийн өмчийг бий болгоно. Ингэснээр нийгмийн суурь давхарга болсон эдийн засагт үндсэн өөрчлөлт хийгдэх бөгөөд үүн дээр үндэслэн ангигүй нийгэм бий болж, булталараа эв хамтдаа амар тайван жаргаж суух аж.

Европын социалист болон социаль демократуудаас ялгаатай нь Маркс ардчилсан сонгуульд төдийлөн ач холбогдол өгдөггүй байв. Харин интернационалист пролетариудын зөвлөл гэгчээр удирдуулсан



хувьсгалт тэмцлийн ачаар буржуй нарыг (хөрөнгөтөн ангийг) устгах учиртай аж.

Гэвч шинээр байгуулагдаад байсан Германы Социаль демократ намууд түүний онолд авах гээхийн ухаанаар хандсан юм. Баялгийн шударга хуваарилалт, эдийн засаг дахь тэгш эрх, хүүхэд эмэгтэйчүүдийн эрх, шашин эс шүтэх эрх чөлөө, хөдөлмөрчдийн нийгмийн хамгаалал гэсэн олон үзэл баримтлалыг нь улс төрийн номлолдоо ашиглажээ. Харин тэр хувьсгалт тэмцэл, коммунист улс төрийн байгуулал гэх зэрэг шийдлүүдээс нь татгалзсан байдаг.

Философи, улс төрийн сэтгэлгээнд тэрбээр хувьсгалын шинжтэй өөрчлөлт хийж чаджээ. Жишээ нь философи бол танин мэдэх, байгааг тайлбарлах төдий биш харин аливааг өөрчлөх ухаан гэсэн утгатай үгийг хэлсэн байдаг. Ертөнцийг үзэх үзлээ тэрбээр шашны нөлөөгүйгээр томьёолохыг оролдсон байдаг. Бүхнийг мэддэг, хардаг, зохицуулдаг бурхан, эзэн, далдын хүчин, сүнс, санаа гэх зэргээс илүү Материалист диалектик гэсэн хөгжлийн хөдөлгүүр хүний нийгэмд үйлчилдэг аж. Хүн төрөлхтний түүх бол дарлагч ба дарлагдагч ангийн тэмцлийн түүх. Нийгэм хөгжиж шинэ шатанд гарахын тулд тэмцэл зөрчил зайлшгүй. Гэхдээ энэ тэмцлийн түүхийг дуусгаж, тэмцэлгүй шударга нийгэм байгуулах боломжтой. Тэр бол түүнийхээр коммунизм байлаа. Үүний тулд буржуй буюу мөлжигч хөрөнгөтнүүдийг устгах ёстой. Гэхдээ коммунизм руу шууд хүрчихгүй. Эхэлж пролетари анги нь төрийн эрхийг аваад социализм байгуулна. Социалист нийгмийн гол зорилго нь буржуй ангийг устгаж, капиталыг нийтэд дахин хуваарилсан тийм шилжилт байх гэнэ.

Өнөөдрийн өндөрлөгөөс эргэн харахад Маркс тухайн цаг үеийнхээ л бүтээгдэхүүн байж. Тэр үед зэрлэг капитализм хүчээ авч, алдарт Чарли Чаплиний “Хүүхэд” (1921 он) хэмээх кинонд гардаг шиг нөхцөл байдал ноёрхож байсан биз ээ. Түүний хувьсгалт үзэл цаг үедээ үзүүлсэн хариу үйлдэл байсан гэж үзэх үндэстэй. Нөгөө талаас тэрбээр хурц ухаан, шүүмжлэлт сэтгэн бодох чадварынхаа ачаар капиталист нийгмийн оршихуй ба хөгжихүйн зүй тогтлыг тайлбарлаж, улмаар сая сая хүнийг араасаа дагуулж чадсан.

Гэвч түүний онол хэдэн янзаар ойлгогдож бас “туршигдсан” гэж болохоор. Өнөөдрийн төв болон хойд Европын орнуудын нийгмийн баримжаатай зах зээлийн байгуулалд Марксын онолын сүүдэр тусаастай. Герман, Швед зэрэг орнууд коммунизм байгуулаагүй ч, ямартаа ч тэнд хэт хөрөнгөтөн, мөлжигч буржуй нар устаж алга болжээ. Ангийн дайснууд гэгдсэн Буржуй нарыг коммунист хувьсгал биш харин ардчилал, шударга ёс, тэгш боломж устгасан гэж судлаачид үздэг. Европын ихэнх хөгжингүй орнуудад хүчирхэг нийгмийн хамгаалал бүхий асар том дундаж анги оршин тогтнож байна. Хүн авьяас чадлаараа капиталист болох боломж бүрэн нээлттэй.

Хятад, Хойд Солонгос, Куба, Вьетнамд чодоо хэр нь Маркст итгэгч нар хэдэн зуун саяараа тоологдоно. Харамсалтай нь Хойд Солонгост “улаан буржуй” давхарга үүсчихээд байна гэж барууны зарим судлаач үздэг. Өөрөөр хэлбэл, Буддагийн сургаалийг гажуудуулдаг лам нар байдгийн адил, “Марксист бус” Марксист цөөнх нь үгээгүй ядуу ардыг төрийн машин, суртал нэвтрүүлэг, харгис цагдаагийн хүчээр барьж байдаг тогтолцоо Хойд Солонгост оршиж байна гэсэн дүгнэлттэй олонтаа таарч болно.

Орос оронд октябрийн хувьсгал ялаагүй бол монголчуудын хувь заяа огт өөрөөр бичигдсэн байж ч болох юм. Бид мэдэхгүй байна гэдэг байхгүй байна гэсэн үг огт биш. Юу хэлэх гээд байна вэ гэвэл Марксын нөлөө одоо ч бидний амьдралд, гэхдээ бидэнд мэдэгдэхгүйгээр оршсоор байна. Монгол Улс НҮБ-д элссэн, Монгол хүн сансарт ниссэн, МАХН хэмээх байгууллага 1930- аад оны их террор үйлдсэн гэх зэрэг олон үйл явдал Марксын үзэл санааг дагасадтай ямар нэг сэжмээр салшгүй холбоотой.

Хэрвээ Маркс цаг хугацааны машинаар аялаад өнөөгийн Монголд ирсэн бол зарим нэг зүйлийг хэлэх байсан болов уу гэж төсөөлж байна. Жишээ нь, 1921 оны Монгол бол капиталист нийгэм биш ээ. Монголчууд морио барихдаа уурга хэрэглэдэг. Уургыг капиталын үр хөврөл гэж үзье. Тэгвэл Монголд уургыг эзэмшигч хөрөнгөтөн анги бий болоогүй л байв. Адуучин эр (ажилчин анги) ч уургыг булааж авах хувьсгал хийх шаардлагагүй. Мал сүрэг капитал мөн үү? Заримдаг утгаар тийм. Гэвч мал сүрэг өөрөө малчин ангийг мөлжих хэрэгсэл болж чадах уу? Үгүй. 1921 оны Монголын нийгэмд нэмүү өртөг үйлдвэрлэдэг эдийн засаг байв уу? Үгүй.

Гэсэн хэдий ч Марксизм улс төрийн үзэл суртлын хувьд Монголд шашин адил дэлгэрсэн. Харин нийгмийн байгууллыг тайлбарлах гэсэн үндсэн үүргээ гүйцэтгэж чадаагүй л болов уу. Маркс өөрөө аливаа шашин, суртал, өмнөх үеийнхний онол, улс төрийн номлолыг сохроор дагахаас зайлсхийдэг байлаа. Санваартан хадам, идеалист багш, цалинг нь өгдөг ажил олгогчийнхоо нөлөөнөөс өөрийгөө чөлөөлөх ёстой гэж эрмэлздэг байсан нь илт. Тухайлбал, шашин бол ард түмний хувьд мансууруулагч (зовлон зүдгүүрээс зугатахад нь тусалдаг) хар тамхи юм гэсэн алдарт үгээ хэлсэн байдаг. Орчин үеийн хүмүүсийн хувьд энэ нь ойлгоход хялбар боловч харьцангуй шашинжсан тухайн цаг үедээ бас л дэвшилт эсвэл гаж гэмээр тайлбар байлаа.

Төгсгөлд нь “Маркс - Эдийн засагч уу?, философич уу?” гэсэн асуултдаа эргэж оръё. Магадгүй энэ нь “Бүргэд-шувуу юу, жигүүртэн үү” гэж асууснаас ялгаагүй байж болох юм. ■

http://www.mongolianeconomy.mn

http://www.mongolianeconomy.mn



Нью-Йорк группын гүйцэтгэх захирал Б.Бямбасайханыг "Бизнесмэн" буландаа урилаа. Б.Бямбасайхан нь дотоод, гадаадад боловсрол эзэмшиж, гаднын өндөр хөгжлөөс багагүй хугацаанд суралцсан, сүүлийн үед түрэн гарч ирж буй залуу бизнесмэнүүдийн нэг юм. Тухайлбал, АНУ-ын Жорж Вашингтоны их сургуульд суралцаж төгсөөд Америк, Азид 10 гаруй жил ажиллаж амьдраад 2010 онд эх орондоо ирсэн билээ. Тэрбээр төрийн болон хувийн хэвшлийн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт босгох, менежмент хийх, ялангуяа дэд бүтцийн төслийн санхүүжилтийн чиглэлээр арвин туршлага хуриmtлуулсан санхүүч юм. 2004-2010 он хүртэл Азийн хөгжлийн банкинд эрчим хүчний хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр ажиллаж, Төв Азийн Казахстан, Пакистан, Узбекистан, Тажикистан зэрэг хөгжлийнхөө гараан дээр буй орнуудын томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд оролцохын зэрэгцээ цэвэр эрчим хүчний талаарх ойлголт, мэдээллийг Азийн орнуудад нэвтрүүлэх хөтөлбөрийг санаачилж байжээ. Б.Бямбасайхан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрчим хүчний зөвлөх, Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл, Монголын Бизнесийн зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн зэрэг олон сонгуульт ажлын үүрэг хүлээжээ.

Бизнесмэн

Б.Бямбасайхан: Мөрөөдлөө зорилго болгож, түүндээ хүрэх хариуцлага биднийх

-"Ньюком" групп гүйцэтгэх захирлынхаа албанд гадаадад өндөр боловсрол эзэмшсэн залуусыг олж, судалж тавьдаг уламжлалтай гэж хэлж болно. Үүний үргэлжлэл нь Та болж байна. Таны сэтгэгдлийг эхлээд сонсоё?

-Монгол Улс өнөөдөр асар хурдан хөгжиж байна. Энэхүү хөгжлийн ард хамгийн түрүүнд бизнес, бизнес эрхлэгч хоёр байгаа. Бидний чухалчлан авч үзэж, ярьж байгаа асуудал бол яах аргагүй өрсөлдөх чадвар. Энэ нь мөн бизнесийн салбартай зайлшгүй холбоотой. Өрсөлдөх чадвартай байх нь гаднын бусад оронтой өрсөлдөхүйц стандартыг бий болгох гэсэн үг юм. Тэгэхээр олон улсын бизнесийн стандартуудыг мэддэг, туршлагатай хүн өнөөдрийн бизнесийн салбарт амжилт олно. 20 жилийн өмнө зах зээл ямар байсан билээ. Бүх зүйл шинээр эхэлж байлаа. Харин өнөөдөр дотоодын зах зээлийн өрсөлдөөн сайжирч, тэр ч бүү хэл, бид бүс нутаг цаашлаад дэлхий дахинд үйл ажиллагаагаа өргөтгөх боломж, шаардлага тулгарч байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлж чадахгүй бол эрхэлж буй бизнес өсч томрох чадвар буурна гэсэн үг. Ийм л учраас гаднын болоод өөрийн оронд сайн мэдлэг эзэмшсэн дадлага туршлага, эрч хүчтэй

http://www.mongolianeconomy.mn

залуус бизнесийн салбарт хүч түрэн орж ирж байна гэж хэлж болох юм. Өөрөөр хэлбэл, эзэмшсэн боловсрол мэдлэг, туршлагаа эх орныхоо хөгжил цэцэглэлтэд зориулах нь бидний ч үүрэг хариуцлага юм.

-"Ньюком" групп байгальд ээлтэй бизнес эрхлэн явуулж байгаа нь уул уурхай руу хошуурсан өнөөгийн нөхцөлд сайшаалтай санагддаг юм. Цэвэр технологи, өндөр технологи нь "Ньюком"-ын брэнд, нэр хүндийн илэрхийлэл болжээ.

-Монголын эдийн засгийн гол суурь бол монгол хүн. Тиймээс монгол хүнд шинэ шаардлага гарч ирж байна. Манай компани хүний хөгжилд ихээхэн анхаарч ажилладаг. Үүний нэг тод жишээ нь монгол инженерүүдийн мэдлэг, чадварт тулгуурлан бий болсон компани бол "Мобиком". Хэрэглэгчдэд хамгийн хэрэгтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг чанартай үзүүлэх зорилготой. Дэлхийн хөгжингүй орнуудад ашигладаг өндөр технологиудыг монголчууд гар утсаараа дамжуулан ашиглаж байна. Монгол орны газар нутгийн алслагдмал байдлаас үл хамаарч хаанаас ч хэнтэйгээ гар утсаар мэнд усаа мэдэлцэх боломжийг олгосон. Монгол Улс өнөөдөр харилцаа холбооны салбарт бүс нутагтаа өрсөлдөх чадвараар дээгүүрт орсон байгаа. Мөн агаарын тээврийн "Изинис Эйрвэйз" компани маань ойрын үед олон улсын нислэг хийхэд анхаарч, Японын агаарын тээврийн АНА компанитай хамтарч ажиллаж байна. Хоёр орны хэлэлцээрүүд амжилттай болбол том оврын онгоцнуудаа оруулж ирээд энэ зунаас олон улсын нислэг хийхээр төлөвлөж байна. Япон, Солонгос, Хятадын олон хот болон Казахстан руу нислэг үйлдэх төлөвлөгөө байна.

Манай компанийн хамгийн сүүлд хийж буй томоохон ажлын нэг гэвэл цэвэр эрчим хүчний салбар дахь их бүтээн байгуулалт. Ер нь манай компанийн бизнесийг ерөнхийд нь нэрлэвэл "холыг ойртуулж, хоёрыг уулзуулдаг" гэж хэлж болно. Энэ бүх ажлыг өндөр технологи, цэвэр технологийг ашиглаж, үйл ажиллагаагаа явуулдаг нь бидний бахархал юм. Өөрөөр хэлбэл, манай хамт олон байгальд ээлтэй бизнес эрхэлдгээрээ бахархдаг.

-Сүүлийн үед "Салхит" салхин станцыг цэвэр эрчим хүчний сайн жишээ болгодог болсон байна. Их бүтээн байгуулалтын ажлын санхүүжилт саяхан шийдэгдсэн. Ер нь энэхүү том төсөлд хэдий хэмжээний хөрөнгө зарцуулагдах вэ?

-Салхитын 50 МВт-ын салхин станц нь манай эрчим хүчний салбарт нэвтэрч байгаа шинэ зүйл. Дэлхий дахинаа ашиглаж байгаа цэвэр технологийг Монголд нутагшуулж байгаа нь өөрөө шинэ бөгөөд сайхан ажил юм. Уг төсөл нь нэлээд өндөр буюу 165 тэрбум төгрөгийн өртөгтэй. Бид гаргаж авсан эрчим хүчээ төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд нийлүүлнэ. Эрчим хүчний салбарын ихэнх компани төрийн мэдэлд байгаа өнөө үед хувийн хэвшлийнхэн энэ салбарт орж ирж байгаа нь уг бүтээн байгуулалтын бас нэг онцлог юм.

-Санхүүжилтийн асуудлыг шийдэх нь амаргүй. Тэгээд салхины эрчим хүчний хувьд анхны том төсөл. Та бүхэн багагүй бартаа саадыг туулж санхүүжилтээ шийдсэн байх даа?

-Санхүүжилтийн асуудал үнэхээр амаргүй ч ийм хэмжээний санхүүжилт олоход нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйл бий. Тухайлбал, 2007 онд батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль байна. Сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагч талд тодорхой үнийн зохицуулалтын асуудлыг энэхүү хуульд оруулж өгсөн нь нөлөөлсөн. Мөн манай төр, засаг 2020 он гэхэд Монгол Улс нийт эрчим хүчнийхээ 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангана гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэ бүх зорилго, дэмжлэгийн үндсэн дээр бид Засгийн газар, "Европын сэргээн босголт хөгжлийн банк", "Женерал электрик", "Мянганы сорилтын сан", Голландын Засгийн газрын хувийн хэвшлийг дэмждэг FMO банк зэрэг байгууллагатай хамтран ажилласнаар "Салхит" салхин паркын бүх талын ажил амжилттай хэрэгжээд явж байна.

-Салхин паркын энэхүү төсөл нь Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарын цаашдын хандлагыг тодорхойлно гэдэг утгаар их хүлээлт үүсгээд байгаа. Төр, засгийн зүгээс хэрхэн дэмжиж байна вэ?

-Өнөө жилийн Монголын эдийн засгийн форумаар Монгол Улсын ирээдүйн хөгжил, чиг хандлага болсон ногоон хөгжлийн талаар ярилцаж гарц хайлаа. Манай эх орон бол эрчим хүчний диваажин орон юм. Тиймээс сэргээгдэх болоод эрчим хүчний салбартаа эх орондоо төдийгүй Азийн бүсэд тэргүүлэгч болох боломж байна. Үүний тулд сэргээгдэх эрчим хүчний салбараа дэмжиж ажиллах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдсэн. Ойрын 10 жилдээ Азидаа эрчим хүчний салбараар тэргүүлэгч болох зорилгыг өмнөө тавилаа. Гэхдээ аливаа зорилгыг өмнөө тавих амархан. Хэрэгжүүлэх хэцүү. Харин анхны алхмаа хийх нь маш чухал байсан. Ямартаа ч өнөөдрийн "Салхит" салхин станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлснээр өөрийн болоод гаднын орнуудад Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах боломж байгаа юм байна гэдгийг ойлгуулсан байх. Нөгөө талаар тус бүтээн байгуулалт нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дээр тогтож байгаа гэж хэлж болно. Төрөөс хууль эрх зүй болоод зохицуулалтын тал дээр биднийг багагүй дэмжиж ажиллаж байгаа.

-Манай орны хувьд тээвэрлэлтийн асуудал ихээхэн хүндрэл дагуулдаг. Тэр дундаа салхин турбин, сэнс гэзд овор хэмжээ том бараг зөөх гэдэг томоохон бэрхшээл. Энэ асуудлыг яаж шийдэж байгаа вэ?

-Аливаа бүтээн байгуулалтын төслийг хийхийн тулд сайн төлөвлөх хэрэгтэй. Тээвэрлэлт, барилгын ажил гээд бүх зүйлийг нарийн тооцоолж, зохион байгуулалттай байх нь чухал. Монголд бизнес эрхлэхэд хамгийн түрүүнд тулгардаг эрсдэл бол яах аргагүй тээвэрлэлт, логистикийн асуудал байдаг. Үүний гол шалтгаан нь зам. Монгол Улс өнөөдрийг хүртэл замаа барьсаар л байна. Бидний хувьд 70 тонн жинтэй турбин, 40 метр урт сэнсний далбаа зэргийг тээвэрлэх нь жаахан хүндрэл дагуулж байгаа нь үнэн. Эдгээр томоохон төхөөрөмж тавдугаар сараас орж ирнэ. Бидний төлөвлөж байгаагаар авто замаар тээвэрлэлт хийх нь илүү оновчтой байх гэж үзэж байгаа.

Бид өнөөдөр мөн 28 км өндөр хүчдэлийн шугамыг өөрсдийн хөрөнгө, хүчээр барьчихаад байна. Мөн салхинаас гаргаж авсан цахилгаанаа хааш нь яаж дамжуулах, борлуулах вэ гэдэг хамгийн хүндрэлтэй асуудлаа шийдчихлээ. Үйл ажиллагаа явуулах нутаг маань уулархаг газар учраас замын асуудлаа хамгийн түрүүнд шийдсэн. Одоо цас хайлаад ирэхээр барилга, угсралтын бусад ажлаа эхэлнэ. Бэлтгэл ажлаа хангалттай базаасан. 2007 оноос хойш л бэлтгэлээ базаасаар санхүүжилтийн асуудлаа шийдээд, барилгын ажил руугаа ороход бэлэн боллоо шүү дээ.

-Үнийн хувьд хэд орчим төгрөгөөр борлуулах вэ?

http://www.mongolianeconomy.mn

-Үнийг хуулиар зохицуулсан байдаг. Салхин цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгааныг 8-9.5 центээр сүлжээнд худалдаж авна гэсэн зохицуулалт бий. Энэ нь төрөөс хөрөнгө оруулагчдыг дэмжиж буй гол хөшүүрэг юм. Европт жишээлбэл салхины эрчим хүчинд дунджаар 15 центийн тариф тогтоосон байдаг.

-Танай компани Өмнийн говьд мөн салхины эрчим хүчний томоохон төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа байх аа?

-Говийн бүс өөрөө Монгол орны хамгийн томоохон салхины нөөц бүхий газар. Мөн хүн амын суурьшил бага байгаа нь том давуу тал. Тиймээс том оврын салхин станц байгуулж, ойр хавийн уул уурхай, үйлдвэрийг эрчим хүчээр хангах боломж өндөр гэсэн үг. Манай мэргэжилтнүүд нарийн судалгаагаа хийж, ТЭЗҮ-ээ гаргахаар ажиллаж байгаа. Зөвхөн Монголд бус бүс нутагт эрчим хүчний зах зээлийг нээж, өргөн хүрээнд ажиллана.

-Япон улсад атомын цахилгаан станцын осол гарч томоохон хохирол учирсан нь дэлхий нийтэд цочроо өгсөн гэж хэлж болно. Япончууд өнөөдөр эрчим хүчний тал дээр бодлогын хувьд эргэлт гаргахаа зарлалаа. Мөн цэвэр эрчим хүчний тухайд манай орныг сонирхож буйгаа нуугаагүй. Ньюком сэргээгдэх эрчим хүчний асуудлаар япончуудтай хэрхэн хамтран ажиллах гэж байна вэ?

-2011 оны гуравдугаар сарын 11-ний Фукушимагийн осол үнэхээрийн цочроог дэлхийд өгсөн. Тиймээс цэвэр эрчим хүчийг хөгжлийнхөө гол түлхүүр болгох зорилтыг Япон улс тавилаа. Энэ нь манай орны хувьд том боломж. Япон нь олон хүн амтай, газар нутгийн хэмжээ бага учраас салхин болоод нарны станц барихад хэцүү л дээ. Тэгэхээр тус орны хамгийн ойрын цэвэр эрчим хүчний нөөц нь манай говийн бүс нутаг болж байгаа юм. Энэхүү боломжийг бид чадварлагаар ашиглах хэрэгтэй. Хоёр орны найрамдалт сайн харилцаагаа ашиглаж чадвал шинэ зах зээл бий болно гэсэн үг.

Саяхан миний бие Японы сэргээгдэх эрчим хүчний сангаас зохион байгуулсан хуралд яваад ирсэн. Япончууд ирээдүйд сэргээгдэх эрчим хүчний ямар бодлоготой байх тухайгаа ярилцсан энэ хурлаас тэд цэвэр эрчим хүчийг хөгжүүлэхэд эргэлт буцалтгүй орох том бөгөөд урт хугацааны зорилт дэвшүүлсэн. Тэд атомын станц бол байгалийн аюулт үзэгдлийн өмнө



үнэхээрийн аюултай эд юм байна гэдгийг ярьж байна. Тиймээс атомын станцаас аль болох зайлсхийж, сэргээгдэх эрчим хүчийг түлхүү хөгжүүлэх бодлого баримтлахаар болж байна. Герман Улс мөн саяхан атомын энергиэс татгалзлаа шүү дээ.

Харин бидний зүгээс нар, салхины нөөцөө ашиглан Азийн зах зээлд нийлүүлэх боломжтой гэдгээ ярьж харилцан хамтран ажиллахаар шийдсэн байгаа. Манай “Ньюком” Японы гурав дахь том компани болох Softbank корпорацитай хамтраад цэвэр эрчим хүчний чиглэлд ажиллах “Clean Energy Asia” компани байгуулсан. Тус компани нь Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг судалж, бүтээгдэхүүнийг Азийн зах зээлд нийлүүлэх боломжийг судлах зорилготой ажиллах юм.

-Сэргээгдэх эрчим хүчний салбарт боловсон хүчний асуудал хэр зэрэг хүндрэлтэй байна вэ?

-Өнөөдөр шинэ технологийг, шинэ нутаг дэвсгэрт суурьшуулах гэдэг бол чадварлаг боловсон хүчингүйгээр бүтэшгүй зүйл. Манай компанийн хувьд МУИС, ШУТИС гэвд томоохон их сургуультай хамтран ажиллаж байна. Хамтран ажиллаж байгаа гол зорилго нь сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр сураад төгсч чадвал ажлын байр бэлэн байгаа шүү гэдгийг ойлгуулах юм. Эхнээсээ сургуулиа төгссөн шинэ

http://www.mongolianeconomy.mn



Фотог Э.Зоригт

боловсон хүчин манайд ажиллаж эхлээд байгаа. Сэргээдэх эрчим хүчний нэг сайн тал нь шавхагдашгүй нөөцтэй. Тиймээс ажлын байрны шаардлага байнга гарна. Түүнчлэн уг салбараа дагаад манайд “High Tech” үйлдвэрлэл нэвтрэх боломжтой. Ер нь өндөр технологийг нэвтрүүлснээр тухайн нутагт үйлдвэр байгуулах бүрэн боломжтой болно гэсэн үг. Ингэж чадвал Монголд олон шинэ ажлын байр бий болно.

-Танай компани тавдугаар цахилгаан станцын тендерт өрсөлдөж байгаа. Энэ ажил хэр урагштай байна вэ?

-Улаанбаатар хотын дулаан, цахилгааны хангамжийн хувьд хамгийн их шаардлагатай төсөл бол тавдугаар цахилгаан станц. Өдөр бүр өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг одоогийн нөөц бололцоогоор хангах боломжгүй болоод байна. Тавдугаар цахилгаан станц нь нүүрс ашиглаж байгаа одоогийн станцуудаас 40-60 хувь илүү цэвэр технологийг ашиглах шаардлага бүхий үр ашигтай том төсөл. Олон улсын тендер зарласан байгаа. Манайх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, цахилгаан станцын хөрөнгө оруулалт, удирдлага хийдэг Европын International Power GDF Suez, Японы Sojitz болон Солонгосын Posco Energy компаниудтай хамтарч уг тендерт өрсөлдөж байгаа.

-Өнөдөр технологи буюу цэвэр технологийгнэвтрүүлэннутагшуулах бизнесийн орчин манайд хэр байна вэ?

-Бид өнөөдөр мөрөөдлөө зорилго болгоод тавьчихая. Бидний хамгийн ойрын том мөрөөдөл бол эх орондоо баян чинээлэг сайхан амьдрах шүү дээ. Харин энэ мөрөөдөл юугаар хэмжигдэх вэ гэдгийг мэдэх чухал. Энэ нь хамгийн түрүүнд өрсөлдөх чадвартай холбогдоно. Өрсөлдөх чадвартай байхын тулд өндөр технологийг оруулж ирэх хэрэгтэй. Тэрхүү технологийг монгол хүн өөрөө сайн мэддэг, эзэмших нь чухал. Тэгэхээр гаднынхнаас сайн суралцах хэрэгтэй байна. Бусдын нэгэнт бий болгочихсон тэр зүйлийг дахин бүтээх хэрэггүй. Зөвхөн өөрийн орны онцлогт тааруулж нутагшуулах нь л чухал юм. Энэ бүгдийг хийж чадвал боловсон хүчин, бизнесийн орчин зэрэг бүх зүйл аяндаа шийдэгдээд ирнэ. Ирэх 20 жилийг аваад үзэхэд томоохон бүтээн байгуулалтын ажлууд Монголд хэрэгжих төлөвлөгөөтэй байна. Харин энэ ажлыг сайн инженерүүд л хийнэ. Ирээдүйд инженер гэдэг хамгийн үнэтэй, эрэлттэй, бас өндөр шаардлага бүхий мэргэжил болно.

-Төрөөс ногоон эдийн засгийг хөгжүүлэх талаар ярьж эхлээд байна. Таны хувьд “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн. Тэр утгаараа ногоон хөгжлийн талаар товч тайлбарлахгүй юу?

-Ногоон эдийн засаг нь өрсөлдөх чадвартай байх гэсэн үг. Яагаад байн байн өрсөлдөх чадварыг яриад байна гэхээр бид дэлхий нийтийн зах зээлд гарахын тулд л юм. Өрсөлдөх чадвар явсаар эцсийн бүлэгтээ хүн дээр л ирнэ. Тэр утгаараа хүнээ хөгжүүлэх шаардлагатай. Өнөөдөр дэлхий нийт хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу буюу нүүрс хэрэглэхээс аль болох зайлсхийх талаар ярьж байна. Үүнтэй холбоотой манай улс Азийн бүсдээ цэвэр эрчим хүчний тэргүүлэгч орон болох зорилго дэвшүүлээд байгаа. Энэ бол том зорилго. Гэхдээ том зорилгод хүрэхийн тулд жижгээс эхлэх хэрэгтэй. Тухайлбал, боловсон хүчнээ бэлтгэнэ, технологио нэвтрүүлнэ, үйлдвэрлэл бий болгоно гээд л олон асуудал бий.

Мөн манай нийгэмд байгаа хамгийн том бэрхшээл бол ойлголтын зөрүү яах аргагүй мөн. Нэг хүн нэг янзаар ойлголоо гэхэд нөгөө нэг нь шал өөрөөр бодоод явж байдаг. Төр, засгийнхан нэг юм ярьдаг, бизнесийнхэн нь бас нэг өөр зүйл яриад байх жишээтэй. За тэгээд эрдэмтэн мэргэд, иргэний нийгэм гээд бүгд л нэг зүйлийг өөрөөр ярина. Энэ нь зорилгоо зөв тодорхойлсон эсэхээс шалтгаалдаг болов уу. Ойлголтын зөрүү байна гэдэг нэгдүгээрт, цаг хугацааны хувьд алдагдалтай. Цаг хугацааг алдах нь эргээд ашгаа алдаж байгаа хэрэг юм. Тиймээс зорилгоо нэг болгоод тэр зорилгодоо хүрэхийн тулд цэвэр технологийг ашиглах хэрэгтэй. Түүнчлэн бид өөрөө өөрийнхөө ажил, амьдралд эзэн болох нь чухал байна.

-“Ньюком” групп компанийн нийгмийн хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

-Нийгмийн хариуцлагыг олон талаас нь харж, олон талын үйл ажиллагаа явуулж болно. Манай компанийн хувьд жишээлбэл цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, тэр бүтээсэн баялгаа хэрэглэгч бүрт хүргэж чадах нь нэг талын нийгмийн хариуцлага. Мөн бид баялаг бүтээх явцдаа хуулиа зөрчихгүй, байгаль орчноо сүйдлэхгүй байх нь нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байгаа хэрэг юм. Хамгийн гол нь бид баялаг бүтээхдээ эрүүл, цэвэр үйл ажиллагаа явуулж, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлдэг нь л манай хамт олны нийгмийн хариуцлага гэж ойлгодог.

-“Ньюком” групп нийтдээ 2000-гаад ажилтантай. Энэ хамт олныг удирдаж яваа залуу бизнесмэнийн гол зарчим нь юу бол?

-Өөрийн гэсэн зорилготой, мөн хариуцлагатай байх. Хүн бүр өөрийн гэсэн мөрөөдөл, зорилготой түүндээ хүрэх чин эрмэлзлэлтэй байх ёстой болов уу. Би байшин барьж байлаа гэхэд өөрийн хариуцлагаа ухамсарлаж чадалгүй нэг туйпуу өрөлгүй хоосон зай үлдээвэл байшин нурна. Тиймээс миний гол зарчим бол зорилгынхоо төлөө хариуцлагатай ажиллах юм даа.

http://www.mongolianeconomy.mn

Дэлхийн залуу удирдагч

Маркетингаас хүмүүнлэг рүү

Х.Хулан

Хүний ажлын анхны гараа бүр өвөрмөц байдаг. Ялангуяа аливаа өөрчлөлтийг авчирч, оюун ухаанаа сорьсон бүхэн үр дүнтэй болдгийг Кэйт Робертсийн түүх харуулж байна.

Кэйт Робертс нь Дэлхийн залуу удирдагчаар 2007 онд Швейцарийн Давост шалгарсан билээ. Тэрбээр Олон улсын хүн амын үйлчилгээ / Population Services International/ байгууллагаас хэрэгжүүлдэг “YouthAIDS” болон “Fife & Alive” хөтөлбөрүүдийн үүсгэн байгуулагч юм.

Хатагтай Робертс нь эдгээр хөтөлбөрийн маркетинг, харилцаа холбоо хариуцсан дэд ерөнхийлөгчийн албыг хашдаг аж. “YouthAIDS” бол залуучуудын дундах ДОХ-ын тархалтыг зогсооход чиглэсэн дэлхийн хэмжээний



томоохон сургалтын хөтөлбөр аж.

“Vogue” сэтгүүлийн алдартай 100 эмэгтэйн жагсаалтад орсон Кэйт Робертс нь Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн эрүүл мэндийн зөвлөх удирдлагын гишүүн. Тэрбээр ДОХ-ын хөтөлбөрөөс гадна “Five & Alive” нэртэй дэлхийн 30-аад оронд хэрэгжүүлж байгаа хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийг мөн санаачилсан байна.

Кэйт төрсөн хот болох Англий Сауфпортын Урлаг, технологийн их сургуулийн маркетингийн ангийг төгсжээ. Тэрбээр Румын улсад ДОХ-той тэмцэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байсан. Ийнхүү өрнөсөн их ажлын дунд Кэйт амрахаар Өмнөд Африкт гурван долоо хоногоор явсан байна. Амарч байх хугацаандаа Африкийн залуус ядуурал, ДОХ өвчинд хот суурингаараа нэрвэгдсэн дүр зургийг харсан түүнд сэтгэлээр өвдөхийн зэрэгцээ нэгэн шинэ санаа төржээ. Тэр нь юу вэ гэвэл, Румынд хийж байгаа ажлынхаа стратегийг бусад оронд ч гэсэн хэрэгжүүлж болох юм байна гэж бодсон байна. Африкийн наран дор төрсөн бодол нь бодит амьдрал дээр хэрэгжиж, 2001 онд “YouthAIDS” хөтөлбөрийг санаачилжээ.

Кэйтийн маркетингийн стратеги бол соёл урлаг, спорт, хэвлэл мэдээлэл, загварын ертөнцийн алдартай хүмүүстэй хамтарсан явдал байлаа. Тухайлбал 2002 онд “Амьд үлдье” нэртэй концертыг MTV сувагтай хамтарч, 170 оронд дамжуулсан байна. Алишиа Кийс, Ашер, Пи Ди Ди гэхчлэн нэртэй дуучид оролцсон энэхүү концертоор дэлхийн залууст ДОХ-оос урьдчилан хамгаалах талаар хүргэх үгийг дамжуулсан аж.

Кэйт Робертсийг Монголд болсон Дэлхийн залуу удирдагчдын уулзалтад оролцохоор ирэх үеэр нь уулзсан билээ. Тэрбээр “ДОХ-ын эсрэг тэмцэл нэгэн үе маш хүчтэй байсан. Харин одоо хэвлэл мэдээлэл энэ тал дээр анхаарахаа больж, тэгснээр хүмүүс ДОХ-ыг байхгүй болсон мэт хандаж байна. Гэтэл энэ аюулт өвчин дэлхий даяар байсаар л байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудад” гэв. Мөн тэрбээр Монголд уул уурхайн бизнес хөгжихийн хэрээр ДОХ нүүрлэх аюултайг сануулаа.

Дашрамд дурдахад, манай Халдварт өвчин судлалын үндэсний төвд өнөөгийн байдлаар нийт 106 ДОХ-оор халдварласан хүн албан ёсоор бүртгэгджээ. Монгол шиг хүн ам цөөхөн улсад энэхүү халдвартай өвчин тархвал гамшгийн хэмжээнд хүрэх аюултайг ч Кэйт ярьж санаа зовниж буйгаа хэлсэн юм.

Тэрбээр ДОХ-ын халдвар авсан хүмүүс бусдад халдварыг тараахүй байх хамгийн найдвартай арга бол, бэлгийн харьцаанд орохгүй байх. Орсон тохиолдолд бэлгэвчийг зөв ашиглах хэрэгтэй гэсэн монголчуудын байнга сонсдог хэрнээ үл тоосон байдлаар ханддаг зөвлөгөөг чухалчилсан.

Орчин үеийн Монгол оронтой танилцсан Кэйт “Би дөрвөн жил Орост ажиллаж амьдарсан. Барууны орнуудад монголчуудыг сарлаг унаад явж байдаг мэтээр төсөөлдөг талаар хатагтай Робертс хуучилсан. Танай оронд анх ирэхэд Орос орны дүр зураг миний нүдэнд нэлээд анзаарагдсан. Харин хөдөө хээр очиход, өөр оронд байгаагаа мэдэрсэн. Монгол Улсад аялал жуулчлалаа хөгжүүлэх том боломж байна. Та бүгд баруунд улс орноо сайн сурталчлах хэрэгтэй. Танайд хөрөнгө оруулагчдыг татаж, хүн амыг эрүүл байлгах асуудал тун чухал байна. Хүн амдаа ДОХ-ын халдварын эрсдэл, урьдчилан сэргийлэх тухай сургах шаардлагатай. Эрүүл, хүчирхэг үндэстэн улс орныхоо өсөлтөд хувь нэмэр оруулна” хэмээв. ■

http://www.mongolianeconomy.mn

Сайд ярьж байна



И.Отгонжаргал

БОАЖ-ын Сайд Д.Цогтбаатар ногоон хөгжлийг Монголд хэрхэн хөгжүүлэх талаар Монголын эдийн засгийн форумын үеэр нэг бус сайн санаа, сайхан санаачилга хэлж, хүмүүсийн сонирхлыг татсан. Түүнчлэн өнгөрөгч гуравдугаар сард Дэлхийн усны өдрөөс эхлээд байгаль орчны цөөнгүй арга хэмжээ Улаанбаатар хотноо болсон билээ. Тиймээс БОАЖ-ын сайд Д.Цогтбаатарыг "Ногоон эдийн засаг" буландаа зочноор урьж, нэг сэдвээр ярилцлаа.

Улстөрчид ногооноор сэтгээд ирэхээр улс төрийн хүсэл эрмэлзлэл бий болно

-Ногоон эдийн засгийн талаар яриад байгаа хэрнээ манай эдийн засаг улам бүр хүрэн болж байна. Дэлхий нийт ногоон хөгжлийг түлхүү ярьж байхад харин манайх таг дүлий сууна. Монгол ногоон өсөлт рүү яаж орох вэ?

- Ногоон өсөлт рүү яаж орох ёстой вэ гэдэг бол чухал асуудал. Ингэж орно гэсэн нэг жор энэ ертөнц одоохондоо бодож олоогүй байна. Бүгдээрээ энэ асуудлыг ярьж байгаа. Энэ утгаараа нэг сайн тал бий. Тийшээ хэн ч очоогүй, бүгдээрээ ногоон эдийн засаг руу явах зүг чигээ тодорхойлж байгаа учраас бид оройтоогүй байна. Эдийн засгийн хөгжлөөрөө манайх нэлээд хоцорчихсон яваа ч ногоон эдийн засгийн хөгжлийн хувьд нэг их хоцролт байхгүй гэж хэлж болно. Тиймээс манайх яаралтай ногоон эдийн засгийн бодлогуудаа гаргах ёстой.

Хамгийн эхний ээлжинд бидний сэтгэлгээ өөрчлөгдөх ёстой. Сэтгэлгээгээ хоёр түвшинд өөрчлөх ёстой. Үйлдвэрлэлийн түвшинд, мөн хэрэглээний түвшинд гэж. Үйлдвэрлэлийн сэтгэлгээ өөрчлөгдчихөөд, бид нарын хэрэглээ бохир, хайнга хэвээрээ байгаад байх

http://www.mongolianeconomy.mn

тохиолдолд ногоон эдийн засаг руу бүрэн шилжиж чадахгүй. Юун түрүүнд бүгдээрээ нэгэн зүйлийг ойлгох ёстой. Энэ ертөнцөд ерөөсөө дуусашгүй нөөц гэж байхгүй юм байна. Харамгүй, хариуцлагагүй хэрэглэх юм бол бүх юм дуусна. Бид өнгөрсөн сарын 22-нд Дэлхийн усны өдрийг тэмдэглэж бүтэн долоо хоногийн турш усны асуудлаар амьсгаллаа. Усыг аваад үзэхэд, дэлхийн байгалийн баялгаас хамгийн арвин нөөцтэй нь. Гэтэл бидний хамгийн их гэж бодож байгаа энэ нөөц харамгүй хэрэглэвэл дуусаж болзошгүй. Хайр гамгүй хэрэглэх юм бол бохирдоод багасах эрсдэл байна. Эрсдэл байна гэдэг чинь дуусаж дундрахын дохио юм.

-Таны ногоон эдийн засгийг хөгжүүлэх санаачилгуудын дотор банк санхүүгийн салбарт ногоон хариуцлага нэвтрүүлэх тухай байсан. Яагаад ингэж бодох болсон бэ?

-Ногоон эдийн засгийг хөгжүүлэхийн тулд Сайд болсноосоо хойш гурван тодорхой асуудлыг санал болгоод байгаа. **Нэгдүгээрт,** банк санхүүгийн байгууллагуудыг ногоон хариуцлагад хамруулъя. Энэ нь бохирдуулагч нь төлдөг тогтолцоо руу оръё гэсэн үг. Үүнийг орчин цагийн тогтолцоо руу шилжих ч гэж ярьдаг. УИХ-д өргөн бариад буй байгаль орчны багц хуулиуд бохирдуулагчтай хариуцлага тооцдог болж байгаагаараа том ахиц гаргахаар байгаа. Тэгэхдээ зөвхөн бохирдуулагчтай ажиллахаар өрөөсгөл. Түүний ард бохирдуулагчид зээл өгөөд, бохирдуулснаас нь ашиг олоод байгаа банк санхүүгийн байгууллагууд бохирдуулагчдын тоонд ордоггүй сайхан амирлангуй хүмүүс ард нь үлддэг. Тэгвэл би банк санхүү, хөрөнгийн биржийг энэ хариуцлагад хамруулдаг болъё гэсэн санаачилга гаргаж байгаа. Тэд бохирдуулагчид бохирдуулах эрсдэл байгаа гэдгийг нь мэдсээр байж зээл өгч, бохирдуулах боломжийг нь олгоод байгаа, эсвэл хөрөнгийн бирж мөнгө босгох боломжийг нь олгоод байгаа бол тухайн хөрөнгийн бирж болон банктай давхар хариуцлага тооцдог байя. Энэ бол банк санхүүгийн байгууллагуудыг хорлох гээд байгаа юм уу, үйл ажиллагааг нь хаах гээд байгаа зүйл бол биш. Бохирдуулагчдыг бүү дэмжээч ээ, цэвэр байгууллагуудтайгаа ажиллаач ээ гэдгийг л хэлж байгаа юм. Үүний хажуугаар бохирдуулагчийг энэ гээд хэн найдвартай хэлэх юм бэ гэдэг асуудал гарч ирнэ. Түүнийг байгаль орчны байгууллагууд хийх ёстой. Бохирдуулагчдын хар жагсаалт гаргана. Тэгээд энд банк санхүүгийн байгууллагыг татан оролцуулснаар өнөөдрийн энэ хариуцлагагүй тогтолцоонд том өөрчлөлт гарна.

Хоёр дахь миний гаргаж буй санаачилга бол манайд Цэвэр агаар сан, Байгаль хамгаалах сан гэх мэт тус тусдаа ногоон чиглэлийн сангууд байдаг. Эдгээрийг нэгтгэж Байгаль орчны сангуудын ногоон консерциум бий болгох хэрэгтэй. Өөр өөрсдийн эх үүсвэрээсээ санхүүжилтээ авч, татвараа бүрдүүлдгээрээ бүрдүүлнэ. Гэхдээ нэгдсэн ногоон санхүүжилтийн зохицуулах удирдлагатай байна гэсэн үг. Энэ консерциум ямар байх вэ гэхээр, хөл дээрээ босч үйл ажиллагаа нь жигдэртэл менежментийг нь гаднын туршлагатай байгууллагад өгөх юм.

-Яагаад?

-Өнөөдөр ногоон технологи, ногоон эдийн засгийг биднээс арай түлхүү мэдэж байгаа нь гаднынхан. Аль нь худлаа ногоон технологи, аль нь үрэлгэн, аль нь үр ашигтай ногоон технологи вэ гэдгийг тэд сайн мэднэ.

Бас нэг давуу тал нь өнөөгийн манай байж байгаа амьдралын нүүр царай л тэр юм даа. Танил тал, гар цайлгах гээд олон зүй бус зүйл байна. Ногоон сан гээд байгуулагдахаар хүмүүс ногоон гэдэг гоё нэртэй үрэлгэн, эргээд хэзээ ч мөнгөө төлөхгүй төслүүдтэй давхиж ирээд мөнгө авах гэж оролддог. Гэтэл гаднын байгууллагад өгчих юм бол гар цайлгах асуудал гацна. Танил талаараа төсөл авдаг боломж нь хязгаарлагдана. Тэгснээрээ харьцангуй цэвэр үйл ажиллагаатай, найдвартай сангууд бий болж эхэлнэ. Одоо хүмүүсийн яриаг сонсож байхад гадуур ногоон эдийн засгийн төслийг сан 100 хувь даадаг гэсэн утгатай зүйл ярьж явна. Хэрвээ тэгсэн тохолдолд сан тухайн төслийн эрсдэлийг 100 хувийн өөртөө авах болно шүү дээ.

Уг нь бол минийхээр тус сан нь ногоон төсөлд санхүүгийн зөвлөгөө өгөөд, хөрөнгийн бирж дээр гарахад нь тусалдаг, өөрсдөө андрейтор болж тодорхой хэмжээнийх нь хувьцааг аваад, хувьцаа гарах сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний бэлтгэлийг хангаж өгнө. Ингэснээр тухайн сан бидний хөгжүүлэх гээд зориод буй Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэмжиж байгаа юм. Нөгөө талаас ногоон чиглэлийн компани сангийн дэмжлэгтэйгээр хөрөнгийн биржид хувьцаагаа гаргаад эхлэхээр Монголын ард түмэн дэвшилт технологийг хөгжүүлэхэд оролцож эхэлж буй хэрэг. Эдийн засгаа ногоон болгоход эргэн хүн оролцоод эхэлж байна гэж үзэж болно. Ингэснээрээ ногоон эдийн засаг бүх нийтийн оролцоотой, эдийн засгийн зөв хөшүүрэгтэй хөгжих боломж бий болж байгаа юм.

-Таны гурав дахь санаачилга юу вэ?

-"Ногоон зээл". Ногоон технологи гэдэг өнөөдрийн байгаа технологиос арай үнэтэй. Тэгэхээр үйлдвэрлэгч дээр очоод өнөөдрийн технологиороо хийж болоод байгаа юмыг нь "Наадах чинь болохгүй байна. Ногоон технологи руу шилжүүл" гээд шахах юм бол нэмэлт зардлыг тэр хүмүүс хаанаасаа гаргаж ирэх вэ. Зарим нь хүсэхгүй болоод шаардлагатай зардлыг гаргахгүй байж болно. Тэгвэл зарим нь дийлэхгүй байж магадгүй шүү дээ. Өнөөдөр бидэнд хөгжлийг бий болгох, ажлын байр бий болгох, ядууралтай тэмцэх давхар давхар хэрэгцээ байгаа. Тийм учраас эдийн засгийг зогсоох маягаар ногоон эдийн засгийг нэвтрүүлж болохгүй. Ногоон хөгжил өөрөө хөдөлгүүр байх ёстой. Тэр утгаараа Ногоон зээлийг бий болгох юм. Ингэснээрээ яах вэ гэхээр, үйлдвэр аж ахуйн газруудад очоод "За технологио шинэчлэхэд хэр хэмжээний зардал хэрэгтэй байгаа вэ. Энэ зардлын чинь 30 хувийг бид хөнгөлөлттэй зээлээр олгоё. 70 хувиа харин та нар өөрсдөө гаргаарай. Хэрэгжүүлэх хугацаа өгье. Хэлсэн хугацаандаа ногоон технологи руу шилжихгүй бол харин хаана шүү" гэдэг ч юм уу. Ингэх юм бол шударга хандлага бий болно. Түүнээс төр өдий болтол энэ эдийн засгийг нүдээ аниж байгаад ийм болгочихоод гэнэт сэрсэн юм шиг та нар буруу явсан гэж болохгүй. Өөрөө тэр бурууд нь оролцоотой байж гэнэт өөрчилнө гэдэг шударга биш. Ногоон зээл гэдэг нь эдийн засгийг ногоон болгох санхүүгийн нэг хөшүүрэг болно. Би нэг зүйлийг хэлье. Ногоон эдийн засагт шилжинэ гэдэг захирамж гаргаад хийдэг ажил биш. Би бол төр эдийн засгийг ногоон болгоход оролцоод, дэмждэг юман дээрээ дэмжээд явах ёстой гэж боддог. Түүнээс биш, төрийг эдийн засгийн бүх үйл ажиллагаанд хавтгай оролцохын эсрэг байдаг.

-Өнөөдөр ногоон хөгжил бодлогын бичиг баримтуудад тэр бүр тусгагдаагүй гэж хэлж болно. Тэгэхээр Та хэлж ярьж байгаагаа яаж төрийн бодлогод тусгуулах вэ. Нэг талаас төр барьж буй хүмүүс ногоон сэтгэхүйтэй болж, ногоон хөгжлөөр явахыг хүсэхгүй байх шиг. Энэ тал дээр юу гэж бодож байна вэ?

-Ногоон бодлого, ногоон

http://www.mongolianeconomy.mn



хөдөлгөөний нэг сайхан тал нь үүний эсрэг хүн байдаггүй. Манай монголчуудын дунд ч яаж ногоон болгохоо мэдэхгүй, зүгээр л гоё болохоор нь яриад буй дутагдал байгаа. Ер нь XXI зуунд сонголтгүй болчихсон учраас бид ногоон хөгжил, ногоон эдийн засаг руу шилжих шаардлагатай болчихоод байна.

-Төрийн хүмүүс таны хэлж байгаа шиг одоо л ногооныг ярьж, яаравчилбал хөгжлийн галт тэргэнд сууж амжина гэдгийг тэр бүр сайн ойлгохгүй байна. Үүнд ямар өөрчлөлт гаргаж болох вэ?

-Ерөнхий суурь сэтгэлгээ нь ногооныг дэмжих хүсэлтэй байгаа мөртлөө яг яаж дэмжихээ мэдэхгүй бүдэг бүрэг байдалтай байгаад байна л даа. Яг үнэн, өөрийн чинь хэлж байгаагаар бүгдийг ойлгуулах хэрэгтэй байгаа. Ногоон эдийн засаг нь мөрөөдлийн бөгөөд айхтар үнэтэй зүйл биш. Боломжтой зүйл гэдгийг бас итгүүлэх хэрэгтэй. Улс төрийн хүсэл эрмэлзлэл бий болж байж энэ явна. Сэтгэлгээ өөрчлөх гээд байгаа чинь л энэ шүү дээ. Олон хүний сэтгэлгээ өөрчлөгдөөд олонх нь ногоон эдийн засгийн төлөө сэтгэдэг болох ёстой. Тэр дотор улстөрчид орно. Тэд нар ногооноор сэтгээд ирэхээр улс төрийн хүсэл эрмэлзлэл бий болж эхэлнэ. Энэ бол эхлэл. Үүний араас бичиг баримтууд боловсруулагдаад, бодлогуудаа оруулж ирнэ дээ. Манайхан өнөөдөр гоё гэж ярьчихаад, өөрсдөө түүндээ итгэхгүй байгаа болохоор ногооруулах үйл ажиллагаа бодит амьдрал дээр явагдахгүй байна. Үүнийг л өөрчлөх нь та бид бүгдийн, иргэний нийгэм, төрд ногооноор сэтгэж байгаа хүмүүсийн хамтын зорилго байх юм.

-Та жишээ нь яриад буй ногоон бодлогоо хэрэгжүүлэхээр яг одоо юу хийж байгаа вэ?

-Дээр хэлсэн гурван санаачилга дээрээ бичиг баримт боловсруулж байна. Гаднынхны тусламжийг авчна гэж бодож байгаа. Яагаад гаднынхны тусламжийг авах гээд байна вэ гэхээр, хамгийн эхний саналыг олон улсад хүлээн зөвшөөрсөн Монгол Улсын ногоон санаачилга болгоно. Манайд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ногоон санаачилга өнөөдрийг хүртэл гаргаагүй. Энэ ертөнцөд оршиж байгаа орны хувьд Монгол олон улсад ногоон санаачилга гаргаад санал оруулах ёстой.

-Хар жагсаалтын талаар Байгаль орчны 10 багц хуульд туссан байгаа юу?

-Тэнд хараахан тусаагүй байгаа. Яг одоо боловсруулж байна. Аль болох богино хугацаанд хийхийг зорино. Бодлого болж гарна.

-Ногоон эдийн засаг нь нийтийн тээврээр зорчих, ус, цахилгаанаа ахуйн нөхцөлд хэмнэх гэх мэт энгийн зүйлээс эхэлнэ гэж ярьдаг. Та хувь хүнийхээ хувьд ногоон сэтгэхүйг хэдийнээс бий болгосон бэ. БОАЖ-ын сайдын албыг аваад түлхүү сонирхдог болов уу. Эсвэл өмнө нь үүнийг хэрэгжүүлдэг байсан уу?

-Маш сонирхолтой асуулт байна. Тэгэхээр би хэзээ ч ан хийж байгаагүй. Амьтны зураг авах, эсвэл хөдөө хээр явж байгаад чоно харсан бол илүү хиймортой байна гэж боддог. Энэ бол байгалийг, ан амьтныг хайрлаж явдаг нь миний бодит амьдралын үйлдэл дээр харагдаж байгаа зүйл. Бага байхдаа биологийн хичээлд маш дуртай байсан. Амьтны ертөнц, эко системийг хувь хүний хувьд шинжлэх ухаан талаас нь ихээхэн сонирхож судалдаг байсан. Түүнээс биш, ногоон эдийн засаг болоод бусад зүйл дээр Сайд болоод нэлээд сайн танилцаж байна.

Би Австралид оюутан байхдаа Австрали, Шинэ Зеландын оюутнуудын дунд зарласан бизнесийн эрх зүйн асуудлаарх судалгааны ажлын уралдаанд оролцоод, түрүүлж байсан. Тэрхүү судалгааны ажлаа “Олон улсын худалдаа ба олон улсын байгаль орчны эрх зүйн зөрчил түүнийг эрх зүйн хүрээнд шийдэх нь” гэсэн асуудлаар бичсэн. Тэр бүтээл маань Лондонд олон улсын хуулийн чиглэлийн мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэж байлаа.

-Таны ярьсан гурван гол бодлого банк санхүү, бизнес талд түлхүү

http://www.mongolianeconomy.mn

чиглэжээ. Танд Улаанбаатар хотын хогны менежментийг сайжруулахтай холбоотойгоор домог болтол яригдсан хог боловсруулах үйлдвэрийн тухай биш, энгийн жижиг зүйлээс эхэлж юу хийж болохоор санагддаг вэ?

-Маш зөв асуулт байна. Би дээр хэлсэн бид хэрэглээгээ өөрчлөх хэрэгтэй гэж. Шуналаа дарж амьдрах хэрэгтэй. Жишээ нь “Манай хөрш том машин аваад уначихаж, би үүнээс томыг авч унана” гэж бодож байгаа бол тэр чинь илүү бензин хэрэглэнэ, илүү агаар бохирдуулна. Тэгэхээр энэ мэт шаардлагаас давсан хэрэгцээнээс аль болох зайлсхийж амьдрах хэрэгтэй байна. Энэ нь ядуу тарчиг амьдар гэж байгаа юм биш. Хангалуун, гэхдээ түүнийгээ хэтрүүлж амьдармааргүй байна.

Миний бие Сайдын албанд оччихоод хогийн цэгүүдээр явж танилцсан. Тэгэхэд хог зөөдөг машины жолооч нар ажлын найман цагаар ажилладаг байсан. Замын түгжрэлд өдрийн талыг авчихна ямар ажлын бүтээмж байх юм бэ. Тэгээд хотын удирдлагуудад хог зөөдөг жолооч нарын ажлын цагийг нь уртасгаж 24 цаг бологоод, гурван ээлжээр ажиллуулбал ямар вэ гэдэг санал тавьж шийдүүлсэн. Шөнө замын түгжрэл бараг байхгүй учраас ажлын бүтээмж нь хэд дахин нэмэгдэнэ. Мөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас тэднийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд шилжүүлэхээр болсон. Зундаа дугуй унадаг болцгооё л доо. Таны хэлдгээр нийтийн тээврийн хэрэгслээр зорчъё. Аль болох явган явж байя. Энэ бүхэн эрүүл хэрэглээ юм. Гэтэл бид таван хүн сууж болох том машинд ганцаархнаа суугаад замын түгжрэлд нэг цаг зогсох жишээтэй л байна шүү дээ. Дэлхийн олон оронд хотын төв рүү орох бол машинд нэг хүн явж болохгүй, 2-3 хүн заавал авч явахыг шаарддаг. Нэг машинд таван хүн суулгачихад хотын замын хөдөлгөөнд оролцож байгаа машины тоо таван машинаар цөөрнө. Ийм мэтийн зохицуулалт хийж чадах юм бол энд маш олон шийдэл байдаг.

-Замын хөдөлгөөнийг багасгах ёстой гоё санаа байна. Та Байгаль орчны сайдын хувьд яагаад тийм шийдвэр гаргаж болохгүй гэж.

-Гэхдээ монголчууд бид угаасаа хээр талыг дангаараа эзэмшиж сурсан хүмүүс болохоор таван хүнийг нэг машинд суу гэвэл энэ Байгаль орчны сайд эрх мэдлээ хэтрүүлж дэмий юм ярьж байна гэх байх л даа. Гэхдээ ийм гарц цөөнгүй бий.

- Урин дулааны улирал айлчлаад утаа бараг арилж байна. Манайхан дахиад өвөл болохгүй юм шиг утааны асуудлыг зун ор тас мартдаг л даа. Тэгвэл Та энэ зун утааны асуудлыг мартахгүй байх чиглэлээр ямар дорвитой ажил хийх вэ?

-Утааг багасгах чиглэлээр багагүй ажил хийж байна. Тэр дотор түлшний үйлдвэрийн асуудал орно. Энэ нь хамгийн сайн шийдэл биш ээ. Гэхдээ өнөөдрийн байгаа мөнгөнийхөө боломжиндоо шийдэх гээд оролдож байгаа оролдлого. Шууд зуун хувь арилгана гэхгүй, шат шатаар 15, 20 хувиар ч гэсэн бууруулж л байх ёстой. Тэр үр дүнг өгч байгаа технологиуд байвал түүнийг нь бас нэвтрүүлж л байх хэрэгтэй. Тэр утгаараа түлшний үйлдвэрүүдийг аль болох богино

Манай хөрш том машин аваад уначихаж, би үүнээс томыг авч унана” гэж бодож байгаа бол тэр чинь илүү бензин хэрэглэнэ, илүү агаар бохирдуулна. Тэгэхээр энэ мэт шаардлагаас давсан хэрэгцээнээс аль болох зайлсхийж амьдрах хэрэгтэй байна.

хугацаанд ашиглалтад оруулах шаардлагатай байна.

Би сая нэг түлшний үйлдвэртэй очиж танилцсан, тавдугаар сард эхний бүтээгдэхүүнээ гаргана гэж байсан. “Хугацаагаа хойшлуулалгүй хэлсэн хугацаандаа түлшээ гаргана шүү” гэсэн шаардлагыг тавьчихсан байгаа. Мэдээжийн хэрэг гэрийн дулаалга, зуухны асуудал байгаа. Олон зүйлээр шийдэхгүй бол болохгүй. Зууханд бас зарим хүн үл итгэх байдалтай л явж байгаа, аргагүй. Гэхдээ энэ чинь бага багаар шийдэх шийдлүүдийн нэг нь. Нэг далайлтаар бид хийх боломжгүй, тийм мөнгө ч байхгүй.

-Зуух гэснээс нийслэлчүүдийн нэг хэсэг нь утаа бага гаргадаг олон улсын стандартын зууханд дасах гэж хэрэндээ л хичээж байгаа сурагтай. Халуунаа удаан барьдаг, нүүрс харьцангуй бага зарцуулдаг гээд ам сайтай байгаа. Гэхдээ нүүрсээ бүрэн шатаж дууссаны дараа галладаг учраас дараагийн нүүрс нь астлаа 2-3 цаг хөлдөөхтэй дөхдөг сул талтай гэж ярих юм билээ.

-Тиймэрхүү яриа байгаа, би сонссон. Энэ талаар би холбогдох хүмүүстэй уулзсан. “Хэрвээ ийм байвал энэ цаашаа түгэхгүй ээ. Тэгэхээр үүнтэй холбоотой тайлбаруудаа нададавчраад өг” гэсэн. Надад өгсөн тайлбараар технолгийнх нь дагуу ашиглах юм бол тэгж их даарч суухгүй байх боломж байгаа юм билээ. Би айлуудаар явж үзсэн. Магадгүй, намайг технологийнх нь дагуу галлаж сурсан айлуудаар авч явсан байхыг ч үгүйсгэхгүй. Нялх хүүхдүүдтэй айлуудаар ч орсон. Тэр үеэр завсар нь зай гарч даардаг гэсэн гомдол санал яриагүй.

-Усны үнийг зохицуулах гэдэг нэг чухал асуудал гэж Та ярьж байсан. Манайд усны тэгш бус хуваарилалтыг халах, нөөцөө зөв хуваарилах зохиуцуулалтын орчин бүрдсэн гэж бодож байна уу?

-Бүрдээгүй. Гэхдээ бүрдээгүй гээд сууж байж таарахгүй. Энэ тал дээр бодлогын нэлээд том алхмуудыг хийх шаардлагатай. Ард иргэдийн хэрэглээний усны үнийг нэмэх тухай ойлголт байж болохгүй. Үнийн бодлогыг эргэж харж ярих ёстой гэж миний үзээд байгаа бол аж үйлдвэрүүд дээр ус гэдэг бүтээгдэхүүний үнийн бодлогыг ярих хэрэгтэй байгаа юм.

-Уул уурхайн усан хангамжийн асуудал хурцаар тавигдаж байгаа. Та болохоор Эдийн засгийн форумын үеэр уул уурхайн компаниудад одоо хэрэглэж байгаа усны зөвшөөрлийнх нь хугацааньдуусахаарзөвшөөрлийг нь сунгахгүй гэдэг дээр бат зогсох хэрэгтэй гэж ярьж байсан. Тэгэхээр яг тэгж баттай зогсож чадах уу?

-Уул уурхайн усан хангамжийн хэрэглээн дээр чадах болов уу, чадахгүй болов уу гэсэн асуудал байж таарахгүй. Чадах ёстой. Тэр үед миний бие Сайд биш байсан ч гэсэн иргэний хувьд Ногоон чиглэлийн хөдөлгөөнүүдтэй нийлээд чадахгүй бол чадуулахын төлөө ажиллах болно. Уул уурхайн компаниуд зөвшөөрөлтэй ус ашиглаж байх хугацаандаа тодорхой мөнгийг цаашаа хөрөнгө оруулалтын бодлогодоо өнөөдрөөс суулгаж өгөөд, гадаргын усыг говь руу татах төслийг л хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй юм бол хаагдана л биз. Байгаль орчны багц хуулийг энэ Парламентыг үнэхээр баталж өгөөсэй гэж хүсэж, найдаж байна. Яагаад гэвэл энд маш олон том бодлогын өөрчлөлтүүд гарах учиртай. ■

http://www.mongolianeconomy.mn



Байгаль орчин

Оюутолгой усны асуудлаа яаж шийдсэн бэ?

Говь нутгаар хэрэн бидэрч, аялаж явахад тэнгис далай л нүдэнд цэлийн харагддаг. Ойртон очих тусам алсарч, алга болох нь зэрэглээний нууц юм. Зэрэглээг зэрвэс харвал их ус. Мэддэггүй хүн анх удаа харвал уулга алдмаар цэлийсэн ус шиг л үзэгддэг. Говь нутагт ус ийм л үнэ цэнэтэй аж. Өнөөдөр усгүйгээр уул уурхайн үйлдвэрлэл хөгжихгүй, уул уурхайгүйгээр улс орны эдийн засаг урагшаа явахгүй болжээ. Тиймээс усны асуудал уул уурхайн салбарт, тодруулбал, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн чухал ордтой холбогдсон нийгмийн хэлэлцүүллэг өрнөх боллоо. Өмнөд говийн дэд бүтэц, уул уурхайн үйлдвэрлэл, Монгол Улсын эдийн засгийн хэтийн хөгжил уснаас шуудхан хамааралтайг ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц, ус ашиглалтын салбарын эрхлэгч Л.Жанчивдорж хэлсэн юм. Тэгвэл усны асуудлаа уул уурхайн салбарынхан хэрхэн шийдэх боломжтой вэ. “Гадаадын орнууд олон зуун мянган усан сан байгуулж усан цогцолбор байгуулан цахилгаан гаргаж, усан хангамжаа шийдвэрлэсэн байдаг. Говь нутагт уул уурхайн үйлдвэрлэл явуулна, аж үйлдвэрийн цогцолбор байгуулна гэж үзэж байгаа бол усны нөөцийн боломж, бүтцийг урьдчилсан боловсруулсан төсөл хэрэгжүүлэх шаардлагатай болохыг Л.Жанчивдорж онцлон ярилаа. Тэрбээр манай говьд эдийн засгийн ач холбогдлоороо Оюутолгой шиг хэд хэдэн орд газрууд илэрч магадгүй гэв.

УИХ-ын Сонгууль ойртох тусам уул уурхайг тойрсон, улс орны эдийн засгийн хөгжлийг чөдөрлөсөн болхи хийрхэл, богино зайны улс төржилт савнаасаа хальж байгаад хөрөнгө оруулагчид тун сэтгэл дундуур байгаа аж. Үүнийг хөгжилд яарсан, хөгжих гэж тэмүүлсэн монголчууд ч лавтай хүсэхгүй. Тиймээс л говь нутгийн цангамал хэвлийд буй үүцийг уудалж авахаас өмнө усны асуудлыг цогцоор шийдэж, шинэ техник технологийг нэвтрүүлэх, аль болох л байгаль орчинд ээлтэй шинэ ололтыг нэвтрүүлэхийг эрдэмтэн, судлаачид санал болгож байна. Тэгвэл Оюутолгой төсөл усныасуудлаа яаж шийдсэн юм бэ.Тавантолгой ч ялгаагүй усны асуудалтай өдгөө нүүр тулж байна.

Усны төвийн захирал, доктор Ж.Далай “Тавантолгойн ордын хувьд Наймантын хөндий, Балгасын улаан

http://www.mongolianeconomy.mn

нуур, Зайрмагтай, Гурамсангийн хоолой, Борзонгийн хоолой, Таван алдын говь, Мандал-Овоо, Мандах бумбат, Оорцог хадан ус зэрэг газраас ус авна гэж тоймлож байгаа. Харин Оюутолгойн нийт ус хэрэглээний 84 хувийг эргүүлж дахин ашиглах бөгөөд зөвхөн 16 хувийг Гүний хоолойн газрын доорхи уснаас авч ашиглахаар төлөвлөсөн байгаа" хэмээн "Ус ба говь" номондоо тэмдэглэсэн байна.

Гүний хоолойн газрын доорхи усны ашиглалтын нөөцийг хоногт 75168 м куб буюу 870 л/сек гэж үнэлж, БОАЖ-ын сайдын тушаалаар баталжээ. Одоогийн байдлаар Оюу Толгой хоногт 696 л/сек буюу хоногт 60.000 гаруй куб метр ус ашиглах юм байна. Мөн өмнөд бүс нутгийн усны асуудлыг "Орхон-Говь" төслийг хэрэгжүүлснээр шийдэх боломжтойг Ж.Далай хэллээ. Хэрлэн голын усны нөөцийг хуримтлуулснаар олон асуудлыг шийднэ хэмээн "Хэрлэн-Говь" төсөлд тайлбарлажээ.

Хөгжлийг хөшүүрэгдэж, эдийн засгийг эргэлтэд оруулах уул уурхайд ус чухал. Монгол Улс өнө мөнх оршиход ус бүр ч чухал. Чухал учраас л чухлын тухай эрүүл хэлэлцүүлэг, илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, баримттай, амьдралд ойрхон амин усны талаар ярих нь зөв гэдэгтээ уул уурхайн салбарынхан дуу нэгтэй хүлээн зөвшөөрч байгаа юм. Түүнээс уул уурхайн салбарт ашиглагдах усаар дан ганц улс төрийн тоглолт хийж болохгүй гэдгийг өнөөдөр хөрөнгө оруулагчид болоод тус салбарт ажиллах хүмүүс хэлж байв. Техник эдийн засгийн үнэлгээгээр Оюутолгой баяжуулах үйлдвэрийн хүчин чадал хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулах ба бүрэн хүчин чадлаараа ажиллах үеийн усны хэрэгцээ 696 литр секунд байх аж. Оюутолгой үйлдвэрлэлийн ашигласан усныхаа 80-90 хувийг дахин ашиглах бөгөөд дэлхий дээрх хамгийн бага усны ашиглалт бүхий хэмнэлттэй уул уурхайг хөгжүүлэх зорилтыг тавьсан байна.

Гүний Хоолой хэмээн нэрлэгдэх газрын доорх усны нөөц талбайн гидрогеологийн нарийвчилсан судал-гааны үр дүнд 6.800.000.000м куб усны нөөцтэй хэмээн тогтоогджээ. Олон сая жилийн туршид хуримтлагдсан давстай ус учир ахуйн хэрэглээнд ашиглах боломжгүй уг усны нөөцийн 20-иос бага хувь нь уурхайн үйл ажиллагааг 40 жилийн турш дэмжих бөгөөд, үлдсэн дийлэнх ус ирээдүй хойч үед үлдэнэ хэмээн "Оюу Толгой" компанийнхан ам бардам хэлж байна.

Оюутолгой Гүний хоолойн усыг зөвхөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана

З.Батбаяр /Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын орлогч дарга/

-Монгол Улсын ирээдүйн хөгжил уул уурхайгаас, уул уурхайн хөгжил өмнөд говиос хамааралтай байх тухай өнөөдөр ярьж байна. Уул уурхай дангаараа хөгжихгүй, харин усан дээр тулгуурлаж, ус байгаа газар л уул уурхай хөгжинө. Тиймээс уурхай болгоныхоо усан хангамжийн асуудлыг дан дангаар нь авч үзэх хэрэгтэй. Оюутолгой төслийн усан хангамжийн асуудлыг одоо байгаа тоо баримтаас нь авч үзэхэд хангалттай байгаа юм. Оюутолгойн усны асуудлын хувьд Гүний хоолой гэдэг газраас гүний усны нөөц илэрсэн. Энэ нь Оюутолгойн үйлдвэрлэлийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой юм билээ. Оюутолгой Гүний хоолойн усыг зөвхөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана. Хэдий ийм боловч аль болох хэмнэлттэй хэрэглэх, дахин ашиглах арга замуудыг нэвтрүүлэх шаардлагыг манай газраас тавьж байна. ■

Төлбөртэй нийтлэв.



http://www.mongolianeconomy.mn

Хуульч

Хуулийн зөвлөх үйлчлүүлэгчдийнхээ бизнесийг сайн олгох нь чухал



Лондон хотод төвтэй олон улсын "Clyde & Co" хуулийн компани нь Монголын "Хаан Лекс Адвокатс" хуулийн компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. Тус "Clyde & Co" компанийн ахлах хуульч, ноён Стивен Трикстэй Улаанбаатарт ажлын шугамаар ирээд байх үед нь манай сурвалжлагч уулзаж ярилцлаа. Ноён Трикс нь Оксфордын их сургуулийн төгсөгч бөгөөд 1986 оноос "Clyde & Co" хуулийн компанид ажиллаж байгаа юм. Тэрбээр олон улсын худалдаа, тээвэр, даатгал зэрэг салбарт эрх зүйн зөвлөгөө өгч ажилладаг, мөн олон улсын худалдаа болоод аж ахуйн нэгжүүдийн хамтарсан төслүүдтэй холбоотой томоохон маргаан дээр өмгөөлөгчөөр ажилладаг туршлагатай хуульч юм.

-Та компанийнхаа болон өөрийн ажлын талаар товч танилцуулна уу?

-"Clyde & Co" хуулийн фирм нь анх 1933 онд Лондон хотод байгуулагдсан түүхтэй. Харин гадаад дахь анхны салбараа Хонконгд 1981 онд байгуулж байсан. Хоёрхон хуульчтай байгуулагдаж байсан "Clyde & Co" нь эдүгээ 1300 гаруй хуульчтай олон улсын хуулийн компани болон өргөжжээ.

Би Монголд сүүлийн нэг жилийн дотор гурав дахь удаагаа ирээд байна. Ирэх бүртээ Монгол Улсын хөгжил дэвшлийн хурд, бүтээн байгуулалтын цар хүрээг өөрийн нүдээр харж, тус улсын ирээдүйг бүтээлцэж байгаа Монголын ажил хэрэгч хүмүүстэй уулзан ярилцаж, хамтран ажилладаг. Нөгөө талаас, Монголын ард түмэн нь өнгөрсөн үеийн аугаа их түүх, соёлтой гэдгийг бас мартаж болохгүй.

Миний бие олон улсын бизнес худалдаа, тээвэр, даатгалын чиглэлээр дагнан ажилладаг. Үүнд, тухайлбал, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, бүтээгдэхүүн үйлчилгээний арилжаа, тээвэр, даатгалын олон талт асуудлаар зөвлөгөө өгдөг. Олон улсын фирм "Clyde & Co" нь өөрсдийн үйлчүүлэгчдийг зөвхөн Их Британид бус, дэлхийн аль ч оронд бизнесээ эрхлэхэд нь хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд анхаардаг. Бид өнөөдөр Монголын дахь байгууллага, компаниудтай хамтран ажиллах болсондоо баяртай байна.

Бид өөрийн ажил үйлчилгээгээ хөгжүүлэхдээ үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээ, бизнесийн арга ажиллагааг зөв ойлгоход онцгой анхаардаг. Хуулийн зөвлөхийн хувьд хуулиа мэдээд зогсохгүй үйлчлүүлэгчийнхээ бизнесийг сайтар ойлгох нь чухал гэж үздэг. Иймд үйлчлүүлэгчтэйгээ ойр дотно байх, тэдний бизнесийг ойлгох, тэдэнд зүгээр нэг хууль зүйн зөвлөгөө бус, харин тэдний бизнест нь хамгийн оновчтой шийдэл бүхий зөвлөгөө өгөхөд түлхүү ажиллаж байна.

-Та Монгол оронд өрнөж буй өөрчлөлтийг юу гэж дүгнэж байна вэ?

-Сул тал гэвэл Улаанбаатар хотод ирэх бүрт замын түгжрэл улам ихэссээр л байна. Тиймээс машинаар бус, явган явбал ажлаа илүү богино хугацаанд амжуулах юм байна гэж би ойлгосон. Гэхдээ Монголд сааранс сайн нь илүү их байна. Хувийн хэвшлийнхэн, төр, засаг аль аль нь бизнесийн салбарыг бэхжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, улмаар эрдэс баялгийн орлогыг аль болох олон хүнд хүргэж хуваарилах, улс нийгэмд үр өгөөжтэй зүйлд захиран зарцуулахад анхаарч ажиллаж байна. Анх 2011 оны тавдугаар сард анх Монгол орны үзэсгэлэнт сайхан хөдөө нутгийг үзэх боломж олдсонд баярлаж

http://www.mongolianeconomy.mn

явдаг. Уудам тал, бэлчиж буй мал, монгол айлд хоносон нь миний сэтгэлд хоногшин үлдсэн шүү.

-Таны нэг өдрийн ажил хэрхэн өрнөдөг вэ?

-Би Лондоноос зайтай амьдардаг тул ажлаа өглөөний есөн цагаас хойш л эхэлдэг дээ. Гэр, ажлын хооронд хурдан галт тэргээр явна. Ажил дээрээ ихэвчлэн 21.00 цаг хүртэл суух ажиллах нь бий. Нөгөө талаас хуульчийн ажил их сонирхолтой. Өнөөдөр ямар шинэ ажил гарах вэ гэдгийг тааж мэдэшгүй. Шүүх хуралд оролцох, ажил хэрэгч уулзалт хийх, заримдаа тухайн асуудалтай холбоотойгоор судалгаа хийх гэхчлэн олон талтай байдаг. Өдөр бүр шинэ, сонирхолтой зүйлийг олж мэддэг. Мөн дэлхийн олон оронд очдог нь ажлын маань онцлог.

-Эрх зүйн салбарын үндсэн чиг үүрэг юу вэ?

-Хуульч бидний үндсэн чиг үүрэг үйлчлүүлэгчийнхээ бизнесийг эрсдэлээс хамгаалахад чиглэдэг. Бизнест олон янзын эрсдэл тулгарч болзошгүй. Жишээ нь байгуулсан гэрээ хэрэгжихгүй байх, ачуулсан бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт саатах, уул уурхайн лицензийг цуцлах гэх мэт. Хэдийгээр эдгээр нь үйлчлүүлэгчийн маань асуудал ч хуульч бидний үүрэг бол эдгээр асуудлыг хуулийн дагуу үйлчлүүлэгчдээ ашигтайгаар шийдвэрлэхэд оршино. Үүний тулд бид зүгээр нэг байгаа хуулийг тайлбарлаж өгөх биш, тухайн асуудлыг бүхэлд нь сайтар ойлгодог байх хэрэгтэй. Тиймээс ч бид тухайн үйлчлүүлэгчийн бизнес, түүний оршин байгаа орны нөхцөл байдал, хууль тогтоомжийг маш сайн судлахыг хичээдэг. Тэгж байж бүтээлч, үр өгөөж бүхий хуулийн зөвлөгөөг өгдөг. Эрх зүйн салбар бол маш том бизнес, тиймээс ч энэ салбарт ажиллагсдын сэтгэл ханамжийн баталгаа чухал байдаг. Хүн ажилдаа дуртай, сэтгэл хангалуун байж л ажлаа сайн хийнэ шүү дээ.

-Хуулийн сургууль дөнгөж төгссөн шинэхэн хуульчдад Та ямар зөвлөгөө өгөх вэ?

-Хуулийн сургуулийн шинэхэн төгсөгчийн хувьд хуульчийн карьерын давуу тал, мөн түүнчлэн бэрхшээл сорилын талаар зөв ойлголттой байх нь чухал. Мэдээж, онолын мэдлэгээс гадна хуулийг хэрэглэх сэтгэлгээ, аргыг мэдэх хэрэгтэй. Мөн эрх зүйн аль нэг салбарыг сонгохдоо тус салбартаа дур сонирхолтой байвал зохино. Зарим хуульчид гэр бүлийн, зарим нь үндсэн хууль, захиргааны, зарим нь бизнесийн эрх зүйд тус тус татагддаг. Аль ч салбарыг сонгосон, гол нь тухайн салбартаа дур сонирхолтой байх нь чухал. Гэхдээ хуульч хүн өөрийнх нь зөвлөгөө үйлчлүүлэгчид нь тус болоход хамгийн их сэтгэл ханамжтай байдаг гэж би боддог. Жишээ нь, шүүхэд заргаа авах нь ямар ч өмгөөлөгчид хамгийн том амжилт байдаг. Гэвч шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэх нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд тэр бүр нийцэхгүй байх тохиолдол амьдрал дээр гардаг. Иймд хуульчийн зөвлөгөө нь юуны түрүүнд үйлчлүүлэгчийн эрх ашигт л чиглэх нь хамгийн чухал.

-Таныг Лондон хотын шүүхээр нэгэн томоохон маргааныг хэлэлцэхэд өмгөөлөгчөөр оролцож, өөрийн үйлчлүүлэгчийн талд шийдвэрлүүлсэн гэж сонссон. Нууц биш бол энэ талаараа сонируулахгүй юу?

-Миний үйлчлүүлэгчийн эсрэг маш их хэмжээний нэхэмжлэлийг гаргасан юм. Нэхэмжлэл нь нэгэн Дундад Азийн улсын хөнгөн цагааны үйлдвэртэй холбоотой. Тодруулж хэлбэл, хөнгөн цагаан хайлуулах үйлдвэрт түүхий эд нийлүүлэх гэрээ, эцсийн бүтээгдэхүүнийг өмчлөх эрхээс үүдэн гарсан маргаан байв. Онцлог нь Лондон хотын шүүхээс гадна өөр хэд хэдэн орныг хамарсан “даяарчлагдсан” маргаан байсан. Жишээ нь, Лондоноос гадна, Москва, Швейцарь, Британийн Виржиний арлуудын шүүхээр уг маргаантай холбоотой бусад хэрэг, маргааныг хянан хэлэлцэж байсан. Уг маргаан гурван жил хагас гаруйн хугацаанд үргэлжилсэний эцэст шийдвэр манай үйлчлүүлэгчийн хувьд ашигтайгаар гарсан даа.

-Шүүхээр хэрэг маргаан шийдвэрлүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг бэлтгэхэд хэр их ажиллагаа ордог вэ?

-Бэлтгэл ажил тухайн хэргийн бүхий л асуудлыг ойлгох, хэрэгт хамааралтай бичиг баримтыг бүгдийг цуглуулахаас эхэлдэг. Ингэснээр тухайн хэрэг маргааны гарал үүсэл, нөхцөл байдлыг зөв ойлгож тогтоох боломжтой болно. Дараа нь шүүхэд гаргах үндэслэл тайлбараа бичгээр боловсруулна. Бас шүүхээр дамжуулан хэрэгт холбоотой эсрэг талын баримт материалыг авч сайтар судлах нь чухал. Түүнчлэн өөрийн үйлчлүүлэгчийн болон эсрэг талын гэрч нарын тайлбар, мэдүүлгийг авч судлах, шаардлагатай бол хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулах хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, шүүхээр орохоос өмнө их хэмжээний мэдээлэлтэй танилцаж боловсруулах шаардлагатай байдаг. Миний бодлоор нийт ажлын 90 хувийг шүүхээс өмнөх үе шатанд гүйцэтгэдэг. Үүнийг дутуу гүйцэтгэвэл шүүхийн шийдвэр эсрэг талд гарах магадлал тэр хэрээр улам нэмэгдэнэ.

-Гэрчийн мэдүүлэг буруу, эсхүл худал гэдгийг яаж мэддэг вэ?

-Зарим үед гэрчийн мэдүүлэг нь хэргийн материалтай зөрөх нь бий. Гэрч нар мэдүүлэгтээ зарим чухал зүйлийг дурдалгүй, эсвэл дутуу орхих нь бий. Иймд мэдүүлэгт дутуу орхигдсон тэр зүйлийг олж илрүүлэх, үүний тулд гэрчээс дахин мэдүүлэг авах шаардлагатай болдог. Түүнчлэн гэрчийг шүүх хурал дээр байцаана. Энэ бүхний эцэст шүүгч гэрч үнэнийг ярьж байгаа эсэхийг шийдвэрлэдэг.

-Хуульчийн хувьд прагматик байх нь хэр чухал вэ?

-Асуудалд прагматик хандах нь зайлшгүй чухал. Үйлчлүүлэгчийн хувьд өөрийн бизнесийг тогтвортой, ашигтай байлгах нь нэн чухал билээ. Тэгвэл аль нэг маргааныг шүүхээр хэлэлцүүлж ихээхэн цаг хугацаа, зардал чирэгдэл учруулахын оронд өөрийн үйлчлүүлэгч, эсрэг тал аль алинд нь хүлээж авахуйц шийдэлд хүрэх нь хамгийн ашигтай хувилбар байх нь амьдралд тохиолддог билээ.

-Та Монголд үйл ажиллагаа явуулахдаа ямар зарчим баримталдаг вэ?

-Манай компанийн хувьд бид уул уурхай, даатгал, санхүүгийн салбарт үйлчлүүлэгчидтэй. Бид Монголд үйл ажиллагаа явуулахдаа бусад оронд баримталдаг зарчмынхаа дагуу ажилладаг. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчийн эрх ашгийг нэгдүгээрт тавьж, Монгол Улсын бизнесийн орчинг ойлгох нь чухал гэж үздэг. Ингэснээр ямар гаргалгаа, ямар шийдэл нь илүү үр дүнтэй, талуудад илүү дөхөмтэй байх вэ гэдгийг олж харах юм.


“Clyde & Co” олон улсын хуулийн компани нь Монголын “Хаан Лекс Адвокатс” хуулийн компанитай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна. Ингэснээр бид одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгч нартаа Монгол болон өөр аль ч улсад англи, монгол хуульчдын үйлчилгээг хүргэх боломжтой болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бид хамтдаа хувийн хэвшилд ч, төрийн байгууллагад ч илүү үр өгөөж, цар хүрээтэй, хавсарсан үйлчилгээг үзүүлэх боломжтой болж байгаа гэсэн үг .

http://www.mongolianeconomy.mn

Бизнесийн завсарлага


Та ямар ном уншиж байгаа вэ?

М.Түвшинтөгс /Моннис группын Бизнес хөгжлийн газрын ерөнхий менежер/:



-Манай аав филисофийн багш хүн байсан болохоор багаасаа номтой нөхөрлөсөн. Энэ байдал миний хүмүүжил, хичээл сурлага, төлөвшилд маань нөлөөлсөн болов уу гэж боддог. Хүмүүс ихэнхдээ өөрөө аль болох сайн ажиллаж, хүүхдүүддээ боломжийн өв хөрөнгө үлдээхийг хүсдэг. Тиймээс ажил төрөлдөө ихэнх цагаа зарцуулж, хүүхдийнхээ хүмүүжилд тэр бүр анхаарч ямар хүн болж төлөвшиж буйг нь тоолгүй өмсөж зүүх, идэх уухаар л гачигдахгүй байвал болоо гэж үздэг. Миний бодлоор энэ нь тийм ч зөв хандлага биш. Харин хүүхдийнхээ оюуны чадавхыг багаас нь яаж хөгжүүлэхэд түлхүү анхаарах хэрэгтэй санагддаг. Нэг ёсондоо хүүхдээ их өв хөрөнгө өвлүүлэх биш, баялгийг өөрөө бүтээх чадамжтай хүн болгон төлөвшүүлэхийг хүсдэг. Энэ талаар байнга бодож явдаг. Тэгээд Сингапурт явж байхдаа номын дэлгүүрээс Тюрн Меллер “Оюун ухаанаа хэрхэн хөгжүүлэх вэ” гэсэн номыг худалдаж авсан. Тус номын гол санааг үндэсний уламжлалтайгаа хослуулан хүүхдээ хүмүүжүүлэхийг хичээдэг. Тус номонд өгүүлснээр 0-3 насанд хүүхдийн тархины эд эс нь хөгжиж, юманд хандах цаашдын хандлага нь тогтдог учраас хамгийн эгзэгтэй үе аж. Тиймээс энэ үед нь тохирсон танин мэдэхүйн тоглоомыг тоглож, аливаа зүйлийг аль болох утга учрыг нь тайлбарлаж ойлгуулах нь чухал гэдгийг онцолсон байсан. Мөн нас насанд нь тохирсон тоглоом, оюун ухааны дасгалуудыг зааварчилсан нь их таалагдсан. Тиймээс залуу эцэг, эхчүүдийн заавал унших номын нэг гэж бодож байна.

З.Энхболд /Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Төрийн захиргаа удирдлагын газрын дарга/:



-БНСУ-ын ерөнхийлөгч И Мён Багийн “Ажлаар амьсгалсан он жилүүд” ном надад олон ухаарал, амьдралын шинэ эрч хүчийг өгсөн. Хүний өөрийн хичээл зүтгэл, тэмүүллээс шалтгаалж амьдрал ирээдүй нь бий болдог юм гэдгийг өөрийн биеэр зохиогч нь тод харуулсан. Тус номонд дайны үеийн нэн ядуу, тарчиг амьдралаас ямар хүнд хэцүү замыг туулж, тэмцэж байж үндэсний том компанийн захирал, улсынхаа ерөнхийлөгч болох хүртэлх замаа их сонирхолтой, сургамжтайгаар гаргаж ирсэн санагддаг. Нөгөө талаас БНСУ-ын хөгжил ямар хүнд хэцүү түвшнээс шаргуу хөдөлмөрлөж, бүтээн босголтын томоохон хөрөнгийг дотоод, гадаадын зах зээлээсээ нэгтгэн гаргаж чадсаныг харуулсан. Тиймээс бид ч үүнээс суралцах хэрэгтэй. Манай компаниуд өөрсдийн багахан хөрөнгөнийхөө төлөө биш дэлхийн хэмжээнд гарч өрсөлдөх цаг ирсэн гэж боддог. Тиймээс номон дээр гарч байгаа үзэл санааг хувь хүн өөр дээрээ тусгаж, нөгөө талаас улстөрчид ч үүнээс суралцаасай гэж бодож байна.

М.Чимэддорж /Монголын үндэсний зөвлөхүүдийн холбооны удирдах зөвлөлийн дарга/:



-Хүнамьдраххугацаандаяамагтлсуралцаж байдаг. Үүний нэг чухал эх сурвалжийг ном гэж хэлж болно. Надад хүн болох ухаан, юу зөв, юу буруу гэдгийг ойлгуулсан ном бол Сажаа Балжид Гунгаажалцан гэдэг хүн зохиож, Ц.Дамдинсүрэн монгол хэлнээ хөрвүүлсэн “Эрдэнийн сан субашид” юм. Энэ номыг хүүхэд байхдаа уншсан. Ялангуяа тайлбар үлгэрүүдийг нь уншиж их дуртай байсан. Бүүр сүүлд ч бас уншсан. Амьдралын олон ойлголтыг сургаал хэлбэрээр шүлэглэсэн учраас бадаг бүр нь нэг цогц санааг илэрхийлдэг. Ер нь хүн бүхний уншиж ёстой ном гэж боддог. Ялангуяа хүүхдүүдэд уншуулбал хүмүүжил, төлөвшилд сайнаар нөлөөлөх байх. Тухайлбал дөрвөн мөртийг нь хэлж сонирхуулъя.

Ухаантан мэргэд хэдий эрдэмтэй боловч
Улам улам мэргэшихийн тулд ном судар цуглуул юу
Урсах мөрөн бүгд уламжлан дамжсаар
Усны сан болсон их далайд цутгах адил ■